ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРЭЭР ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДАД ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТЭД 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

2023.02.09 Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, яамны удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ыг баримталсан болно.

## ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын 9 хуулийн 70 заалт, Улсын Их Хурлын 4 тогтоолын 8 заалт, Ерөнхийлөгчийн 5 зарлигийн 7 заалт, Улсын Их Хурлын Байнгын хорооны 2 тогтоолын 2 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 зөвлөмжийн 2 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1 хуралдааны 4 заалт, Ерөнхий сайдын захирамж 1 , Засгийн газрын 24 тогтоолын 39 заалт, Засгийн газрын хуралдааны 36 тэмдэглэлийн 75 заалт, Засгийн газрын 5 албан даалгаврын 6 заалт буюу нийт 89 шийдвэрийн 214 заалтыг хяналтад авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Бүрэн хэрэгжсэн 128, хэрэгжих шатанд/дуусаагүй 70%-ийн хэрэгжилттэй 51, хэрэгжилт хангалтгүй буюу 30%-ийн хэрэгжилттэй 15, хугацаа болоогүй-21, хэрэгжилтийн дундаж **86.7%**-тай дүгнэв.

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нэгдсэн дүн**
**/**Хууль тогтоомжийн төрлөөр**/**

Хүснэгт №1

| № | Шийдвэрийн нэр, төрөл | Шийдвэрийн | | Хэрэгжилтийн үнэлгээ/хувь/ | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тоо | заалт | 100 | 70 | 30 | 0 | Хугацаа болоогүй | Хувь |
| 1 | Монгол Улсын хууль | 9 | 70 | 46 | 2 | 8 | - | 14 | 88.9 |
| 2 | Улсын Их Хурлын тогтоол | 4 | 8 | 3 | 3 | 2 | - | - | 71.2 |
| 3 | УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 2 | 2 | 1 | 1 | - | - | - | 85.0 |
| 4 | Ерөнхийлөгчийн зарлиг | 5 | 7 | 7 | - | - | - | - | 100 |
| 5 | ҮАБЗ-ийн зөвлөмж | 2 | 2 | 2 | - | - | - | - | 100 |
| 6 | ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл | 1 | 4 | 3 | 1 | - | - | - | 92.5 |
| 7 | Ерөнхий сайдын захирамж | 1 | 1 | 1 | - | - | - | - | 100 |
| 8 | Засгийн газрын тогтоол | 24 | 39 | 17 | 17 | 1 | - | 4 | 83.4 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 36 | 75 | 45 | 24 | 4 | - | 3 | 86.3 |
| 10 | Засгийн газрын албан даалгавар | 5 | 6 | 3 | 3 | - | - | - | 85.0 |
| Нийт | | **89** | **214** | **128** | **51** | **15** | **-** | **21** | **86.7** |

Газар, нэгж тус бүрийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
Хүснэгт 2

| **№** | **Газрын нэрс** | **Нийт заалт** | **Үүнээс /хувиар/** | | | | | **Биелэлт хувь** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **100** | **70** | **30** | **0** | **Хугацаа болоогүй** | |
| 1 | ТЗУГ | 34 | 23 | 7 | - | - | 4 | **93.0** |
| 2 | ХШҮДАГ | 11 | 6 | 5 | - | - | - | **86.4** |
| 3 | БТГ | 42 | 19 | 15 | 4 | - | 4 | **80.8** |
| 4 | АЗБХЗГ | 47 | 22 | 14 | 5 | 2 | 4 | **77.4** |
| 5 | АТБХЗГ | 26 | 13 | 9 | 2 | - | 2 | **82.9** |
| 6 | ТЗДТБХЗГ | 65 | 28 | 26 | 8 | - | 3 | **78.4** |
| 7 | ИНБХЗГ | 22 | 7 | 12 | 2 | - | 1 | **76.2** |
| 8 | СХГ | 1 | - | - | - | - | 1 | **-** |
| 9 | ИНЕГ | 6 | 2 | 2 | 1 | - | 1 | **74.0** |
| 10 | ЗТХТ | 3 | - | 1 | 1 | - | 1 | **50.0** |
| 11 | АТҮТ | 3 | - | 1 | 1 | - | 1 | **50.0** |
| 12 | ГТХЗНТ | 3 | 1 | 1 | - | - | 1 | **85.0** |
| 13 | МИАТ | 3 | 1 | 1 | - | - | 1 | **85.0** |
| 14 | УБТЗ | 4 | 2 | 1 | - | - | 1 | **90.0** |
| 15 | МТЗ | 10 | 1 | 6 | 2 | - | 1 | **64.4** |
| 16 | Далайн захиргаа | 9 | - | - | 4 | 3 | 2 | **17.1** |
| 17 | ТТЗ | 4 | 3 | 1 | - | - | - | **92.5** |
| 18 | ХХНОБ | 4 | - | 2 | 1 | - | - | **56.7** |

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний нэгтгэл**
/Салбар, салбараар/
Хүснэгт 3

| **Салбар, чиглэлийн нэр** | **Хяналтад авсан тоо** | | **Хэрэгжилтийн явц** | | | | | **Хувь** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Шийдвэр | Заалт | 100% | 70% | 30% | 0% | Хугацаа болоогүй | |
| **1. Авто замын салбар** | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 1 | 4 | 4 | - | - | - | - | 100.0 |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 1 | 1 | - | 1 | - | - | - | 70.0 |
| Ерөнхий сайдын захирамж | 1 | 1 | 1 | - | - | - | - | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 8 | 9 | 4 | 2 | - | - | 3 | 90.0 |
| Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 12 | 18 | 10 | 5 | 3 | - | - | 80.0 |
| Засгийн газрын албан даалгавар | 1 | 1 | - | 1 | - | - | - | 70.0 |
| Хэрэгжилтийн дундаж | 24 | 34 | 19 | 9 | 3 | - | 3 | 84.5 |
| **2. Төмөр замын салбар** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Улсын Их Хурлын тогтоол | 1 | 2 | 2 | - | - | - | - | 100.0 |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 1 | 1 | 1 | - | - | - | - | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 9 | 22 | 8 | 13 | 1 | - | - | 79.0 |
| Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 9 | 14 | 10 | 4 | - | - | - | 91.4 |
| Хэрэгжилтийн дундаж | 20 | 39 | 21 | 17 | 1 | - | - | 85.1 |
| **3. Автотээврийн салбар** | | | | | | | | |
| Улсын Их Хурлын тогтоол | 1 | 1 | - | - | 1 | - | - | 30.0 |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | 1 | 1 | 1 | - | - | - | - | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 2 | 2 | 1 | 1 | - | - | - | 70.0 |
| Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 8 | 14 | 8 | 4 | 1 | - | 1 | 85.3 |
| Хэрэгжилтийн дундаж | 12 | 18 | 10 | 5 | 2 | - | 1 | 82.9 |
| **4. Иргэний нисэхийн салбар** | | | | | | | | |
| Улсын Их Хурлын тогтоол | 1 | 2 | - | 1 | 1 | - | - | 50.0 |
| ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл | 1 | 1 | - | 1 | - | - | - | 70.0 |
| Засгийн газрын тогтоол | 2 | 2 | 1 | - | - | - | 1 | 100.0 |
| Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 6 | 9 | 5 | 4 | - | - | - | 86.6 |
| Засгийн газрын албан даалгавар | 1 | 1 | - | 1 | - | - | - | 70.0 |
| Хэрэгжилтийн дундаж | 11 | 15 | 6 | 7 | 1 | - | 1 | 80.0 |
| **5. Усан замын салбар** | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 2 | 14 | 2 | - | 7 | - | 5 | 45.5 |
| **6. Нийтлэг асуудал** | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 5 | 52 | 40 | 2 | 1 | - | 9 | 96.9 |
| УИХ-ын тогтоол | 3 | 3 | 1 | 2 | - | - | - | 80.0 |
| Ерөнхийлөгчийн зарлиг | 5 | 7 | 7 | - | - | - | - | 100.0 |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | 1 | 1 | 1 | - | - | - | - | 100.0 |
| ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл | 1 | 4 | 3 | 1 | - | - | - | 92.5 |
| Засгийн газрын тогтоол | 4 | 4 | 3 | 1 | - | - | - | 92.5 |
| Засгийн газрын албан даалгавар | 3 | 4 | 3 | 1 | - | - | - | 92.5 |
| Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 15 | 20 | 12 | 7 | - | - | 1 | 88.9 |
| Хэрэгжилтийн дундаж | 37 | 95 | 70 | 14 | 1 | - | 10 | 94.2 |

## Гурав. Дүгнэлт

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 10 төрлийн 89 шийдвэрийн 214 заалтаас бүрэн хэрэгжсэн 128, хэрэгжих шатанд/дуусаагүй 70%-ийн хэрэгжилттэй 51, хэрэгжилт хангалтгүй буюу 30%-ийн хэрэгжилттэй 15, хугацаа болоогүй/үнэлээгүй-21, хэрэгжилтийн дундаж 86.7%-тай дүгнэгдэв. Энэ нь 2022 оны хагас жилийн 82.2% дүнтэй харьцуулахад 4.5%-иар өссөн үзүүлэлттэй байна.

2. Нийт 15 зүйл, заалтыг “хэрэгжилт хангалтгүй” буюу 30% гэж дүгнэсэн ба салбар чиглэлээр авч үзвэл дараах байна. Үүнд:
   - Усан замын салбар/Далай ашиглах тухай хууль/ - 7;
   - Авто замын салбар – 3;
   - Автотээврийн салбар- 2;
   - Иргэний нисэхийн салбар – 1;
   - Төмөр замын салбар -1
   - Нийтлэг асуудал -1.

3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 214 зүйл, заалтаас бүрэн хэрэгжсэн, нэг удаагийн буюу цаг үеийн шинжтэй, тус яамны чиг үүрэгт хамаарахгүй зэрэг 93 заалтыг хяналтаас хасуулах саналыг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн системд оруулав.

**Дөрөв. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж**

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа ажлын гол үр дүнг товч тодорхой (хоёр мянган тэмдэгтэд багтаан), бодлогын баримт бичгүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлттэй уялдуулан баримт нотолгоог хавсарган тайлагнах.

2. Төрийн захиргааны удирдлагын газраас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг (дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж) нэгтгэн боловсруулж, хэрэгжилтийг оновчтой, хүрсэн үр дүнг холбогдох шийдвэр, албан бичгийн огноо, дугаарыг тодорхой бичүүлэх .

3. Хэрэгжилт хангалтгүй дүгнэгдсэн ажлуудыг эрчимжүүлж, 2023 оны хагас жилээр хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг холбогдох нэгжүүд авч хэрэгжүүлэх.

---o0o---

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

/2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС/

| № | Шийдвэрийн огноо, дугаар | Зүйл, заалт | Хэрэгжилт | Үнэлгээ | Хяналтаас хасуулах санал |
|---|---|---|---|---|---|
| | | | **1. Авто замын салбар** | | |
| | | | 1а. Монгол Улсын хууль | | |
| 1 | **Авто замын тухай /Шинэчилсэн найруулга/ 2017.07.01** | 9.1.1.. Монгол Улсын авто замын салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг баталж, хэрэгжүүлэх, хяналт тавих; (9.1.Засгийн газар авто замын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Монгол Улсын авто замын салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг баталж, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын хүрээнд 2020.05.07-ны өдөр батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5.3-д “Эдийн засаг болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр” болох “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан. Уг бодлого 10 жилийн хугацаанд хэрэгжих ба тус салбарын 42 төслийн 17 нь авто замын салбарын төсөл, арга хэмжээ батлагдсан. | 100% | 2020 онд батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасан "Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ыг хэрэгжүүлэх Шинэ сэргэлтийн бодлого батлагдсан тул хяналтаас хасуулах |
| 2 | | 9.1.3.. Авто замын үндэсний сүлжээг хөгжүүлэх бодлогыг батлах; | Монгол Улсын авто замын салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг баталж, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын хүрээнд 2020.05.07-ны өдөр батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5.3-д “Эдийн засаг болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр” болох “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан. Уг бодлого 10 жилийн хугацаанд хэрэгжих ба тус салбарын 42 төслийн 17 нь авто замын салбарын төсөл, арга хэмжээ батлагдсан. | 100% | 2020 онд батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасан "Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ыг хэрэгжүүлэх Шинэ сэргэлтийн бодлого батлагдсан тул хяналтаас хасуулах |
| 3 | | 6.3.. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хөрөнгө оруулалтаар баригдах | Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын 2- | 100% | Жагсаалт батлагдсан тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | авто зам, замын байгууламжийн жагсаалтыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална. | т Авто замын төслүүд батлагдсан ба 15 төсөл хэрэгжсэн байна. | | |
| 4 | | 22.8.. Авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэх норм, норматив болон журмыг санхүү, төсвийн болон авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. | "Авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэх журам"-ыг Сангийн сайд, Зам тээврийн хөгжлийн сайдын 2020.08.20-ны 154/А159 дугаар хамтарсан тушаалаар баталсан. | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах. |
| **1б. УИХ-ын Байнгын хорооны тогтоол** | | | | | |
| 5 | **2022 №03 АБГББХ. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай** | 1.10. Газрын тосны экспортын тээвэрлэлтийг шороон замаар хийж байгаагийн улмаас тухайн орон нутгийн байгаль орчин, бэлчээр ихээр сүйдэж, тоосжилт үүсч байгаа тул хатуу хучилттай автозамын барилгын ажлыг яаралтай дуусгах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авах; | Дорнод аймгийн Халхгол сумын нутагт Өмнөд Буйрын 21 дүгээр талбайгаас Тосон-Уул-Баянхошуу чиглэлийн авто замтай холбох 58.5 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр "Их Монгол Барилга" ХХК шалгаран Захиалагч "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэж байна. Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 03/3723 тоот албан бичгээр авто замын барилгын ажлыг эрчимжүүлж, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “Их Монгол Барилга” ХХК-д мэдэгдсэн. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-аас 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 22/1-1152 тоот албан бичигтээ “тус компанийн зүгээс зам барилгын ажлыг дуусгах талаар ихээхэн ач холбогдол өгч, Ерөнхийлөгчөөрөө ахлуулсан ажлын хэсэг байгуулж, бүх талын дэмжлэг үзүүлэн ажилласны үр дүнд 30 км авто замыг хучиж, нийт ажлын 80 хувийг хийж, гүйцэтгэсэн тухай дурдсан. Асфальтбетон хучилтыг намар +10-аас доош, салхины хурд 10м/сек-ээс дээш үед дэвсэхгүй, | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хольцын орц норм, дэвсэх үеийн стандарт, техник, технологийн шаардлагыг дагуу гүйцэтгэх ёстой тул барилгын ажил 2022 оны өвлийн улиралд хийгдээгүй байна. | | |
| | | **1в.Засгийн газрын тогтоол** | | | |
| 6 | **2021_130. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай / 2021-05-05** | 2. Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 361 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол"-ын 61 дэх заалтын дараа хавсралтад дурдсан агуулгатай 62-76 дахь заалтыг нэмсүгэй. 2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлагдсаны дагуу Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацыг ашиглаж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2022 оны 10 сарын 30-ны өдөр нээсэн. Хэрэгжилтэд байнгын хяналтыг газар дээр нь Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар 2022 оны 08 сараас эхлэн 11 сарын 10 хүртэл тавьж ажилласан. Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол"-д Засгийн газрын 2022 оны 176 болон 273 дугаар тогтоолоор тус тус нэмэлт орсон. | 100% | Түгээмэл тархацыг ашиглан, УБ-Дархан чиглэлийн 202.4 км авто замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нээсэн тул хяналтаас хасуулах. |
| 7 | **2021_293. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах талбайн солбицлыг батлах тухай** | 2. Азийн хөгжлийн банкны МОН-3679/3786 зээлийн хөрөнгөөр "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"-ийн хүрээнд хэрэгжих Хүйтэний хөндий-Арвайхээр чиглэлийн 57.56 км авто замын шинэчлэл, их засварын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол | Хүйтний хөндий -Арвайхээр чиглэлийн 57.56 км авто замын шинэчлэлт, их засварын ажилд ашиглагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг Засгийн газрын тогтоолын хавсралтаар батлагдсан солбицол бүхий талбайгаас ашиглаж, замын шинэчлэл их засварын ажлыг дуусган тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2022 оны 11 дүгээр сард нээн, Улсын комисс ажилласан. Түгээмэл тархацтай ашигт малтмал авсан карьерийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж, гүйцэтгэсэн. | 100% | хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Өвөрхангай аймгийн Засаг дарга А.Ишдорж, авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | | | |
| 8 | **2022_165. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай / 2022-04-20 /** | 2. “Олон улс, улсын чанартай зам барих” төслийн хүрээнд хэрэгжих Дархан-Алтанбулагийн замаас Сэлэнгэ аймгийн Шаамар сум-Зэлтэрийн боомт чиглэлийн 120,85 км хатуу хучилттай авто замын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд | Дархан-Алтанбулагийн замаас Сэлэнгэ аймгийн Шаамар сум-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто замын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлуулж, Сэлэнгэ аймгийн Засаг даргад авто замын барилгын ажил гүйцэтгэж буй хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгох эрхийг Засгийн газрын тогтоолоор баталгаажуулж, дэмжлэг үзүүлж ажилласан. | 100% | Дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | | | |
| 9 | | 3. Авто замын барилгын ажил дууссаны дараа ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг авто замын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд үүрэг болгосугай. | Авто замын барилгын ажил дуусаагүй, нөхөн сэргээлт хийх хугацаа болоогүй. | Хугацаа болоогүй | түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг баталсан тогтоолын нөхөн сэргээлтийг зохих ёсоор гүйцэтгүүлж, хэрэгжилтэд хяналтад тавих заалтыг дотоод хяналтад авч, ЗГХШМС-ийн хяналтаас хасуулах |
| 10 | **2022_166. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай / 2022-04-20 /** | 4. Авто замын барилгын ажил дууссаны дараа ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг авто замын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд үүрэг болгосугай. 4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасугай | "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл"-ийн Хөвсгөл дэд төслийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам 37.9 км хатуу хучилттай авто замын төслийг ажлыг хэрэгжүүлж байна. Зам, тээврийн хөгжлийн яамнаас авто замын барилгын ажилд дэмжлэг үзүүлж, түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлуулан, дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Барилгын ажил дуусаагүй байгаа тул нөхөн сэргээлт хийх хугацаа болоогүй. | Хугацаа болоогүй | түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг баталсан тогтоолын хэрэгжилтэд хяналтад тавих заалтыг дотоод хяналтад авч, ЗГХШМС-ийн хяналтаас хасуулах |
| 11 | **2022_176. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай / 2022-04-27 /** | 2. Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 361 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлагдсаны дагуу Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацыг ашиглаж, хэрэгжилтэд байнгын хяналтыг газар дээр нь Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар 2022 оны 08 сараас эхлэн 11 сарын 10 хүртэл тавьж ажилласан. Үүний үр дүнд | 100% | хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | талбайн солбицол”-ын 76 дахь заалтын дараа хавсралтад дурдсан агуулгатай 77-91 дэх заалтыг нэмсугэй. 2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2022 оны 10 сарын 30-ны өдөр нээсэн. | | |
| 12 | **2022_195. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай / 2022-05-11 /** | 4. Авто зам, талбайн барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг авто замын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд үүрэг болгосугай. 4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд тус тус даалгасугай. | Авто замын барилгын ажил үргэлжилж байна. Хугацаа болоогүй | Хугацаа болоогүй | түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, талбайн солбицол баталсан тогтоолын хүрээнд авто замын барилгын ажил дууссаны дараа нөхөн сэргээлтийн ажил хийгддэг тул уг заалтуудыг ЗГХШМС-ийн хяналтаас хасуулж, дотоод хяналтад авах |
| 13 | **2022_273. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай / 2022-07-05 /** | 2. Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 361 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол”-ын 91 дэх заалтын дараа хавсралтад дурдсан агуулгатай 92-103 дахь заалт нэмсугэй. 2. Энэ тогтоолын | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлагдсаны дагуу Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацыг ашиглаж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2022 оны 10 сарын 30-ны өдөр нээсэн. Хэрэгжилтэд байнгын хяналтыг газар дээр нь Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар 2022 оны 08 сараас эхлэн 11 сарын 10 хүртэл тавьж ажилласан. | 70% | Дотоод хяналтад авч, ЗГХШМС-ийн хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | | | |
| 14 | **2022_442. Төслийн жагсаалт шинэчлэн батлах тухай / 2022-12-07 /** | 2. Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд 2019 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр байгуулсан Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд 300 сая ам.доллартой тэнцэх зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. 2. Энэ тогтоолын хавсралтад заасан төслийг хэрэгжүүлэх талаар Европын сэргээн босголт, хөгжлийн банктай тохиролцож, холбогдох гэрээ хэлэлцээрийг байгуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд, төслийг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд тус тус даалгасугай. | Уг жагсаалтаар "УБ-Дарханы замд нэмэлт 2 эгнээ барих" төслийн нэмэлт санхүүжилт 20 сая ам.долларын санхүүжилтийг ЕСБХБ-ны зээлийн хөрөнгөөр шийдвэрлэхээр болсон ба Сангийн яамнаас ЕСБХБ-тай байгуулах зээлийн хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанд оруулах ажлыг зохион байгуулж байна. Энэхүү ЗГ-ын хуралдаанаар оруулах төсөлд холбогдох саналыг 2023.01.16-ны өдөр Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд тухайн зээлийн хэлэлцээрийг санхүүжүүлэгч банктай байгуулахад Сангийн яаманд дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна. Тус зээлийн хэлэлцээр байгуулагдсаны дараагаар одоогийн гүйцэтгэгч байгууллагуудтай нэмэлт гэрээ байгуулах, нэмэлтээр хийгдэх 5 см хучилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаар хөрөнгө оруулагч банкны холбогдох журмын дагуу зохион байгуулж, гэрээ байгуулах арга хэмжээг авна. | 70% | |
| **1Г. Ерөнхий сайдын захирамж** | | | | | |
| 15 | **2022_14. Ажлын хэсэг байгуулах тухай / 2022-02-08 /** | 2. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлж, шуурхай арга хэмжээг тухай бүр авч, дэмжлэг үзүүлж ажиллах Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй | Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын бүтээн байгуулалтын ажлыг 2022 оны 05 сараас 08 сар хүртэл Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Ж.Бат-Эрдэнэ, 2022 оны 08 сараас 11 сарын 10 хүртэл Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар нар авто замын барилгын ажил гүйцэтгэж буй талбайд тухай бүр ажиллан шуурхай удирдлагаар ханган ажилласнаар | 100% | Ажлын хэсэг явц үр дүн, шаардлагатай арга хэмжээний талаар Засгийн газарт танилцуулсан тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгуулсугай: Ажлын хэсгийн удирдамжийг хавсралт ёсоор баталсугай. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын барилгын ажлын явц, үр дүнг улирал бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байх. | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөр нээсэн. Энэ хугацаанд Засгийн газрын 2022 оны 176 болон 273 дугаар тогтоолуудаар авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардлагатай түгээмэл тархац ашиглах, талбайн солбицолыг тус тус батлуулж ажилласан. 2022 оны 442 дугаар тогтоолоор "УБ-Дарханы замд нэмэлт 2 эгнээ барих" төслийн нэмэлт санхүүжилт 20 сая ам.долларын санхүүжилтийг ЕСБХБ-ны зээлийн хөрөнгөөр шийдвэрлэх арга хэмжээний жагсаалтад тусгуулсан. | | |
| **1г. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 16 | **2021_15. 2021 оны 3 дугаар сарын 5-ны өдөр 15 дугаар тэмдэглэл / 2021-03-05 /** | III.1. “Авто замын салбарт хэрэгжүүлэх томоохон бүтээн байгуулалтын төслүүдийн явц, тэдгээрт шаардлагатай хөрөнгийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Авто замын салбарт хэрэгжүүлэх томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийн талаар судалж, хууль тогтоомжийн хүрээнд үе шаттайгаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгав. | Авто замын салбарт хэрэгжүүлэх томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын 2023 оны төсөвт тусгуулсан. Засгийн газрын 2022 оны 233 дугаар тогтоолоор УБ-Мандалговь чиглэлийн 305 км авто замын засвар арчлалтын ажилд шаардлагатай хөрөнгийг Эрдэнэс таван толгой ХК-аас гаргуулахаар шийдвэрлэж, засварын ажлыг 2 АЗЗА компани бүрэн хийж гүйцэтгэсэн. Улаанбаатар-Дархан чиглэлийн нэмэлт 2 эгнээ барих төслийн нэмэлт 20 сая долларын санхүүжилтийг Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны хооронд байгуулсан хэлэлцээрийн хүрээнд шийдвэрлэхээр Засгийн газрын 2022 оны 442 дугаар тогтоолоор батлагдсан арга хэмжээний жагсаалтад тусгуулсан. | 100% | |
| 17 | **2022_17. 2022 оны 3 дугаар** | IX.4.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын боомтын сэргэлтийн | Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8км авто замын барилгын ажил дуусч, 2022.10.29-ний өдөр | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **сарын 23-ны өдөр 17 дугаар тэмдэглэл / 2022-03-23 /** | хүрээнд Цагааннуур, Даянгийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, эдгээр боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт; | ашиглалтад оруулсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 17 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн чиглэлийн дагуу Даян боомт чиглэлийн авто замын маршрутын судалгаа болон зураг төсөл боловсруулах зардлыг тооцоог гарган Барилга хот байгуулалтын яаманд 2022.04.14-ны өдрийн "Санхүүжилт шийдвэрлүүлэх тухай" 01/1632 дугаартай албан тоотыг хүргүүлсэн. | | |
| 18 | **2022_24. 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл / 2022-04-20 /** | XIY.11.4. Авто замын барилгын ажилд ашиглаж байгаа түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газрыг нөхөн сэргээхэд анхаарах, түр замыг сайжруулж, иргэд аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт даалгав; | Авто замын барилгын ажилд ашиглаж байгаа түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газрыг нөхөн сэргээхэд хяналт тавьж, түр замын засвар арчлалтыг тогтмол гүйцэтгүүлж, иргэд аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөр бүрэн нээсэн. | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах, цаашид түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах эрх олгосон заалтыг дотоод хяналтад авч байх саналтай |
| 19 | **2022_25. 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 25 дугаар тэмдэглэл / 2022-04-27 /** | XY.2. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын барилгын ажилд байнгын хяналт тавьж ажиллах Ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн дэд сайдаар ахлуулан байгуулж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт даалгав. | Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын барилгын ажилд байнгын хяналт тавьж, барилгын ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтийг шуурхай хангахад дэмжлэг үзүүлэх, удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/140 тушаалаар байгуулсан байгуулсан. Зам, тээврийн хөгжлийн дэд сайдын дэд сайдаар ахлуулсан хэсгийн гишүүд нь өөрсдийн эрхлэх асуудлын чиг үүргийн хүрээнд дараах чиглэлийг баримтлан ажилласан бөгөөд ажлын явцын үр дүнг Засгийн газрын хуралдаанд тухай бүр танилцуулж ажилласан. Үүнд: 1. Азийн хөгжлийн банк болон Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын нийт 10 багц төслийн зам барилгын | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажлын гүйцэтгэлд өөрсдийн эрхлэх асуудлын хүрээнд өдөр тутмын байнгын хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>2. Зам барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай гүйцэтгэгч болон зөвлөх байгууллагын гадаадаас оруулж ирэх ажиллах хүч, мэргэжилтэнг Монгол Улсад иргүүлж, ажлын талбайд ажиллуулах асуудлыг шуурхай зохион байгуулж шийдсэн.<br>3. Төсөлд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгох асуудлыг Засгийн газрын түвшинд шуурхай шийдвэрлүүлсэн.<br>4. Авто замын бүтээн байгуулалтын ажлыг тасралтгүй, хэвийн үргэлжлэхэд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авах, төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллага хоорондын уялдааг хангаж ажилласан.<br>5. Зам барилгын ажилд ашиглагдах импортоор оруулж ирэх бараа материал, техник, тоног төхөөрөмжийг хил, гаалиар саадгүй шуурхай нэвтрүүлж, ажлын талбайд саатал, хүлээлт үүсгэхгүй байх зохион байгуулалтыг арга хэмжээг авч ажилласнаар 2022.10.30-ны өдөр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн. | | |
| 20 | **2022_28. 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл / 2022-05-11 /** | XYI.10. Дорноговь аймгийн Сайншанд хотоос Ханги хилийн боомт хүртэл хатуу хучилттай авто зам тавих асуудлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх боломжийг судалж, танилцуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт; | Сайншанд хотоос Ханги боомт чиглэлтэй үндсэндээ давхцаж буй Зүүнбаян-Ханги чиглэлийн 226.9 км төмөр замыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барьж, 2022.11.25-ны өдөр нээлтээ хийсэн. Сайншанд хотоос Ханги боомт чиглэлд төмөр замтай зэрэгцэн авто машинаар тээвэрлэлт хийх эрэлт, хэрэгцээ маш бага бөгөөд авто тээврийн тариф 4-5 дахин өндөр, хөрөнгө оруулалтын хувьд үр ашиггүй тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах боломжгүй юм. | 30% | Концессын тухай хуулийн дагуу төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар зардал, ашгийн тооцоо ашигтай гарвал хөрөнгө оруулалт татах боломжтой гэж үзэх тул одоогийн түвшинд төмөр замтай зэрэгцэн авто замаар тээвэр хийх тариф өндөр, үр ашиггүй |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | гэж үзэж байгаа тул хяналтаас хасуулах |
| 21 | | XYI.11. Цагаандэл-Уул боомтын нөлөөллийн бүсийн иргэдэд боомт нээгдэж, авто зам тавигдсанаар сум, орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох боломж бүрдэж иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэгт эерэг нөлөө үзүүлэх талаар таниулга, сурталчилгаа хийж, тохиролцоонд хүрэх ажлыг зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж нарт; | Ерөнхий сайд 2022.05.26-наас 27-ны өдрүүдэд Өмнөговьд ажилласан бөгөөд ард иргэдийн шаардлага, хүсэлтийн дагуу Цагаандэл-Уул боомт нээхээр шийдвэрлэсэн Засгийн газрын 2014 оны 46 дугаар тогтоолыг түдгэлзүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэр гаргаж байгаагаа мэдэгдсэн. Засгийн газрын 2022.05.31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Цагаандэл Уул боомтын асуудлыг Өмнийн говийн хөгжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн санал, дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан даалгасан. Мөн Ерөнхий сайдын 2022.07.20-ны өдрийн 107 дугаар захирамжаар Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагын дарга нараас бүрдсэн Цагаандэл-Уул боомтыг нээн ажиллуулахад тулгамдаж буй асуудлыг судалж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. | 30% | Цагаандэл-Уул боомт үйл ажиллагаа орон нутгийн иргэдийн шаардлагаар зогссон тул хяналтаас хасуулах |
| 22 | | XX.3.1.2. Таван толгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын чиг (трасс)-ийн давхцлын асуудлыг судалж, шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | Тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу тус яамнаас 03/3909 тоот албан бичгээр авто замын трассыг өөрчлөхдөө ашиглалтын зөвшөөрөл эзэмшигч "Манлай энержи" ХХК-тай зөвшилцөлгүйгээр ашиглалтын талбайг дайруулсан талаарх тайлбар ирүүлэхийг "Тахилт хайрхан транс "ХХК-д, хувийг концессын гэрээний тал болох ЭЗХЯ, хяналт хэрэгжүүлж буй Зөвлөх "Эм Си Пи Си ЖИ Ар" ХХК-д мэдэгдсэн. Концесс эзэмшигчээс замын трассыг өөрчлөх хайгуул, судалгаа хийж, хувилбар гаргасан бөгөөд уг хувилбараар сум орон нутгийн удирдлагатай зөвшилцсөн хариу өгсөн. Үүний дагуу ашиглалтын талбайн хэмжээнд | 70% | Засгийн газрын 2022.08.03-ны өдрийн 39 дүгээр тэмдэглэлээр дээрх заалттай ижил үүрэг өгсөн тул хяналтаас хасуулах, Мөн тус яамнаас эрхлэх асуудлын хүрээнд арга хэмжээ авсан ба трассын давхцалыг чиг үүргийн дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | өөрчлөлт оруулах асуудлыг судлан үзэж, трассын давхцалыг шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 03/04 тоот албан бичгээр хүргүүлсэн. | | шийдвэрлэх тул хяналтаас хасуулах. |
| 23 | **2022_28. 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл / 2022-05-11 /** | XX.3.1.5. Цагаандэл-Уул боомт, авто замын бүтээн байгуулалтын нөлөөллийн бүсэд хамаарч буй орон нутгийн иргэдэд хөгжлийн төслийн бүтээн байгуулалт, ач холбогдлын талаар таниулах, нөхөн олговрын асуудлыг авто замын төслийн концесс эзэмшигч аж ахуйн нэгжтэй хамтран тохиролцож, шийдвэрлэхийг Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт; | Тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу Өмнөговь аймгийн Засаг даргын тушаалаар тус аймгийн Засаг даргын Тамгын газар болон концесс эзэмшигчийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг 2022.05.23-ны өдөр замын дагуу явж малчидтай уулзаж, төр засгийн бодлого шийдвэрийг танилцуулах оролдлого хийсэн боловч иргэд, малчид ажлын хэсгийнхнийг үг хэлүүлэхгүй, эсэргүүцэн, хөөж харилцан ярилцаж, тохиролцоонд хүрэх ямар ч боломж бүрдээгүй талаар ажлын хэсэгт ажилласан Өмнөговь аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс мэдээлэл өгсөн. Ерөнхий сайд 2022.05.26-наас 27-ны өдрүүдэд Өмнөговьд ажилласан бөгөөд ард иргэдийн шаардлага, хүсэлтийн дагуу Цагаандэл-Уул боомт нээхээр шийдвэрлэсэн Засгийн газрын 2014 оны 46 дугаар тогтоолыг түдгэлзүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэр гаргаж байгаагаа мэдэгдсэн. Засгийн газрын 2022.05.31-ний өдрийн хуралдаандаар хэлэлцүүлж, Цагаандэл Уул боомтын асуудлыг Өмнийн говийн хөгжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн санал, дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан даалгасан. Мөн Ерөнхий сайдын 2022.07.20-ны өдрийн 107 дугаар захирамжаар Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагын дарга нараас бүрдсэн Цагаандэл-Уул боомтыг нээн ажиллуулахад тулгамдаж буй асуудлыг судалж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. | 30% | Орон нутгийн иргэдийн шаардлагаар боомтын үйл ажиллагаа зогссон тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 24 | **2022_34. 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл / 2022-06-22 /** | XII.12. . “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Замын-Үүд-Алтанбулаг чиглэлийн олон улсын транзит хурдны авто зам барих, хилийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох төслийн хэрэгжилтийн явцын талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Арцсуурь, Ханх, Бага-Илэнх, Сүмбэр, Баянхошуу боомт чиглэлийн авто замыг барих төслийн хөрөнгийн эх үүсвэрийн талаар судалж, саналаа танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав; | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд дээрх чиглэлийн авто замыг барих төслийн хөрөнгийн саналыг 2022.08.12-ны 01/3688 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн ч төсөвт тусгагдаагүй. Арцсуурь хилийн боомт хүртэлх 159.4км авто зам барих төслийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдүүлэхээр АХБ-ны 4-р шатны төслийн хүрээнд хэрэгжүүлэх саналыг ЭЗХЯ-нд хүргүүлсэн. | 70% | |
| 25 | **2022_34. 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл / 2022-06-22 /** | XII.12.3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр нь шийдвэрлэгдсэн авто замын бүтээн байгуулалтын ажлыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт даалгав. | 2022 онд хөрөнгө оруулалт шийдвэрлэгдсэн дараах авто замын бүтээн байгуулалтын ажил дуусч, хэрэгжилтэд хяналт тавин ажилласнаар ашиглалтад оруулсан байна. Үүнд:<br>1. Чингис хот - Дадал сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 50 км<br>2. Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Хөвсгөл, Цагаан-Уул сум/ 1.1 км<br>3. Улаанбаатар хотод хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ: Баянгол дүүрэг-Багц-1-3<br>4. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй хорооны доторх авто зам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг 13 дугаар хороо/<br>5. БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн Тосонцэнгэл- | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто зам;<br>6. Баруун босоо тэнхлэгийн авто төслийн Багц 1-4 Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км авто зам<br>7. Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн. | | |
| 26 | **2022_35. 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр 35 дугаар тэмдэглэл / 2022-06-29 /** | XXYII.3. . Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалт болон Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замд хийгдэж байгаа 57.56 км авто замын шинэчлэлийн ажлын хэрэгжилт, тулгамдаж байгаа асуудлын талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалт болон Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замд хийгдэж байгаа 57.56 км авто замын шинэчлэлийн ажлыг саадгүй гүйцэтгэхэд шаардлагатай цементийг хуваарийн дагуу дараалал харгалзахгүйгээр, тасралтгүй нийлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Хөтөлийн “Цемент шохой” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр гүйцэтгэх төрийн өмчийн төлөөлөгч Л.Наранбаатар нарт даалгав; 2. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын төслийн | “Мак цемент” ХХК, “Монцемент билдинг материалс” ХХК, “Налгар түшиг” ХХК нь Улаанбаатар-Дархан чиглэлийн автозамын ажлын бүтээн байгуулалтыг тасалдуулахгүй байхад онцгой анхаарч хамтран ажилласан ба УБ-Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажлын талаар 2022.09.22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар танилцуулсан.<br>2022.10.30-ны өдөр УБ-Дархан чиглэлийн 202.4 км замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн. | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | санхүүжилтийн асуудлаар холбогдох этгээдтэй хэлэлцээ хийх, санхүүжилтийг шийдвэрлэх саналаа Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт даалгав. | | | |
| 27 | 2022_35. 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр 35 дугаар тэмдэглэл | XXYII.4.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын боомтын сэргэлтийн хүрээнд Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1255 км төмөр замын төслийг эхлүүлэх, Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх 159.5 км хатуу хучилттай авто зам барих, Арцсуурь хилийн боомтын зэрэглэлийг нэмэгдүүлэх талаар судалж танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт; | 1. Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1255 км төмөр замын төсөл: Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт буюу Баруун босоо чиглэлийн төмөр замын төсөлд “Эссенз Саплайз” ХХК, Зүүн босоо чиглэлийн төсөлд “Ийст коридор рэйлрөүд” ХХК, “Бодь интернэшнл” ХХК-иуд сонгогдсон бөгөөд цаашид хэрхэн хамтарч ажиллах тухай санал солилцон хэлэлцээр хийгдэж байна.<br>Тус тогтоолын хэрэгжилт удаашралтай байгаа тул хамтран хэрэгжүүлэх компанитай хэлэлцээ хийх, гэрээ байгуулах ажлыг эрчимжүүлэх, ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах чиглэлийг 2022.11.29, 2022.12.08-ны өдрийн албан бичгүүдээр “МТЗ” ТӨХК-д хүргүүлсэн. Төсөлд оролцохоор хүсэлт ирүүлсэн компаниудтай уулзалт зохион байгуулан хэлэлцээрийн саналыг 2022.12.28-ны өдөр МТЗ ТӨХК-иас тус яаманд ирүүлсэн бөгөөд албан бичигт тусгагдсан саналуудтай танилцаад холбогдох саналыг өгч ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, хэлэлцээр хийх ажлыг эрчимжүүлэх чиглэлийг албан бичгээр хүргүүлсэн. Үүний үр дүнд хөрөнгө оруулж хамтран ажиллахаар сонгогдсон байгууллагуудтай гэрээ байгуулахаар гэрээний нөхцөлүүдээ тохирч Зам, тээврийн хөгжлийн яаманд хянуулах, санал | 100% | Баруун босоо чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлсэн, мөн Хилийн боомтын авто зам барих, зэрэглэл нэмэгдүүлэх талаар Засгийн газарт 3 удаа танилцуулсан тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | авахаар ирүүлээд байна. Мөн тус төслүүдийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын даалгаварын төсөл, төслүүдийн ажлын төлөвлөгөөг хянуулах, батлуулахаар ажиллаж байна.<br>2. Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх 159.5 км хатуу хучилттай авто зам барих, Арцсуурь хилийн боомтын зэрэглэлийг нэмэгдүүлэх талаар: Хилийн боомт чиглэлийн авто замын төслүүдийн мэдээллийг бэлтгэж, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн болон Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан төслүүдийн явц байдлын талаар мэдээллийг бэлтгэн, санхүүжилтийг шийдвэрлэх саналын хамт 2022.03.30-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд тус тус танилцуулсан. Үүний дараа Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан авто замын төслүүдийн талаар Засгийн газрын хуралдаанд 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр танилцуулж, 34 дүгээр тэмдэглэл гарсан. | | |
| 28 | **2022_36. 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 36 дугаар тэмдэглэл / 2022-07-05 /** | XX.7.1. Монгол Улсын Ерөнхий сайд 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажилтай танилцсан дүнгийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авахыг дор дурдсан албан тушаалтанд даалгав: 1. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам, замын барилга байгууламжийг барих ажлын хэрэгжилт удаашралтай | Тэмдэглэлийн дагуу “Чайна жео инженеринг корпораци” болон “Жунмэй инженеринг групп” компаниудад хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар тухай бүр газар дээр нь шалган, хяналт тавьж ажилласан.<br>УБ-Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажлын талаар 2022.09.22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар танилцуулсан.<br>2022.10.30-ны өдөр УБ-Дархан чиглэлийн 202.4 км замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн. Засгийн газрын 2022 оны 442 дугаар тогтоолоор УБ-Дархан чиглэлийн замд нэмэлт 2 гүүр барих төслийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. | 100% | хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгаа Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилттэй Багц 4 хэсэг буюу Сүмбэрийн уулзвараас Цайдамын хөндий хүртэлх 45.08 км замын барилгын ажлын гүйцэтгэгч “Чайна жео инженеринг корпораци” болон Европын сэргээн босголт, хөгжлийн банкны төслийн санхүүжилттэй Багц 2 хэсэг буюу Хар модотын давааны араас Урьхан хүртэлх 45.5 км, Багц 3 хэсэг буюу Урьханаас-Сүмбэрийн уулзвар хүртэлх 45.72 км замын барилгын ажлын гүйцэтгэгч “Жунмэй инженеринг групп” компаниудад ажил эрчимжүүлэх хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийн биелэлтийн талаарх дүн, цаашид авах арга хэмжээний талаарх саналаа Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт; | | | |
| 29 | **2022_38. 2022 оны 7 дугаар сарын 27-ны өдөр 38 дугаар тэмдэглэл / 2022-07-27 /** | Ү.3. Монгол Улсын хилийн Даян боомтын гүүрийн барилгын ажил удааширсан шалтгааныг судалж, шаардлагатай арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт даалгав. | Даян боомтод барих гүүрийн байршлыг тодорхойлох судалгаа хийлгэхээр Авто замын норм, нормативын сангийн 2023 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | 100% | Даян боомтод гүүр байхгүй ба шаардлагатай арга хэмжээг авсан тул хяналтаас хасуулах |
| 30 | **2022_39. 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр** | XYIII.3.1.5. Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын бүтээн байгуулалтын талбайтай давхцал бүхий газрын асуудлыг 2022 оны 8 дугаар сард | Тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу тус яамнаас 03/3909 тоот албан бичгээр авто замын трассыг өөрчлөхдөө ашиглалтын зөвшөөрөл эзэмшигч "Манлай энержи" ХХК-тай зөвшилцөлгүйгээр ашиглалтын талбайг | 70% | Мөн тус яамнаас эрхлэх асуудлын хүрээнд арга хэмжээ авсан ба трассын давхцалыг чиг үүргийн дагуу Уул уурхай, хүнд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **тэмдэглэл / 2022-08-03 /** | багтаан шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт; | дайруулсан талаарх тайлбар ирүүлэхийг "Тахилт хайрхан транс "ХХК-д, хувийг концессын гэрээний тал болох ЭЗХЯ, хяналт хэрэгжүүлж буй Зөвлөх "Эм Си Пи Си ЖИ Ар" ХХК-д мэдэгдсэн. Концесс эзэмшигчээс замын трассыг өөрчлөх хайгуул, судалгаа хийж, хувилбар гаргасан бөгөөд уг хувилбараар сум орон нутгийн удирдлагатай зөвшилцсөн хариу өгсөн. Үүний дагуу ашиглалтын талбайн хэмжээнд өөрчлөлт оруулах асуудлыг судлан үзэж, трассын давхцалыг шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 03/04 тоот албан бичгээр хүргүүлсэн. Трассын давхцалыг чиг үүргийн дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам шийдвэрлэнэ. | | үйлдвэрийн яам шийдвэрлэх тул хяналтаас хасуулах. |
| 31 | **2022_39. 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл / 2022-08-03 /** | XYIII.3.1.13. Шинээр хэрэгжиж эхэлсэн Норовлин-Баян-Уул-Ульхан чиглэлийн 117 км авто зам барих төсөл, Гашуунсухайт боомт дахь ачаа тээврийн терминал төсөл, Замын-Үүд-Эрээн боомт дахь чингэлэг шилжүүлэн ачих талбайг өргөтгөх төсөл, Багануурын 700 МВт-ын дулааны цахилгаан станц төсөл, Амгалангийн 116 МВт-ын дулааны станцыг өргөтгөх төслийн нарийвчилсан төлөвлөгөөг тус тус шинэчлэн 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх нарт". | 1.Норовлин-Баян-Уул чиглэлийн 68.3 км хатуу хучилттай авто замын барилгын ажил тусгагдаж, гүйцэтгэгчээр "Монгол зам групп" ХХК шалгарч гэрээ байгуулан барилгын ажлыг эхлүүлсэн. Барилгын ажил 15%-тай хэрэгжилттэй байна.<br>2. Баян-Уул -Ульхан чиглэлийн 50 км авто замын барилгын ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2022 онд 6 удаа зарласан ч амжилтгүй болсон. 2023 онд төсөв нэмэгдэн батлагдаж, тендерийг дахин зарласан ба 2023 оны 02 дугаар сарын 17-нд нээнэ.<br>3. Гашуунсухайт боомт дахь ачаа тээврийн терминал төсөл, Замын-Үүд-Эрээн боомт дахь чингэлэг шилжүүлэн ачих талбайг өргөтгөх төслийн төлөвлөгөөг тус тус ЭЗХЯ-нд хүргүүлсэн. | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 32 | **2022_46. 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 46 дугаар тэмдэглэл / 2022-09-22 /** | X.8. Авто замын стандартыг олон улсын стандартын түвшинд хүргэж нийцүүлэх, холбогдох авто замын (даац, зам засвар, арчлалт гэх мэт) норм, норматив, техникийн баримт бичгийг сайжруулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод; | Авто замын норм нормативын сангийн хөрөнгө оруулалтаар "Автотээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал авто замын хучилтанд нөлөөлөх байдлын судалгаа"-ны ажлыг "MCPC gr" ХХК-иар гүйцэтгүүлж, судалгааны ажлын эхлэл, дунд, эцсийн шатны тайланг хүлээн авч авто замын салбарын болон Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, техникийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан. | 100% | хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| 33 | **2022_62. 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 60 дугаар тэмдэглэл / 2022-12-21** | XYI.4. . Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ 2022 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хотын түгжрэл, төвлөрөл болон шинээр барьж байгуулах зам, замын байгууламжийн чиг (трасс)-ийн төлөвлөлттэй танилцсан дүнгийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын дараахь гишүүд, холбогдох албан тушаалтанд даалгав: 1."Шинэ тойрог зам"-ын урд чиглэлийн хэсэг буюу Туул голын эрэг дагуух авто зам, замын байгууламж болон тус авто замыг Улаанбаатар-Хөшигийн хөндийн нисэх онгоцны шинэ буудал чиглэлийн хурдны авто замтай холбох авто зам, замын байгууламжийг шуурхай барьж байгуулахаар зохион байгуулж, зохих арга хэмжээ авч | "Шинэ тойрог зам"-ын урд чиглэлийн хэсэг буюу Туул голын эрэг дагуух авто зам, замын байгууламж болон тус авто замыг Улаанбаатар-Хөшигийн хөндийн нисэх онгоцны шинэ буудал чиглэлийн хурдны авто замтай холбох авто зам, замын байгууламжийг шуурхай барьж байгуулах талаар Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, чиг үүргийн дагуу хариуцах ажлуудыг үүрэгжүүлсэн Улаанбаатар хотын шинэ тойрог замыг барьж байгуулах тухай 476 тогтоол гаргуулсан. | 100% | хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод, хойд чиглэлийн хэсгийг шуурхай барьж байгуулахаар зохион байгуулж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт; | | | |
| **1Д.Засгийн газрын албан даалгавар** | | | | | |
| 34 | **2021_01. Бүтээн байгуулалтын төсөл, бодлогын зарим арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай** | 10.2. 10.2.Улаанбаатар-Дархан-Улаанбаатар чиглэлийн авто замын барилгын ажлыг чанартай барьж дуусгах, ашиглалтад бүрэн өгөх хугацааг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан тооцож тодорхойлох; | Улаанбаатар-Дархан чиглэлийн багц нийт 5 багц хэсгийн шинээр асфальтбетон хучилт хийгдсэн 204 км авто замаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2022.10.30-ны өдрөөс хэвийн нэвтрүүлж байна. АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын явц:<br>Ажлын хэрэгжилтийг багц тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:<br>Багц 1 хэсэг: санхүүжилтийн өртгөөр - 94.13%, ажлын тоо хэмжээгээр - 94.13%,<br>Багц 2 хэсэг: санхүүжилтийн өртгөөр – 97.21% ажлын тоо хэмжээгээр – 99.2%<br>Багц 3 хэсэг: санхүүжилтийн өртгөөр - 94.39%, ажлын тоо хэмжээгээр – 94.39%,<br>Багц 4 хэсэг: санхүүжилтийн өртгөөр – 51.55%, ажлын тоо хэмжээгээр – 65.1%<br>Багц 5 хэсэг: санхүүжилтийн өртгөөр - 95.54%, ажлын тоо хэмжээгээр - 99.09%<br>АХБ-ны төслийн хүрээнд барилгын ажлын талбай дээр 297 гаруй инженер техникийн ажилчид, 146 орчим техник, тоног төхөөрөмж ажиллаж байгаа бөгөөд нийт 5 багц хэсгийн барилгын ажлын гүйцэтгэл санхүүжилтийн өртөгөөр 83.8%, ажлын | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тоо хэмжээгээр 87.6%-тай хэрэгжиж байна. Тав. Европын сэргээн босголт, хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөлийн ажлын явц:<br>Ажлын хэрэгжилтийг багц тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:<br>Багц 1 хэсэг: санхүүжилтийн өртгөөр – 69.68%, ажлын тоо хэмжээгээр - 84.22%,<br>Багц 2 хэсэг: санхүүжилтийн өртгөөр – 37.82%, ажлын тоо хэмжээгээр - 51.78%,<br>Багц 3 хэсэг: санхүүжилтийн өртгөөр – 27.44%, ажлын тоо хэмжээгээр - 40.89%,<br>Багц 4 хэсэг: санхүүжилтийн өртгөөр - 53.27%, ажлын тоо хэмжээгээр – 59.24%,<br>Багц 5 хэсэг: санхүүжилтийн өртгөөр – 52.85%, ажлын тоо хэмжээгээр - 66.64%,<br>Нийт 5 багц хэсгийн барилгын ажлын гүйцэтгэл санхүүжилтийн өртөгөөр 48.5%, хийсэн ажлын тоо хэмжээгээр 60.5%-ийн хэрэгжилттэй байна. Тухайн төслийг нийт уртад 4 эгнээгээр гүйцэтгэгч байгууллагуудтай байгуулсан гэрээний хүрээнд 2023.10.30-ны өдөр бүрэн ашиглалтад оруулна. | | |
| **2.Төмөр замын салбар** | | | | | |
| **2а. УИХ-ын тогтоол** | | | | | |
| 35 | **2021 №12. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай** | 3. Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч нэн шаардлагатай гэж үзсэн хууль тогтоомжийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлж байхыг Монгол | Зүүнбаян-Ханги, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн 876.4 км төмөр зам баригдсанаар Монгол Улсын үндэсний төмөр замын сүлжээний урт 2,964.9 км болж өргөжсөн. Урьд нь төмөр замын суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч ганцхан байсан бол өдгөө суурь бүтэц эзэмшигч 4, тээвэрлэгч 4, суурь бүтэц барих, угсрах эрх бүхий 253, дагнасан болон салбар зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч 250 орчим болж нэмэгдлээ. Үүнтэй холбоотойгоор Монгол | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай. | Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдаагүй Төмөр замын тээврийн тухай хуулийг шинэчлэн боловсруулж, УИХ-д 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн. | | |
| 36 | **2021 №94. Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн талаар авах зарим арга хэмжээний тухай** | 3.. Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн дүрмийн санг нэмэгдүүлэх асуудлыг Оросын талтай тохиролцсон тохиолдолд тус нийгэмлэгт олгосон “МОН-П1”, “МОН-П2” хөнгөлөлттэй зээлийн үлдэгдлийг Монголбанкны 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн албан ханшаар төгрөгт шилжүүлж, уг өдрөөс хойш тооцогдсон хүү, алдангийн төлбөрийг чөлөөлж, дүрмийн санг нэмэгдүүлэхээс бусад зээлийн үлдэгдэл төлбөрийг Японы Олон улсын хамтын ажиллагааны банканд төлөх хуваарьтай уялдуулан 2021-2025 онд багтаан төлүүлэх арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай. | Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэг МОН-П1, МОН-П2 зээлийн 2022 онд төлвөл зохих 10,147,646,817.77 төгрөгийг 2022 оны 12 дугаар сарын 24, 28-ны өдрүүдэд Сангийн яамны холбогдох дансанд төвлөрүүлсэн. Хэлэлцээрт нэмэлт оруулах протокол байгуулагдаагүй тул үлдэгдэл төлбөрийг “Японы Олон улсын хамтын ажиллагааны банк”-нд төлөх төлбөрийн хуваарьтай уялдуулан 2025 он хүртэл төлөх нөхцөлөөр дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулагдаагүй байгаа болно. Хэрэв энэхүү протокол байгуулагдахгүй тохиолдолд 2025 он хүртэлх хуваарийн дагуу төлбөрийг төлөх болно. 2021, 2022 оны төлбөрийг хуваарийн дагуу төлсөн. | 100% | |
| **2б.УИХ-ын Байнгын хорооны тогтоол** | | | | | |
| 37 | **2021 №6 УБХ.. Засгийн газарт чиглэл өгөх тухай / 2021-12-28 / УИХ-ын байнгын** | I.2. Экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих төмөр замын төслүүд /Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Богдхан төмөр зам, нүүрс | Экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих төмөр замын төслүүд 2022 онд зорилтот түвшинд хүрч, дараах гүйцэтгэлтэй байна. Үүнд: 1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн чиглэлийн 416.1 км/дэлгэмэл 462.5 км/ хэвтээ тэнхлэгийн төмөр замын бүтээн байгуулалтын ажил дууссаж, 2022.03.10-ны өдөр зүгшрүүлэх тээвэр явж | 100% | Төмөр замын томоохон төслүүд Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт, Зүүнбаян-Ханги чиглэлийн нийт дэлгэмэл 1064.3 км төмөр замын бүтээн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **хорооны тогтоол** | ачилтын байгууламж, холболтын болон хилийн төмөр зам/ | эхэлсэн.<br>2. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 233.6 км/дэлгэмэл урт 312.8 км/ нэгдүгээр зэрэглэлийн хүнд даацын төмөр замыг 2022.09.09-ны өдөр ашиглалтад хүлээн авсан.<br>3. Тавантолгой-Зүүнбаян болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замуудыг холбох 21.1км/дэлгэмэл 26км/ төмөр замын дээд, доод бүтцийг 2022 оны 09 сард барьж дуусган, техникийн комисс ажилласан.<br>4. Богдхан төмөр зам:<br>4.1 Богдхан төмөр замын ТЭЗҮ-ийг "Тавантолгой төмөр зам" ХХК боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлөөр 2022.01.07-ны өдөр Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр 2022.01.11-ний өдөр хэлэлцүүлж дэмжсэн.<br>4.2. Богдхан төмөр замын чигийг "Тавантолгой төмөр зам" ХХК боловсруулж Засгийн газрын 2022.01.19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.<br>4.3.Богдхан төмөр зам төслийн санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 353 дугаар маш нууц тогтоолоор уг асуудлыг шийдвэрлэсэн.<br>4.4. Богдхан төмөр зам төслийн талаар 2022.12.21-ний Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэж, 62 дугаар тэмдэглэлээр уг төслийг УБТЗ ХНН-ээр гүйцэтгүүлэхээр үүрэг өгсөн. | | байгуулалтын ажил хийгдэж дууссан тул хяналтаас хасуулах. |
| **2в. Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 38 | **2021_146. Нийслэл Улаанбаатар хотын талаар авах зарим** | 6. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, дагуул хот, суурьшлын бүсийг үе шаттайгаар байгуулах зорилгоор Богдхан төмөр замыг барьж | Богдхан төмөр замыг барьж ашиглалтад оруулах ажлыг эрчимжүүлэх хүрээнд дараах арга хэмжээ авч ажилласан. Үүнд:<br>1. Богдхан төмөр зам төслийн чигийг ЗГ-ын 2022.01.19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **арга хэмжээний тухай / 2021-05-19** | ашиглалтад оруулах ажлыг эрчимжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд, Богдхан уулын дархан цаазат газрын хилийн заагт өөрчлөлт оруулах асуудлыг судалж, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасанд, Нийслэл Улаанбаатар хот, Төв аймаг хооронд үүссэн хилийн цэсийн маргааныг судалж, хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нарт тус тус даалгасугай. | 51 дүгээр тогтоолоор баталгаажуулсан. 2. Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар төслийн ажлыг эрчимжүүлэх зарим асуудлыг хэлэлцүүлэн, 22 дугаар тэмдэглэл гарсан. 3. Богдхан төмөр замын төслийн ТЭЗҮ-г тус яамны Шинжлэх ухаан, технологийн Зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 09 дүгээр шийдвэрээр хэлэлцүүлэн батлуулсан. 4. Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн сайд, Батлан хамгаалахын сайд нарын “Тогтоолын хэрэгжилт хангах тухай” 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн МН/01, МН/03, МН/28 дугаартай хамтарсан тушаал батлагдсанаар Төслийн замын доод бүтэц, өртөө, зөрлөгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлэх Зэвсэгт хүчний жанжин штабтай 2022 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн ТТЗ-МН22/03 дугаар гэрээг байгуулсан. 5. Зэвсэгт хүчин жанжин штабийн 2 нэгтгэл анги, 15 туслан гүйцэтгэгч компани Богдхан төмөр замын трассын дагуух пк105+000 - пк142+500 хүртэлх 37.5 км замын газар шорооны ажлыг 2022.09.27-нд эхлүүлж 2022 оны байдлаар 899,840.18 м3 ажил хийж гүйцэтгэсэн. 6. Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 62 дугаар тэмдэглэлийн 3 дахь заалтаар "Богдхан төмөр зам төслийг УБТЗ ХНН-ээр хариуцуулан гүйцэтгүүлэх, тус төмөр замын шугамыг эцэслэн тохирох чиглэлээр оросын талтай ажиллаж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд арга хэмжээ авахыг" Зам, тээврийн хөгжлийн сайдад даалган, дараагийн шатны үүрэг өгөгдсөн. | | |
| 39 | **2021_380. Монгол-Оросын хувь** | 5. Оросын талтай хэлэлцээ хийж дуусах хүртэлх хугацаанд “Улаанбаатар төмөр зам” ХНН- | Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэг МОН-П1, МОН-П2 зээлийн 2022 онд төлвөл зохих 10,147,646,817.77 | 100% | 2025 он хүртэл жил бүрийн эцэст төлбөр хуваарийн дагуу төлөгдөх |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн талаар авах зарим арга хэмжээний тухай / 2021-12-14 / ЗГ-ын тогтоол** | ийн дүрмийн санг нэмэгдүүлэхээс бусад зээлийн үлдэгдэл төлбөрийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дамжуулан зээлдүүлэх гэрээний хуваарьт 2021 оноос төлөхөөр заасан хэмжээгээр улсын төсөвт төлж, хэлэлцээр байгуулсан тохиолдолд үлдэгдэл төлбөрийг “Японы Олон улсын хамтын ажиллагааны банк”-нд төлөх төлбөрийн хуваарьтай уялдуулан 2025 он хүртэл төлөх нөхцөлөөр дамжуулан зээлдүүлэх гэрээг шинэчлэн байгуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, “Улаанбаатар төмөр зам” ХНН-т даалгасугай. | төгрөгийг 2022 оны 12 дугаар сарын 24, 28-ны өдрүүдэд Сангийн яамны холбогдох дансанд төвлөрүүлсэн. Хэлэлцээрт нэмэлт оруулах протокол байгуулагдаагүй тул үлдэгдэл төлбөрийг “Японы Олон улсын хамтын ажиллагааны банк”-нд төлөх төлбөрийн хуваарьтай уялдуулан 2025 он хүртэл төлөх нөхцөлөөр дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулагдаагүй байгаа болно. Хэрэв энэхүү протокол байгуулагдахгүй тохиолдолд 2025 он хүртэлх хуваарийн дагуу төлбөрийг төлөх болно. 2021, 2022 оны төлбөрийг хуваарийн дагуу төлсөн. | | тул Дотоод хяналтандаа авч, ЗГХШМС-ын хяналтаас хасуулах |
| 40 | **2022_51. Төмөр замын шугамын чиг тогтоох тухай / 2022-01-19** | 2. Батлагдсан чигийн дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай болон давхацсан газрыг чөлөөлөх, шинээр газар олгохгүй байх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нарт, төмөр замын чигтэй давхацсан нутаг дэвсгэрт газар чөлөөлөхөд | "Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 51 дүгээр тогтоолоор батлагдсан Богдхан төмөр замын шугамын чигийг ашигт малтмалын мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулж, чигийн дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шинээр олгохгүй байх саналыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 01/1764 дугаартай албан бичгээр Уул, уурхай, хүнд үйлдвэрийн сайдад хүргүүлсэн. Засгийн газрын тогтоолын дагуу мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн талаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас мэдэгдсэн. Мөн дээрх тогтоолыг хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар чөлөөлөх ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022.06.23-ний өдрийн 01/2917 дугаартай албан бичгээр Барилга, хот байгуулалтын сайдад | 100% | ЗТХЯам нь Улсын тусгай хэрэгцээнд авах газрын байршил, солбицол, зориулалт, хэмжээний саналаа боловсруулж БХБЯаманд хүргүүлсэн тул Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5.14-т заасан ЗТХЯамны эрхлэх асуудал 100 хувь бүрэн дууссан. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах гаргах журамд заасны дагуу газар чөлөөлөлтийн асуудлыг БХБЯ, ГЗБГЗЗГазар, аймаг, Нийслэл, дүүргийн газрын |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шаардагдах хөрөнгийг төслийн нийт санхүүжилтэд оруулан тооцохыг “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Удаанжаргалд тус тус даалгасугай. | хүргүүлсэн. “Тавантолгой төмөр зам” ХХК-аас Богдхан төмөр замын 1245,54 га зурвас газрын кадастрын зургийг боловсруулж 2022.09.13-ны өдрийн 1/982 дугаартай албан бичгээр ЗТХЯаманд ирүүлсэнийг “Төмөр замын зурвас газарт тавих шаардлага” MNS 6060:2010 Монгол Улсын стандарт, “Норм ба дүрэм батлах тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 121 дүгээр тушаалд нийцүүлсэн эсэхийг хянаж ЗТХЯамны 2022.09.14-ний өдрийн 03/4184 дугаартай албан бичгээр Улсын тусгай хэрэгцээнд авах саналаа БХБЯаманд хүргүүлсэн. Монгол Улсын засгийн газрын тухай хуулийн 20.5.12, Газрын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах гаргах журам”-д заасны дагуу БХБЯ-ны чиг үүрэг болно. | | алба хамтран шийдвэрлэхээр заасан байх тул хяналтаас хасуулах |
| 41 | **2022_109. Төмөр замын шугамын чиг тогтоох тухай / 2022-03-09 /** | 2. “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын чигийн дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг 2022 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт, төмөр замын шугамын чигийг Газрын кадастрын улсын мэдээллийн санд бүртгэхийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (А.Энхманлай)-т тус тус даалгасугай. | Төмөр замын шугамын чигийг ашигт малтмалын мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулж, чигийн дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шинээр олгохгүй байх саналыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 01/1764 дугаартай албан бичгээр Уул, уурхай, хүнд үйлдвэрийн сайдад хүргүүлсэн. “Монголиан транс лайн” ХХК-аас Зүүнбаян-Ханги чиглэлийн 226,9 км төмөр замын 3257 га зурвас газрын кадастрын зургийг боловсруулж 2023.01.26-ны өдрийн 1/38 дугаартай албан бичгээр ЗТХЯаманд ирүүлсэнийг “Төмөр замын зурвас газарт тавих шаардлага” MNS 6060:2010 Монгол Улсын стандарт, “Норм ба дүрэм батлах тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 121 дүгээр тушаалд нийцүүлсэн эсэхийг хянаж, төслийн танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, тогтоолын төслийн хамт боловсруулж ЗТХ-ийн сайдын 2023.01.27-ны | 100% | ЗТХЯам нь Улсын тусгай хэрэгцээнд авах газрын байршил, солбицол, зориулалт, хэмжээний саналаа боловсруулж БХБЯаманд хүргүүлсэн тул Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5.14-т заасан ЗТХЯамны эрхлэх асуудал 100 хувь бүрэн дууссан. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах гаргах журамд заасны дагуу газар чөлөөлөлтийн асуудлыг БХБЯ, ГЗБГЗЗГазар, аймаг, Нийслэл, дүүргийн газрын алба хамтран |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | өдрийн 01/421 дугаартай албан бичгээр Улсын тусгай хэрэгцээнд авах саналаа БХБЯаманд хүргүүлсэн.<br>Монгол Улсын засгийн газрын тухай хуулийн 20.5.12, Газрын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах гаргах журам”-д заасны дагуу БХБЯ-ны чиг үүрэг болно. | | шийдвэрлэхээр заасан байх тул хяналтаас хасуулах |
| 42 | **2022_116. Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай / 2022-03-16** | 4. Энэ тогтоолын 1-д заасан компанитай холбогдох хууль тогтоомжийн дагуу шууд гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар (Х.Улам-Өрнөх)-т, төмөр замын төслийн ажлыг 2022 оны 2 дугаар улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, “Монголын төмөр зам” ТӨХК (О.Батнасан)-д тус тус даалгасугай. | Монголын төмөр зам ТӨХК нь Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төсөлд хамтран ажиллах сонирхол бүхий этгээдийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулж, сонирхогч байгууллагад урилга хүргүүлж, 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр хүртэл 11 материал хүлээн авсан. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг явуулж, Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн буюу Баруун босоо чиглэлийн төмөр замын төсөлд “Эссенз Саплайз” ХХК, Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт буюу Зүүн босоо чиглэлийн төсөлд “Ийст коридор рэйлрөүд” ХХК, “Бодь интернэшнл” ХХК-иуд сонгогдсон. 2022.12.28-ны өдөр МТЗ ТӨХК-иас дээрх компаниудтай уулзалт зохион байгуулан хэлэлцээрийн саналыг тус яаманд ирүүлсэн ба албан бичигт тусгагдсан саналуудтай танилцан холбогдох саналыг өгч, хэлэлцээр хийх ажлыг эрчимжүүлэх чиглэлийг албан бичгээр хүргүүлсэн. Үүний үр дүнд хөрөнгө оруулж хамтран ажиллахаар сонгогдсон байгууллагуудтай гэрээ байгуулахаар гэрээний нөхцөлүүдээ тохирч Зам, тээврийн хөгжлийн яаманд хянуулах, санал авахаар ирүүлээд байна. Мөн тус төслүүдийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | даалгаварын төсөл, төслүүдийн ажлын төлөвлөгөөг батлуулахаар ажиллаж байна. | | |
| 43 | **2022_116. Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай / 2022-03-16 /** | 6. “Монгол-Оросын хилийн төмөр замын харилцааны тухай хэлэлцээр”-т холбогдох өөрчлөлт оруулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт даалгасугай. | Монгол-Оросын хилийн төмөр замын харилцааны тухай хэлэлцээрт холбогдох өөрчлөлт оруулах ажлын хүрээнд дараах арга хэмжээ авч ажилласан. Үүнд:<br>1. Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Оросын Холбооны Улсын Красноярскийн хязгаарын Зам тээврийн сайд К.Н.Димитровтой 2022.06.07-ны өдөр хийсэн уулзалтын үеэр хилийн Арцсуурь-Цагаантолгой төмөр замын боомтыг байгуулах асуудлыг хэлэлцсэн.<br>2. “Хилийн боомт болон Монгол, Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн Газар хоорондын хэлэлцээр”-т хилийн Арцсуурь-Цагаантолгой төмөр замын боомтыг нэмж тусгах, Эрээнцав-Соловьёвск төмөр замын боомтыг төмөр замын тээврийн харилцааны олон улсын зэрэглэлтэй болгох асуудлыг оросын талтай хэлэлцэн шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг 2022.09.08-ний өдрийн 01/4084 дугаар албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.<br>3. Монгол-Оросын хилийн Сүхбаатар-Наушки болон Монгол-Хятадын хилийн Замын-Үүд-Эрээн төмөр замын боомтын галт тэрэг солилцооны асуудлаар Зам, тээврийн хөгжлийн яам, Оросын Холбооны Улсын Тээврийн яамны Төмөр замын тээврийн бодлогын газрын дарга нарын зөвлөлдөх уулзалтыг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Тус уулзалтаар Монгол-Оросын хилийн Арцсуурь-Цагаантолгой төмөр замын боомтыг шинээр байгуулах, Эрээнцав-Соловьёвск төмөр замын боомтыг тээврийн харилцааны олон улсын зэрэглэлтэй болгох тухай санал солилцсон. Оросын тал тус | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | асуудлаар хоёр талын төмөр замын байгууллагууд яриа хэлэлцээ хийх асуудлыг дэмжиж Монголын талтай уулзалт зохион байгуулах талаар “Оросын төмөр замууд" НХН-т чиглэл өгөхөөр болов. 4. Үүний дагуу 2023 оны 02 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд цахим горимоор Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төмөр замуудын төлөөлөгчдийн зөвлөгөөн болон Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн төмөр замын комиссын зөвлөгөөн зохион байгуулагдсан. Уг уулзалтаар Засгийн газар хоорондын комиссын хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад Эрээнцав-Соловьеск төмөр замын боомтын асуудлыг оруулахаар тохирсон. | | |
| 44 | **2022_434. “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн талаар авах арга хэмжээний тухай / 2022-11-30 /** | 2. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилт, “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зохих дүгнэлт гаргуулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн)-д даалгасугай. | ЗГХЭГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах" тухай 94 дүгээр тушаалын дагуу “Тавантолгой-Зүүнбаян”, "Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын төсөл, ”Богдхан” төмөр замын төслийн хэрэгжилтэд болон “Зүүнбаян төмөр зам” ХХК, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж дүгнэлт гаргуулах Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/ТТЗ-ЗБТ дугаартай удирдамжийн дагуу шалгалтын ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. | 70% | |
| 45 | | 3. “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагаар зогсоож, “Монголын төмөр зам” ТӨХК-д нэгтгэж байгаатай холбогдуулан “Монголын төмөр зам” ТӨХК-ийн дүрэм, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх арга хэмжээг зохих журмын дагуу авч | “Монголын төмөр зам” ТӨХК-ийн дүрэм, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүллээ.Үүнд: 1.ТӨБЗГ-ын 2022 оны 12 сарын 16-ны өдрийн А-1/2478 чиглэл болон 2022 оны 12 сарын 21-ний өдрийн А-1/2520 удирдамжийн дагуу компанийн дүрэм, бүтэц, зохион байгуулалттай холбоотой 2022 оны 12 сарын 30 өдрийн 03/6105 дугаартай | 100% | хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Брямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | албан тоотыг МТЗ ТӨХК-д хүргүүлсэн.<br>2. "МТЗ" ТӨХК-ийн ТУЗ-ын 2022 оны 12 сарын 30-ны өдрийн 27 дугаар тогтоолоор компанийн дүрмийн төслийг дэмжиж шийдвэрлэсэн.<br>3. ТӨБЗГ-ын 2022 оны 12 сарын 30-ны өдрийн 726-дугаар тогтоолоор "МТЗ" ТӨХК-ийн шинэчилсэн дүрмийн төслийг баталсан.<br>4. 2023 оны 01 сарын 05-ны өдөр "МТЗ" ТӨХК-ийн дүрмийг Улсын бүртгэлд бүртгүүлж албан ёсоор баталгаажуулсан.<br>5. ТӨБЗГ-ын "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн талаар авах арга хэмжээний тухай 2022 оны 12 сарын 725 дугаар тогтоолын дагуу "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийг "МТЗ" ТӨХК-нд нэгтгэхэд бүтэц, орон тоог шинэчлэн батлахтай холбогдуулан "МТЗ" ТӨХК-ийн ТУЗ-ийн дараах тогтоолууд гарсан.<br>-"Зүүнбаян төмөр зам" ХХК-ийг "МТЗ" ТӨХК-нд нэгтгэх 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 24 дүгээр тогтоол;<br>-"Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн хөрөнгийг шилжүүлэн авах 2022 оны 12 сарын 22-ны өдрийн 25 дугаар тогтоол;<br>-"МТЗ" ТӨХК-ийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тухай 28 дугаар тогтоол;<br>-"МТЗ" ТӨХК-ийн зохион байгуулалтын бүтцийн шинэчлэн батлах тухай 2022 оны 12 сарын 30-ны өдрийн 29 дүгээр тогтоол тус тус гарсан. | | |
| 46 | **2022_434. "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн талаар авах арга хэмжээний** | 4. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд "Эрдэнэс Тавантолгой" ХК-аас оруулсан хөрөнгө, санхүүжилтийг "Монголын төмөр зам" ТӨХК-ийн тээвэрлэлтийн үйл ажиллагааны орлого, холбогдох бусад эх үүсвэрээс барагдуулах арга | Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд "Эрдэнэс Тавантолгой" ХК-аас оруулсан хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлэх талаарх саналаа "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал П.Ганхүү "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад болон хувийг Зам тээврийн хөгжлийн яаманд 2023 оны 01 сарын 03 | 30% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **тухай / 2022-11-30 /** | хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай. | өдрийн 01/14 албан тоотоор тус тус хүргүүлсэн. МТЗ ТӨХК нь Эрдэнэс Тавантолгой ХК-д төмөр замын төсөлд зарцуулсан хөрөнгийг буцаан төлөх хуваарь гарган ажиллахаар төлөвлөж байна. | | |
| 47 | **2022_434. “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн талаар авах арга хэмжээний тухай / 2022-11-30 /** | 5. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардагдах эх үүсвэрийг тооцож, саналаа танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх удирдлага (Ж.Ганбат)-д даалгасугай. | 1.Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардагдах эх үүсвэрийг тооцож, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал П.Ганхүү “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай гэрээ байгуулах, хамтран ажиллах тухай санал болон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын нэмэлт санхүүжилтийн зээлийн гэрээний төслийн хамт 2023 оны 01 сарын 05 өдрийн 01/18 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад, албан бичгийн хувийг Зам тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тус тус хүргүүлсэн. 2. 2023 оны 01 сарын 18-ны өдрийн 01/75 албан бичгээр гэрээ байгуулах, хамтран ажиллах тухай саналыг дахин уламжилсан. Албан тоотын хувийг Зам, тээврийн хөгжлийн яаманд явуулсан. 3 2023 оны 01 сарын 18-ны өдрийн 01/76 албан тоотоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01/35 дугаартай албан бичгийн хариуг хүргүүлсэн.Хувийг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. | 70% | |
| 48 | **2022_435. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний** | 2. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг “Монголын төмөр зам” ТӨХК хэрэгжүүлэхээр тогтоосугай. 2. Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын | “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 435 дугаар тогтоолоор тус компаний хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр “Монголын төмөр зам” ТӨХК-ийг тогтоосны дагуу Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа, | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **тухай / 2022-11-30 /** | тээвэрлэлтийн үйл ажиллагаа, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах асуудлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод тус тус даалгасугай. | хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах асуудлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Зам тээврийн хөгжлийн сайдад, ТӨБЗГ, "Монголын төмөр зам" ТӨХК-ТУЗ-д тус тус даалгасаны дагуу тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 26 дугаар тогтоолоор "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг тогтоосон. Мөн ТӨБЗГ 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 726 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Монголын төмөр зам" ТӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 5,11,15-д "Компанийн төлөөлөн охин болон хараат компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэхээр заасан. | | |
| 49 | | 4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардагдах эх үүсвэрийг тооцож саналаа танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх удирдлага (Ж.Ганбат)-д тус тус даалгасугай. | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардагдах санхүүжилтийн тооцоог судлан гаргаж, УИХ-ын хянан шалгах түр хороонд танилцуулсан. Одоогийн байдлаар үндсэн төслийн санхүүжилт гацсан зүйл байхгүй байна. Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 70% | |
| 50 | | 5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээ, дүрэмд | "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийг "МТЗ" ТӨХК-нд нэгтгэх, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг "МТЗ" ТӨХК-нд шилжүүлэхтэй холбогдуулан тухайн 3 компанийн | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | өөрчлөлт оруулах, бүтэц, зохион байгуулалтыг зохих журмын дагуу шинэчлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай. | бүтэц, зохион байгуулалт, орон тооны талаар 2022.12.16-ны өдөр МТЗ ТӨХК-ийн ТУЗ-ийг хуралдуулсан.<br>ТУЗ-ын хурлаар:<br>1. Компаниудын эрх үүрэг, хариуцлага шилжүүлэх гэрээг хэлэлцсэн;<br>2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын товийг тогтоох асуудлуудыг хэлэлцсэн.<br>Мөн “МТЗ” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2022.12.30-ны өдрийн хуралдаанаар компаниуд нэгдсэнтэй холбоотой “МТЗ” ТӨХК-ийн 2023 оны Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг хэлэлцсэн, компанийн дүрмийг шинэчлэн баталсан. Уг хуралдаанаар МТЗ ТӨХК-ийн гүйцэтгэх захирлыг “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр томилсон. | | |
| 51 | **2022_435. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай / 2022-11-30 /** | 6. Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтоор шинээр баригдах хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож, хэрхэн санхүүжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн | Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтоор шинээр баригдах хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн талаар Засгийн газарт танилцуулахаар 2023.01.24 01/362 тоот албан бичгийг хүргүүлсэн ба 2023.01.25-ны өдрийн хуралдаанаар танилцуулах байсан боловч хойшлогдсон. | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай. | | | |
| 52 | **2022_446. Хилийн боомтуудын төмөр замын талаар авах арга хэмжээний тухай / 2022-12-07 /** | 1. Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч боомтын хил дамнасан төмөр замын техникийн нөхцөл, бүтээн байгуулалтын асуудлаар хятадын талтай хэлэлцээ хийж, үр дүнг танилцуулж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгасугай. | 1. Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч боомтын хил дамнасан төмөр замын техникийн нөхцөл, бүтээн байгуулалтын асуудлаар Хятадын талтай хэлэлцээ хийх, хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлэх талаар Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт 2022.12.19-ний өдрийн 01/5852 тоот албан бичиг хүргүүлсэн.<br>2. 2023 оны 02 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд цахим горимоор зохион байгуулагдсан Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төмөр замуудын төлөөлөгчдийн зөвлөгөөн болон Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн төмөр замын комиссын зөвлөгөөнөөр Шивээхүрэн, Бичигт, Гашуунсухайт, Ханги хилийн боомтын төмөр замын техникийн нөхцөл, бүтээн байгуулалтын асуудлаарх саналаа Хятадын талд танилцуулсан. | 70% | |
| 53 | **2022_446. Хилийн боомтуудын төмөр замын талаар авах арга хэмжээний тухай / 2022-12-07 /** | 2. Энэ тогтоолын 1-д заасан хэлэлцээгээр тохиролцсон асуудлын хүрээнд боомтын хил дамнасан төмөр замын асуудлыг хятадын төмөр замын байгууллагатай нарийвчлан тохиролцох хэлэлцээг “Монголын төмөр зам” ХХК-аар хийлгэх арга хэмжээ авч, удирдамж, чиглэлээр хангаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод даалгасугай. | 1. "Монголын төмөр зам" ХХК нь Хятадын төмөр замын байгууллагатай хилийн боомтуудын бүтээн байгуулалтын талаар яриа хэлэлцээ хийх бэлтгэл ажлыг хангах хилийн боомтын урьдчилсан төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах техникийн шаардлагын төслийг боловсруулж, ЗТХЯ-нд 2022.12.27-ны өдрийн 01/1835 тоот албан бичгээр ирүүлсэн.<br>2. "Монголын төмөр зам" ХХК-ийг Хятадын төмөр замын байгууллагатай хийх яриа хэлэлцээг зохион байгуулах талаар хүсэлтийг Хятадын талд уламжлуулахаар ГХЯ-нд 2023.01.04-ний өдрийн 01/28 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>3. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 446 дугаар тогтоолоор Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч боомтын | 100% | Удирдамж чиглэлээр ханган ажиллаж, үр дүн гарсан тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хил дамнасан төмөр замын техникийн нөхцөл, бүтээн байгуулалтын асуудлыг Хятадын төмөр замын байгууллагатай нарийвчлан тохиролцох хэлэлцээг “Монголын төмөр зам” ТӨХК-аар хийлгэхээр шийдвэрлэсний дагуу тус хэлэлцээг хийх удирдамжийг 2023.01.04-ний өдрийн 08/29 тоот албан бичгээр МТЗ ТӨХК-д хүргүүлсэн. 4. Дээрх бүх арга хэмжээний үр дүнд 2023 оны 02 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд цахим горимоор Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төмөр замуудын төлөөлөгчдийн зөвлөгөөн болон Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн төмөр замын комиссын зөвлөгөөн зохион байгуулагдсан ба Хятадын талд Шивээхүрэн, Бичигт, Зүүнхатавч, Ханги хилийн төмөр замын боомтын талаарх саналаа танилцуулж, ОХУ-ын талд 2 улсын засгийн газар хоорондын комиссын хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад Эрээнцав-Соловьеск хилийн төмөр замын боомтын асуудлыг оруулахаар тохирсон. | | |
| 54 | **2022_446. Хилийн боомтуудын төмөр замын талаар авах арга хэмжээний тухай / 2022-12-07 /** | 3. Хилийн төмөр замын Ханги-Мандал боомтыг “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т нэмж тусгах талаар хятадын талтай хийж байгаа хэлэлцээг эрчимжүүлж, 2023 оны эхний хагас жилд багтаан тохиролцох арга хэмжээ авч ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгасугай. | Монгол, Хятадын хилийн Ханги-Мандал төмөр замын боомт байгуулах асуудалтай холбоотой Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замаар тээвэрлэх ачааны судалгаа, холбогдох мэдээллийг 2022.12.22-ны 03/5931 тоот албан бичгээр ГХЯ-аар уламжлан Хятадын талд хүргүүлсэн. Хилийн Ханги-Мандал төмөр замын боомт байгуулах ажлын танилцуулга, ТЭЗҮ, концессын гэрээг ЭЗХЯ-нд 2022.12.26-ны өдөр цахим шуудангаар хүргүүлсэн. ЗТХЯ-наас ЭЗХЯ болон "Монголын төмөр зам" ТӨХК, концесс эзэмшийгчийн төлөөллийг оролцуулан БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Ардын засгийн ордон, "Хөх хотын төмөр зам групп" компанийн төлөөлөлтэй БНХАУ-ын Мандал боомтод 2023.01.12-ны өдөр уулзалт зохион байгуулж Зүүнбаян-Ханги чиглэлийн шинэ төмөр | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | замыг хилийн Ханги-Мандал боомтоор дамжуулан БНХАУ-ын төмөр замын дэд бүтэцтэй холбох техникийн шийдлийн талаар хэлэлцэж, санал солилцсон.<br>Хятадын талаас хариу ирүүлэхийг хүлээж байна. | | |
| 55 | **2022_459. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай / 2022-12-12 /** | 3. “Тавантолгой төмөр зам” ХХК-д онцгой дэглэм тогтоосон хугацаанд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараахь албан тушаалтанд даалгасугай: 3.1. компанийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоож шинэчлэх, шаардлагатай бол бүтцийн нэгжийн удирдлага, холбогдох албан тушаалтныг томилж, чөлөөлөхийг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Н.Мягмарт; 3.2. компанийн хөдөлмөрийн дотоод журам болон үйлдвэрлэл, тээвэр, технологийн тухайлсан дүрэм, үйлдвэрлэлийн осол, аюулгүй ажиллагааны тусгай журам тогтоож, тэдгээрийг зөрчигчдөд зохих хариуцлага хүлээлгэж ажиллахыг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Н.Мягмарт; | 3.1. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022.12.30-ны өдрийн ээлжит хурлаар Гүйцэтгэх захирал Н.Удаанжаргалтай байгуулсан /КГ-01/45/01/ дугаар контрактын гэрээг 2022.12.12-ны өдрөөр цуцлан, үүрэгт ажлаас чөлөөлсөн.<br>Мөн хурлаар “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан компанийн зохион байгуулалтын бүтэц дэх “Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба”-ыг “Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн Ажлын алба” болгон өөрчилж Ажлын алба болон Захиргаа удирдлагын газрын даргыг томилсон. Цаашид компанийн 2023 оны төсвийн төсөл, хүрэх үр дүн, үйл ажиллагааны төлөвлөгөөг бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн хамт 2023 оны нэгдүгээр сард багтаан ТУЗ-өөр батлуулах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг төлөвлөж байна. Үүнд: Кемп нүүлгэх, ажилчдын хоол, унаа, тээврийн үйл ажиллагааг гүйцэтгэх бусад бүхий л хэвийн нөхцөлийг хангах зэрэг болно. Компанийн өмнө гаргасан зөрчилтэй тушаал, гэрээ, хэлцэл, албан тоотыг хууль зүйн зөрчилгүй болгох, үр дагаврыг нь арилгах, цуцлах ажил хийгдсэн. Үүнд 32 ажилтантай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээг цуцалж, худалдан авалтын зарим гэрээг үргэлжлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн. Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн ажлын төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан.<br>3.2. ХАБЭА-н чиглэлээр 2022 онд байгууллагын хөдөлмөрийн Дотоод журам, холбогдох дүрэм, | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | журам, заавруудыг чанд мөрдөн ажилласнаар Үйлдвэрлэлийн осол, аюулгүй ажиллагааны тусгай журам зөрчигдсөн тохиолдол гараагүй.<br>- 2022 оны 12 дугаар сард ХАБЭА болон Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр ээлжит бус давтан зааварчилгаа нийт ажилтнуудад өгч, ажлын байруудад үзлэг шалгалт бүрэн хийсэн.<br>- Компанийн “ХАБЭА-н удирдлагын тогтолцоо”-г шинэчилж, үйл ажиллагааны бүхий л үе шатанд сахилга хариуцлагыг сайжруулж ажиллах тухай А/04 тушаал батлуулж, мөрдөн ажиллаж эхэлсэн | | |
| 56 | **2022_459. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай / 2022-12-12 /** | 3.3. . Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд зарцуулсан хөрөнгөд хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах, хууль зөрчсөн, ашиг сонирхлын зөрчилтэй, компанийн эрх ашигт нийцээгүй гэрээ хэлцэл, үйл ажиллагаар хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Н.Мягмар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт; | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд зарцуулсан хөрөнгөд хөндлөнгийн аудит хийлгэх тухай 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 1/1480 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 01/2067 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газраас Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоолыг үндэслэн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналыг олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв тайлагнасан эсэхэд аудит хийж, дүгнэлт гаргах, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд аудит хийж дүгнэлт гаргах хяналт шалгалтын үйл ажиллагаа явагдаж байгаа талаар хариу ирүүлсэн. | 70% | |
| 57 | | 3.4. “Богдхан” төмөр зам төсөл болон “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний | Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн №94 тоот тушаалаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэлээр | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилт, худалдан авах ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Брямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Төрийн худалдах авах ажиллагааны газар (Ц.Батзул) нарт; | ахлуулсан ажлын комисс "Тавантолгой-Зүүнбаян'', "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төсөл, "Богдхан" төмөр замын төслийн хэрэгжилтэд болон "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн үндсэн болон Санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажил 2022.12.30-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаанд хийгдсэн. Тайлан боловсруулж, нэгтгэх шатанд явж байна. | | |
| 58 | **2022_459. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай / 2022-12-12 /** | 3.5. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын тээврийн үйл ажиллагаа болон галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бүхий л үе шатанд хяналтыг сайжруулах, шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Н.Мягмарт, энэ чиглэлээр бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод; | 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 17 удаа галт тэрэг аялуулж 22595.5тн, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 28 удаа галт тэрэг аялуулж 35416.9 тн ачаа тээвэрлэсэн.<br>Галт тэрэгний хөдөлгөөнийг оновчтой зөв зохион байгуулж, хөдөлгөөний аюулгүй байдалд байнгын хяналт тавьж, чиглэл өгч ажиллаж байна.<br>1.Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг сар бүрээр гаргаж биелэлтийг тухай бүр ханган ажиллаж, графикийн дагуу зам шалгалтын ажлыг үр дүнтэйгээр дараах байдлаар хийж байна. Үүнд:<br>- Замын техникийн ерөнхий байдалд явганаар тууш үзлэг хийх;<br>- Зам хэмжигч вагоноор үзлэг хийх;<br>- ПТ7-МК тэргэнцэрээр үзлэг хийх;<br>- Сэв шалгах тэргэнцэр РДМ-22 үзлэг хийх;<br>- Хориг хашааны үзлэг хийх;<br>- Зам шалгалтаар илэрсэн дутагдлуудыг тухай бүрд нь засварлаж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж байна.<br>2.Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд нэн шаардлагатай байгаа Тавантолгой өртөө болон Цогтцэций өртөө хооронд галт тэрэг солилцох | 100% | хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | журмыг шинэчлэн боловсруулж, "МТЗ" ТӨХК-д танилцуулсан.<br>3.Эрдэнэс Тавантолгой ХК болон Тавантолгой төмөр зам ХХК-ууд хооронд байгуулсан 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн “Төмөр замаар ачаа тээвэрлэх түр гэрээ”-г дүгнэх, гүйцэтгэлийг хянах хүсэлтийг 1/1509 тоот албан бичиг, 2023 онд Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлийн төмөр замаар ачаа тээвэрлэх гэрээний төслийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулан 1/1537 тоот албан бичгээр “ЭТТ” ХК-д тус тус хүргүүлсэн.<br>4. “УБТЗ”ХНН-тэй байгуулсан ТГ/22/307 тоот Зүтгүүр түрээсийн гэрээнд нэмэлт өөрчлөлтийг оруулж, гэрээний 2.1 дэх заалтыг 2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2023 оны 01-р сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэхээр түрээсийн хугацааг сунгасан. | | |
| 59 | **2022_459. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай / 2022-12-12 /** | 4. Энэ тогтоолын хэрэгжилт, “Тавантолгой төмөр зам” ХХК-д тогтоосон онцгой дэглэмийн үр дүн, явц байдлыг сар бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, тодорхой чиглэл авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Брямбацогтод, онцгой дэглэмийн хугацаанд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хяналт шалгалт тэдгээрийн үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлж байхыг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Н.Мягмарт тус тус даалгасугай. | Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгчөөр Н.Мягмар томилогдсоноос хойших 1 сарын хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлуудыг багцлан, компанийн сайт, facebook page, бусад салбарын сайт, facebook page-ээр дараах мэдээллийг бэлтгэн түгээв.<br>1. Мэдээ: “30 хоногт” хийгдсэн ажлууд<br>2. Постер: “30 хоногт” – тус бүр агуулга бүхий 10 постер,<br>3. Шторк: “30 хоногт” видео хэлбэрээр бэлтгэн түгээв,<br>4. “ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ХОЛБОЛТЫН ТӨМӨР ЗАМЫН АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА“ ярилцлагыг Өнөөдөр сонин, Өдрийн сонин, Ганзам сонин-д хийж хэрэгжүүлсэн ажлуудын талаар ярилцлага нийтлэгдсэн. | 70% | |

| 2Е.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 60 | **2021_11. 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл / 2021-02-17 /** | XII.12. 6. Зүүнбаян-Ханги чиглэлийн болон Богдхан төмөр замыг барьж байгуулах төслийг Оросын талтай хамтран хэрэгжүүлэх талаар судалж, Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт; | 1. Зүүнбаян Ханги чиглэлийн төмөр замын барилгын ажил дуусч, 2022.11.25 ашиглалтад оруулсан.<br>2. Богдхан төмөр замын талаар Засгийн газрын 2022 оны 12 сарын 21-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 62 дугаар тэмдэглэлийн 3 дахь заалтаар Богдхан төмөр замын төслийг Улаанбаатар төмөр зам ХНН-ээр хариуцуулан гүйцэтгүүлэх тухай дараагийн шатны үүрэг даалгавар өгсөн. | 100% | хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| 61 | **2021_19. 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл / 2021-03-24 /** | XYI.5.2. Концессын гэрээ байгуулсан төслийн гүйцэтгэлд байнгын хяналт тавих талаар Концессын тухай хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллахыг холбогдох сайд нарт үүрэг болгов. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 28 тогтоолоор Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийг концессын тухай хуулийн дагуу шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлэх “Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам” төслийн концессын гэрээг “Монголиан транс лайн” ХХК болон “Монголиан транс ложистик” ХХК-ийн нэгдэлтэй байгуулах эрхийг 2022 оны 3 дугаар сарын Засгийн газрын хуралдаанаар олгосон. Зүүнбаян-Ханги чиглэлийн 226.9 километр төмөр замын дээд, доод бүтцийн барилгын ажил дуусаж, 2022.11.25-нд нээлтээ хийсэн. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийн дээд, доод бүтцийн барилга, угсралтын ажлыг шалгах Техникийн комиссыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022.11.18-ны А/299 дугээр тушаалаар байгуулж, 2023 оны 01 дүгээр сарын 16-наас 19-ний хооронд газар дээр нь ажилласан. | 100% | Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төсөл амжилттай хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| 62 | **2021_58. 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 58 дугаар** | XII.6.7. Төмөр замын бүх төрлийн ачааны вагоныг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас, дотооддоо үйлдвэрлэж, | Төмөр замын бүх төрлийн ачааны вагоныг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудал Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудал тул Эдийн засгийн сэргэлтийг | 100% | 1.Төмөр замын ачааны вагоныг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх асуудлыг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **тэмдэглэл / 2021-11-03 /** | борлуулсан ургамлын тосыг нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлөх асуудлыг судалж саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт; | эрчимжүүлэх тухай хуулийн төсөл болон Газрын тосны тухай хуулийн төсөлд уг саналаа тусган, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2021 оны 01/593 тоот албан бичгээр хүргүүлсэн. Улсын Их Хурлын хаврын чуулган 2022 оны 03 сард хэлэлцүүлэгдсэн. Газрын тосны тухай хуулинд 2022.04.22 нэмэлт өөрчлөлт батлагдсан ба төмөр замын ачааны вагон гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөөгүй. | | холбогдох хуулийн төсөлд санал өгсөн боловч дэмжигдээгүй. 2. Коронавируст цар тахлын үед БНХАУ-ын талаас задгай вагоноор нурмаг ачаа хүлээж авахгүй гэдгээ мэдэгдсэний дагуу тавцант вагоны эрэлт нэмэгдэж, Монгол Улсад худалдаж болон түрээслэн оруулж ирэх вагоныг гааль, татвараас чөлөөлөх шаардлагатай болсон. Гэвч тухайн үед гааль, татвараас чөлөөлөх тухай асуудлыг хуулийн төслүүдэд тусган, Засгийн газарт хүргүүлж байсан боловч шийдвэрлэгдээгүй.<br>Тухайн цагаас хойш Монгол Улсад оруулж ирсэн тавцант болон бусад төрлийн вагоны тоо эрс нэмэгдэж, өнөөдрийн байдлаар 12200 орчим төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, үүнээс 3200 орчим нь тавцант вагон байна. Иймд Төмөр замын бүх төрлийн ачааны вагоныг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг хяналтаас хасуулах саналтай байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 63 | **2022_16. 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл / 2022-03-16 /** | XYIII.4.2. Концессын зураг, төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх нөхцөлтэй гэрээгээр хэрэгжүүлэх Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын бэлтгэлийг богино хугацаанд хангаж, энэ оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал О.Батнасан нарт. | Монголын төмөр зам ТӨХК нь Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төсөлд хамтран ажиллах сонирхол бүхий этгээдийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулж, сонирхогч байгууллагад урилга хүргүүлж, 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр хүртэл 11 материал хүлээн авсан. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг явуулж, Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн буюу Баруун босоо чиглэлийн төмөр замын төсөлд “Эссенз Саплайз” ХХК, Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт буюу Зүүн босоо чиглэлийн төсөлд “Ийст коридор рэйлрөүд” ХХК, “Бодь интернэшнл” ХХК-иуд сонгогдсон. 2022.12.28-ны өдөр МТЗ ТӨХК-иас дээрх компаниудтай уулзалт зохион байгуулан хэлэлцээрийн саналыг тус яаманд ирүүлсэн ба албан бичигт тусгагдсан саналуудтай танилцан холбогдох саналыг өгч, хэлэлцээр хийх ажлыг эрчимжүүлэх чиглэлийг албан бичгээр хүргүүлсэн. Үүний үр дүнд хөрөнгө оруулж хамтран ажиллахаар сонгогдсон байгууллагуудтай гэрээ байгуулахаар гэрээний нөхцөлүүдээ тохирч Зам, тээврийн хөгжлийн яаманд хянуулах, санал авахаар ирүүлээд байна. Мөн тус төслүүдийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын даалгаварын төсөл, төслүүдийн ажлын төлөвлөгөөг батлуулахаар ажиллаж байна. | 70% | |
| 64 | **2022_32. 2022 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 32 дугаар тэмдэглэл / 2022-06-08 /** | XY.7. . Монгол Улсын Сангийн яам, БНХАУ-ын Хөгжил, шинэчлэлийн хороотой 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хийсэн цахим уулзалтын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй | Монголын төмөр зам” ТӨХК нь Шивээхүрэн-Сэхэ төмөр замын боомтын төмөр замын урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж Хятадын талд хүргүүлэхээр 2022.10.24-ний 01/1601 дугаар албан бичгээр Сангийн яамны ТНБД-д хүргүүлсэн. Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтод хил дамнасан байгууламж болох төмөр замын бүтээн | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | холбогдуулан: 1. Шивээхүрэн-Сэхэ төмөр замын боомтын бүтээн байгуулалтын төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж дуусган холбогдох баримт бичгийг Хятадын талд хүргүүлэхийг “Монголын төмөр зам” ТӨХК (П.Ганхүү)-д, төслийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт даалгав; | байгуулалтын ажлыг Засгийн газрын 2018 оны 232 дугаар тогтоолын дагуу хэрэгжүүлэх талаар Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн шуурхай хуралдаанаар "МТЗ" ТӨХК-д үүрэг болгов. Энэ хүрээнд "Нарийнсухайтын төмөр зам" ХХК-тай хамтран "Шивээхүрэн төмөр зам" ХХК-г байгуулах, Засгийн газрын 2022 оны 446 дугаар тогтоолыг хэрэгжүүлж хятадын талтай техник технологийн нөхцөлийг тохирох яриа хэлэлцээ хийх зэрэг ажлууд эхлүүлэхээр "Монголын төмөр зам" ТӨХК ажиллаж байна. | | |
| 65 | **2022_54. 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дугээр тэмдэглэл / 2022-11-09 /** | Х.8.8. Хилийн Гашуунсухайт боомтоор нэвтрэх автомат удирдлагатай чингэлэг тээврийн хэрэгслийн тоог 2 дахин нэмэгдүүлэх арга хэмжээ авах, хилийн Шивээхүрэн, Ханги, Замын-Үүд, Булган, Гашуунсухайт боомтоор өдөрт гарах авто тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлж, валютын бодит орлого нэмэгдүүлэх зорилгоор нүүрс тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга бөгөөд Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын үүрэг хариуцагч Д.Амарбаясгалан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт; | 1. 2022 оны 10 сард Гашуунсухайт боомтоор өдөрт 60 тээврийн хэрэгсэл гардаг байсныг Хилийн нэвтрэх автомат удирдлагатай чингэлэг тээврийн хэрэгслийн тоог 2 дахин нэмэгдүүлсэнээр одоо өдөрт 120 тээврийн хэрэгсэлээр 240 чингэлэг гарч байна.<br>2. Хилийн Шивээхүрэн, Ханги, Замын-Үүд, Булган, Гашуунсухайт боомтоор өдөрт гарах авто тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлж, валютын бодит орлого нэмэгдүүлэх зорилгоор нүүрс тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулж ажилласанаар 2022 онд БНХАУ-руу дараах боомтуудаар тээврийн хэрэгсэл нэвтэрсэн байна. Үүнд:<br>- Булган 34499 тээврийн хэрэгсэл, 2021 онтой харьцуулахад 222.59%<br>-Гашуунсухайт 109383 тээврийн хэрэгсэл, 2021 онтой харьцуулахад 138.63%<br>- Шивээхүрэн 34981 тээврийн хэрэгсэл, 2021 онтой харьцуулахад 91.18%<br>-Замын-Үүд 29124 тээврийн хэрэгсэл 2021 онтой | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | харьцуулахад 108.88% тус тус өссөн үзүүлэлттэй байна. | | |
| 66 | **2022_54. 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл / 2022-11-09 /** | Х.8.10. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн экспортын бүтээгдэхүүнийг төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглан төмөр замын тээвэрлэлтийг зохион байгуулж, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т; | “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн экспортын бүтээгдэхүүнийг төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглан төмөр замын тээвэрлэлтийг зохион байгуулж, экспортыг нэмэгдүүлэх талаар дараах арга хэмжээ авч ажилласан. Үүнд:<br>1. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн төмрийн хүдрийн ачилтыг “МТЗ” ТӨХК-ийн Төмөртэй өртөөнөөс 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлж, 2022 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар 420 вагон 28862 тонн экспортын төмрийн хүдэр ачиж, тээвэрлэсэн. Үүнээс 2022 оны 12 дугаар сард 250 вагон 17132 тонныг ачсан.<br>2. “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ийн зэсийн баяжмалын тээвэрлэлтэд 100 хувь “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн эзэмшлийн вагоноор хангаж байгаа бөгөөд 11 зүгээр сард 849 вагон 56.6 мянган тонн, 12 дугаар сарын эхний 27 хоногийн байдлаар 806 вагон 53.9 мянган тонн зэсийн баяжмал ачиж, тээвэрлээд байна.<br>3.“Монголросцветмет” ТӨҮГ-ын экспортын бүтээгдэхүүний тээвэрт “ДТҮ” ТӨҮГ /ЗТИ/ болон БТЕГ-ын вагоныг ашиглаж байгаа бөгөөд 11 зүгээр сард 296 вагон 19.4 мянган тонн, 12 дугаар сарын эхний 27 хоногийн байдлаар 288 вагон 18.3 мянган тонн төмрийн хүдэр ачиж, тээвэрлээд байна.<br>4.“Тавантолгой төмөр зам” ХХК нь өөрийн эзэмшлийн 100 хагас вагоноо “Мүгэн Логистик” ХХК болон “Жи Ар Капитал Логистик” ХХК-д тус тус ашиглуулж байсан түрээсийн гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгох мэдэгдлийг 2022.12.22-ны өдрийн 1/1501, 1/1500 тоот бичгээр | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | мэдэгдсэн бөгөөд нэг талын санаачилгаар цуцлах мэдэгдлийн хугацаа 2023.01.02-ны өдөр дууссан. 5. 2023.01.18-ны Засгийн газрын хуралдаанд Төмөр замын экспортын тээвэрлэлтийн талаар танилцуулсан. | | |
| 67 | **2022_54. 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл / 2022-11-09 /** | X.13. . Төмөр замын бүтээн байгуулалт, шинэчлэлтийн зарим төсөлд Оросын Холбооны Улстай хамтран ажиллах талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын хуралдаанд оролцох үеэр “Богдхан” төмөр замын бүтээн байгуулалт болон “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Сайншанд-Зүүнбаян чиглэлийн төмөр замын засвар, шинэчлэлтийн төслийг хамтран хэрэгжүүлэх талаар оросын талтай санал солилцож, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгав. | Богдхан төмөр зам төслийг оросын талтай хамтран хэрэгжүүлэх асуудлаар Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын хуралдаанд оролцох үеэр санал хүргүүлсэн. Мөн ТЭЗҮ-ийг оросын талд албан ёсоор хүргүүлсэн. “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Сайншанд-Зүүнбаян чиглэлийн төмөр замын засвар, шинэчлэлтийн төслийг тус нийгэмлэгийн 2023 оны үйлдвэрлэл-санхүүгийн төлөвлөгөөнд тусгасан. | 70% | |
| 68 | **2022_56. 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр 56 дугаар** | XIX.1. . “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 362 дугаар тогтоолын хэрэгжилт, | Уул уурхайн олборлолт, экспортын үйл ажиллагаар хэвийн явуулахад шаардлагатай дизель түлшний тээвэрлэлтийг шуурхай зохион байгуулж ажиллаж байна. АМГТГ-т төмөр замын тээврийн мэдээг хоног тутам 3 байдлаар гаргаж өгч байна. Үүнд: тухайн өдөр импортоор орж ирсэн | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **тэмдэглэл / 2022-11-23 /** | цаашид авах арга хэмжээний талаар Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтанд даалгав: 1.1. Уул уурхай олборлолт, экспортын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай дизель түлшний тээвэрлэлтийг шуурхай зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод; | шатахууны мэдээ, тухайн төмөр замаар тээвэрлэгдэж буй шатахууны байршил, хүлээн авагчийн мэдээлэл, мөн тухайн өдөр Толгой өртөөнд байгаа шатахуунтай вагоны дэлгэрэгүй мэдээллийг гаргаж өгч байна. УУХҮЯ, ЗТХЯ, АМГТГ, "УБТЗ" ХНН болон шатахуун импортлогч ААН-үүд хамтарсан вайбер групп үүсгэн шатахууны шуурхай буулгахад харилцан хяналттай, анхаарч ажиллаж байна.<br><br>2022 оны 12-р сарын эхний 29 хоногийн байдлаар нийт 1689 вагон 102.1 мянган тонн дизелийн түлш импортолсон. /БНХАУ-аас 385 вагон 21.3 мянган тонн, ОХУ-аас 1304 вагон 80.8 тонн дизелийн түлш хүлээн авсан./ Толгойт өртөөнд 2022.12.30-ны 08-00 цагийн байдлаар буулгалтад 36 цс дизелийн түлш байгаагаас 27 цс нь ээлжинд бууж, 9 цс үлдэнэ. Төмөр зам тээвэрлэж шатахуун импортлогч нар түгээлтийг хариуцан ажилладаг болно. | | |
| 69 | **2022_56. 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр 56 дугаар тэмдэглэл / 2022-11-23 /** | XIX.1.4. "Монголросцветмет" ТӨҮГ-ын экспортын бүтээгдэхүүнийг тээвэрлэх төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, "Улаанбаатар төмөр зам" ХНН (Х.Хэрлэн), "Монголросцветмет" ТӨҮГ (Б.Мөнхбат)-т; | "Монголросцветмет" ТӨҮГ-ын экспортын бүтээгдэхүүнийг төмөр замаар тээвэрлэхэд шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүний асуудлыг шийдвэрлэх зорилгоор "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн эзэмшлийн 100 ширхэг хагас вагоныг тус компанид 2023.01 дүгээр сараас эхлэн түрээслүүлсэн. Мөн Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн мэдэлд байгаа 250 ширхэг хүртэлх ачааны хагас вагоныг "Монголросцветмет" ТӨҮГ-т түрээслүүлэх боломжтой байна. | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| 70 | **2022_56. 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр 56 дугаар** | XIX.1... Төмөр замын ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэж байгаа галт тэрэгний зүтгүүр болон хөдлөх бүрэлдэхүүний тоо, тэдгээрийн аж ахуйн нэгж, | Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар Төмөр замын экспортын тээвэрлэлтийн талаар танилцуулах үед галт тэрэгний зүтгүүр, хөдлөх бүрэлдэхүүний тоо зэрэг төмөр замын ачаа тээвэрлэлтийн нөхцөл байдал | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **тэмдэглэл / 2022-11-23 /** | байгууллага дахь хуваарилалтыг гаргах, галт тэрэгний зүтгүүр худалдан авах үнэ, нөхцөл, боломжийг судлан танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Улаанбаатар төмөр зам” ХНН (Х.Хэрлэн)-т. | танилцуулагдсан ба 4 дүгээр тэмдэглэлээр 4 зүтгүүр худалдан авах асуудлыг судалж танилцуулах үүргийг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал П.Ганхүүд даалгасан. | | |
| 71 | **2022_58. 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл / 2022-12-07 /** | XXI.1. . “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтанд даалгав: 1. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын үйл ажиллагаанд төмөр замын ачаа тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, галт тэрэгний хүртээмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөөг гарган холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Улаанбаатар төмөр зам” ХНН (Х.Хэрлэн)-д; | Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын үйл ажиллагаанд төмөр замын ачаа тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах галт тэрэгний хүртээмжийг нэмэгдүүлэхээр авах арга хэмжээний талаар 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 2023 оны 4 дүгээр тэмдэглэл гарсан. | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| 72 | **2022_62. 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 60 дугаар** | XYI.2. . Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Эдийн засаг, | Засгийн газрын 2022 оны 362 дугаар "Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийн талаар 2023.01.18-ний өдрийн Засгийн газрын | 100% | Хэрэгжсэн, Дараагийн шатны үүрэг өгөгдсөн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **тэмдэглэл / 2022-12-21 /** | хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Тавантолгойн уурхайгаас Гашуунсухайт хилийн боомт хүртэлх нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах санал боловсруулж Засгийн газарт танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын үүрэг хариуцагч Х.Нямбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат нарт даалгав. | хуралдаанаар танилцуулж, 4 дүгээр тэмдэглэлийн 3 дах заалтаар Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Ханги чиглэлийн төмөр замын ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэхэд шаардлагатай 4 зүтгүүр худалдан авах асуудлыг судалж, танилцуулахыг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал П.Ганхүүд даалгасан. | | |
| 73 | **2022_62. 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 60 дугаар тэмдэглэл / 2022-12-21 /** | 3. “Богдхан төмөр зам” төслийг “Улаанбаатар төмөр зам” ХНН-ээр хариуцуулан гүйцэтгүүлэх, тус төмөр замын шугамыг эцэслэн тохирох чиглэлээр оросын талтай ажиллаж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт; | Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 62 дугаар тэмдэглэлийн 3 дугаар заалтад “Богдхан” төмөр зам төслийг “Улаанбаатар төмөр зам” ХНН-т хариуцуулсан. Үүний дагуу тус нийгэмлэгийн Замын даргын А/25 дугаартай тушаал гарч “Богдхан” төмөр зам төслийн трассыг судалж байна. Түүнчлэн уг төслийн ТЭЗҮ-ийг оросын талд албан ёсоор хүргүүлсэн бөгөөд хамтран хэрэгжүүлэх эсэх асуудлаар хариу хүлээж байна. | 70% | |
| **3.Усан замын салбар** | | | | | |
| **3А.Монгол Улсын хууль** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 74 | **2017.07.01. Усан замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/** | 5.1.1. Усан замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлогыг батлах; (5.1.Засгийн газар усан замын тээврийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Монгол Улсын авто замын салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг баталж, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын хүрээнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6.6-д “Эдийн засаг болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр” болох УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогод Усан замын тээврийн асуудал тусгагдаагүй. | Хугацаа болоогүй | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Эдийн засаг, дэд бүтцийн нэг бодлого батлахаар хуульчилж, Авто зам/Усан замын тээврийн талаар тусгайлан бодлого батлах шаардлагагүй тул хяналтаас хасуулах. Мөн Эдийн засгийн болон дэд бүтцийн зорилтот хөтөлбөр батлагдсан тул хяналтаас хасуулах. |
| 75 | | 6.1.7.. Усан замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ, тарифын аргачлалыг боловсруулах, хяналт тавих; | "Усан замын зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ, тарифын аргачлал"-ыг 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн сайдын А/228 дугаар тушаалаар батлуулсан. Тушаалаар батлагдсан аргачлалын талаар Далайн захиргаа УТҮГ-ын усан замын тээврийн хяналтын байцаагч нар хөвөлтийн улирал эхлэх үед 2022 оны 06 дугаар сард усан замын тээврийн үйл ажиллагаа эрхлэгч нийт 64 иргэн, аж ахуйн нэгжэд танилцуулж, заавар зөвлөмж өгч ажилласан. | 100% | Уг аргачлал батлагдсан, хөвөлтийн улиралд усан замын тээврийн хэрэгслээр зорчигчдын аюулгүй байдалд хяналт тогтмол тавьж ажилладаг тул хяналтаас хасуулах. |
| 76 | | 10.1.. Усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн шаардлагыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 17-ны А/179 дугаар тушаалаар "Усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн шаардлага"-ыг батлуулсан | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| 77 | **2022.07.01. Далай ашиглах тухай** | 10.2. Энэ хуулийн 10.1-д заасан дугаар олгох журмыг Далайн захиргаа батална. (10.1.Далайн | Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам болон Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн хүчинтэй байх | Хугацаа болоогүй | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **/Шинэчилсэн найруулга** | захиргаа хөлөг онгоцонд хиймэл дагуулын холбооны болон хөлөг онгоцны дуудлагын дугаар олгоно.) | хугацааг сунгах, бүртгэлийг цуцлах, далбааны эзэн улсын хяналт тавихтай холбоотой үйлчилгээний төлбөрийн хэмжээний доод хязгаар тогтоосон журмыг тус тус Засгийн газар батлсны дараа уг журмыг Далайн захиргаа батална. | | |
| 78 | | 22.3. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журмыг Засгийн газар батална. | АНУ-ын техникийн туслалцааны хүрээнд хэрэгжүүлж буй Төрийн департмент, Сандиа үндэсний лабораториас зохион байгуулсан “Монгол Улсын хөлөг онгоц бүртгэлийн хориг арга хэмжээний эрсдэлийн удирдлага” сургалтад Зам, тээврийн хөгжлийн яамны Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтэс болон Далайн захиргааны холбогдох мэргэжилтнүүд 2022 оны 12 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд хамрагдсан. Тус сургалтын үеэр сүүлийн үед үүсээд буй дайны нөхцөл байдалтай холбогдуулан АНУ, Европын холбоо, ОУ-ын далайн байгууллагаас гаргасан улс орнуудад тавьсан хориг, шинэчлэн гаргасан бодлого зэргээс үүдэн “Монголын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам”-ын төсөлд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн. Ийнхүү Монголын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журмын төсөл, нөлөөллийн шинжилгээ, танилцуулгад дээрх шинэчилсэн бодлогыг тусгахаар дахин боловсруулж, Засгийн газраар батлуулах шатанд ажиллаж байна. | 30% | |
| 79 | | 22.6. Хөлөг онгоцны бүртгэлийн түр болон байнгын гэрчилгээ, хөлөг онгоц дангаар түрээслэх бүртгэлийн гэрчилгээ, баталгаажуулах гэрчилгээ зэрэг бүртгэлтэй холбоотой бусад баримт бичгийн загварыг Далайн захиргаа батална. | Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам болон Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгах, бүртгэлийг цуцлах, далбааны эзэн улсын хяналт тавихтай холбоотой үйлчилгээний төлбөрийн хэмжээний доод хязгаар тогтоосон журмыг тус тус Засгийн газар батлсны дараа гэрчилгээний загварыг Далайн захиргаа батална. | Хугацаа болоогүй | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 80 | | 23.5. Бүртгэлийн дугаар хөтлөх журмыг Далайн захиргаа батална. | Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам болон Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгах, бүртгэлийг цуцлах, далбааны эзэн улсын хяналт тавихтай холбоотой үйлчилгээний төлбөрийн хэмжээний доод хязгаар тогтоосон журмыг тус тус Засгийн газар батлсны дараа Бүртгэлийн дугаар хөтлөх журмыг Далайн захиргаа батална. | Хугацаа болоогүй | |
| 81 | | 26.3. Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагыг томилох, түүний ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүн шинжилгээ хийх, үйл ажиллагааг хянан зохицуулах журмыг далайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. | Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагыг томилох, түүний ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүн шинжилгээ хийх, үйл ажиллагааг хянан зохицуулах журмыг боловсруулан эцэслэн хянуулсан. Журмыг сайдаар батлуулах шатанд ажиллаж байна. | 30% | |
| 82 | | 28.4. Хяналтын улсын байцаагч нь дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх бөгөөд дүрэмт хувцасны загвар, ялгах тэмдгийг далайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. | Хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцасны загвар, ялгах тэмдгийг шинээр боловсруулсан. Холбогдох журмын дагуу батлуулахаар ажиллаж байна. | 30% | |
| 83 | | 29.10. Далбааны эзэн улсын хяналт, шалгалт хийх журмыг далайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. | Далбааны эзэн улсын хяналтын үзлэг, шалгалт явуулах журмыг боловсруулан эцэслэн хянуулсан. Журмыг сайдаар батлуулах шатанд ажиллаж байна. | 30% | |
| 84 | | 32.2. Хөлөг онгоцыг алсын зайнаас хянах үйл ажиллагааны журмыг далайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. | Хөлөг онгоцыг алсын зайнаас хянах үйл ажиллагааны журмыг шинээр боловсруулсан. Холбогдох журмын дагуу батлуулахаар ажиллаж байна. | 30% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 85 | | 33.6. Далайн осол, зөрчлийг шинжлэн шалгах журмыг далайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. | Далайн тээврийн осол, зөрчлийг шинжлэн шалгах журмыг шинээр боловсруулсан. Холбогдох журмын дагуу батлуулахаар ажиллаж байна. | 30% | |
| 86 | | 22.4. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгах, бүртгэлийг цуцлах, далбааны эзэн улсын хяналт тавихтай холбоотой үйлчилгээний төлбөрийн хэмжээний доод хязгаарыг Засгийн газар тогтооно. | АНУ-ын техникийн туслалцааны хүрээнд хэрэгжүүлж буй Төрийн департмент, Сандиа үндэсний лабораториас зохион байгуулсан “Монгол Улсын хөлөг онгоц бүртгэлийн хориг арга хэмжээний эрсдэлийн удирдлага” сургалтад Зам, тээврийн хөгжлийн яамны Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтэс болон Далайн захиргааны холбогдох мэргэжилтнүүд 2022 оны 12 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд хамрагдсан. Тус сургалтын үеэр сүүлийн үед үүсээд буй дайны нөхцөл байдалтай холбогдуулан АНУ, Европын холбоо, ОУ-ын далайн байгууллагаас гаргасан улс орнуудад тавьсан хориг, шинэчлэн гаргасан бодлого зэргээс үүдэн “Монголын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам”-ын төсөлд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн. Ийнхүү Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх, далбааны эзэн улсын хяналт тавихтай холбоотой үйлчилгээний төлбөрийн хэмжээний доод хязгаар тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг дахин боловсруулж, Засгийн газраар батлуулах шатанд ажиллаж байна. | 30% | |
| 87 | | 5.1.3. Олон Улсын Далайн Байгууллагын конвенц, зөвлөмжийн хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Олон Улсын Далайн Байгууллагад хүргүүлэх; (5.1.Далайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв | Хууль батлагдсанаас хойших хоёр жилийн хугацаанд хийгдэх тул хугацаа болоогүй. | Хугацаа болоогүй | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:) | | | |
| **4.Автотээврийн салбар** | | | | | |
| **4а. УИХ-ын тогтоол** | | | | | |
| 88 | **2021 №12. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай** | ЗТХЯ УИХ-ын тогтоолын төсөл 2021. "Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалтыгтогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай"Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 05 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай | “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоолд нэмэлт оруулах хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 02/3715 тоот албан бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн газрын 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан хэдий ч салбарын сайд уг асуудлыг буцаан татсан учир хэлэлцүүлэгдээгүй түр хугацаагаар хойшлогдоод байна. | 30% | |
| **4б. Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж** | | | | | |
| 89 | **2014_52/30. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай / 2014-10-20** | 2.6. Авто тээврийн хэрэгслээс үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах асуудлын хүрээнд олон улсын стандартад нийцсэн сайн чанарын шатахууны хэрэглээг дэмжих, тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх, нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх | Автотээврийн хэрэгслээс үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах асуудлын хүрээнд хэрэгжүүлэх дээрх 3 арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд: 1. Нийслэлийн 2022 оны төсөвт нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлт, төлбөрийн системийн шинэчлэлтэд 77 тэрбум 260 сая төгрөг батлагдсан. 2022 онд 100, 2023 он гарснаас хойш шинээр 117 дизель хөдөлгүүр бүхий автобусыг тус тус импортоор оруулж ирэн нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглаж байна. 2. Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх хүрээнд: 2.1. Тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналт, авто үйлчилгээ, татвар, даатгалын байгууллагуудтай Төрийн мэдээлэл солилцох ХУР системийг ашиглан "Тээврийн хэрэгслийн бүртгэл, | 100% | Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд 1. нийтийн тээврийн чанар хүртээмж сайжруулах, нэмэгдүүлэх асуудал 2021 оны 07 дугаар сард батлагдсан Улаанбаатар хотын Эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.11-д "авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нийслэл хотод тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэхэд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хяналтын үзлэгийн мэдээллийн нэгдсэн сан"-ийн мэдээллийг солилцож, Нээлттэй өгөгдөл opendata.gov.mn-д тухай бүр шинэчлэлт хийгдэж байна.<br>2.2. Тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх Улаанбаатар хот тойрсон Авто замын төлбөр авах 5 цэг/Эмээлт, Налайх, Хоолт, Түргэн болон Хөшгийн хөндийн/-ийг цахимжуулсан.<br>2.3. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021.12.02-ны С/60 тушаалаар MNS ISO 29160:2021- Мэдээллийн технологи, Зүйлсийн удирдлагын радио давтамжийн танилт- RFID тэмдэг (Үндэсний болгох) стандартыг батлуулсан. Засгийн газрын 2022.09.28-ны өдрийн хуралдаанаар Нийтийн тээврийн асуудал хэлэлцэгдэж, 47 дугаар тэмдэглэлээр Автотээврийн хэрэгслийн гэрчилгээг цахимжуулах ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 03-ны дотор хэрэгжүүлэх үүрэг өгсөн.<br>3. Олон улсын стандартад нийцсэн сайн чанарын шатахууны хэрэглээг дэмжих асуудлыг чиг үүргийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, түүний харьяа Ашигт малтмал, газрын тосны газар Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үлдэгдэл, нөөц бүрдүүлэн ажилладаг. | | чиглэсэн төсөл, арга хэмжээ" авах нь Нийслэл хотын чиг үүрэг; 2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор "Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр" /2020-2024/-ийг хүчингүй болгосон; 3. Сайн чанарын шатахууны хэрэглээг дэмжих асуудал Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20.5.16-д Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх "газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлого"-ын асуудал тул хяналтаас хасуулах. |
| **4г. Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 90 | **2022_204. Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай / 2022-05-25** | 6. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар олгох арга хэмжээг 2022 онд багтаан зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, | "Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг 1-р хэсэг Ерөнхий шаардлага" MNS4410-1:20021 стандартад "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд хар хөх өнгийн дэвсгэртэй дугаар олгох" нэмэлт өөрчлөлтийг Автотээврийн стандартын техникийн хорооны 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хэлэлцэн батлав. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн С/04 дүгээр тушаалаар "Автотээврийн хэрэгслийн | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгасугай. | улсын дугаарын тэмдэг. 1-р хэсэг. Ерөнхий шаардлага” MNS 4410-1:20021 стандартад нэмэлт, өөрчлөлт орсон. Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулсан стандартыг улсын мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн тул https://estandard.gov.mn/ вэб сайт байршуулсан. Стандартад орсон нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэгч нарт хүргэж үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллах чиглэлийг холбогдох холбоонд хүргүүлээд байна. | | |
| 91 | **2022_466. Журам батлах тухай / 2022-12-14 /** | 4. Цахим арилжаагаар экспортод гаргах нүүрсний ачаа тээвэрлэлтийг Гашуунсухайт боомт дахь чингэлэгт тээврийн терминалаар тусгай горимоор зохион байгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Монгол Улсын сайд, Боомт сэргэлтийн Үндэсний хорооны даргын үүрэг хариуцагч Х.Нямбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн) нарт тус тус даалгасугай. | Нүүрсний экспортын цахим арилжаа зохион байгуулах болсонтой холбогдуулан 2023 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн Гашуунсухайт – Ганц мод боомтоор нэвтрэх ачаа тээврийн хөдөлгөөнийг хэвийн горимд шилжүүлж, жолооч нар хятадын талд хонож нүүрс буулгах нөхцөлийг бүрдүүлсэн. Ингэснээр өдөрт хилээр ачаатай гарах автомашины тоо 600-650-аас 850-930 болж нэмэгдсэн. Тухайлбал, 2023.01.19-ний өдөр хилээр нүүрс ачсан 937 автомашинаар 120.05 мянган тонн нүүрс гарч дээд амжилт тогтоосон. | 100% | |
| **4Д.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 92 | **2021_27. 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр 27 дугаар тэмдэглэл / 2021-04-28 /** | XI.5. . Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний хэт ачааллыг бууруулах цогц арга хэмжээний талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Нийтийн тээврийн шинэ төрлийг | 1.1. Засгийн газрын 2022.03.16-ны өдрийн 16 дугаар тэмдэглэлээр тус төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2022 онд багтаан эхлүүлэх, санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх тухай санал танилцуулахыг Сангийн сайд, УБ хотын захирагч нарт даалгасан.<br>1.2. Стандартын шаардлага хангасан, 24 болон түүнээс дээш хүний суудалтай, 45 болон түүнээс | 100% | Хэрэгжүүлэх чиг үүрэг нь УБ хотын захирагчийн ажлын албаны харьяа УБ түгжрэлийг бууруулах нэгж хариуцан ажиллаж байна. УБ хотын эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Нийслэл хот чиг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нэвтрүүлэх, автобусны үйлчилгээг шинэчлэн сайжруулах, автомашины хэрэглээг хязгаарлах чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт даалгав: 1.1. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд тээврийн шинэ төрөл нэвтрүүлэх ажлын техник, эдийн засгийн үндэслэлийг 2021 онд багтаан боловсруулах, ажлын зураг төслийг 2022 онд дуусгах, 2023 оноос бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх; 1.2. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд эхний ээлжид шаардлагатай байгалийн шатдаг хий, байгаль орчинд ээлтэй бусад эх үүсвэрээр ажилладаг автобус худалдан авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж, танилцуулах, 2022 оны төсөвт тусгуулах талаар холбогдох арга хэмжээ авах; 1.3. Нийтийн тээврийн үйлчилгээний парк шинэчлэлтийн хүрээнд импортоор оруулж ирэх автобус, такси үйлчилгээний автомашиныг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг холбогдох хуулийн дагуу судлан шийдвэрлүүлэх; 1.4. Нийтийн тээврийн үйлчилгээний | дээш зорчигчийн багтаамжтай, үйлдвэрлэснээс хойш зургаа хүртэл жил ашиглагдсан нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний зориулалт бүхий автобусыг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх тухай асуудлыг 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. 1.3 2022 онд төсөвлөгдсөн төсвийн дагуу 145 автобусаар парк шинэчлэлт хийсэн. 1.6. Зогсоол шинээр барих, менежментийг сайжруулах төсөлд 5 133.0 сая төгрөг төсөвлөж, 2022 онд Баянзүрх дүүргийн Их хүрээ гудамжны урд, хойд байршилд “Мандала хотхон” нэртэй 2 зогсоол, Сүхбаатар дүүргийн Бэлхийн эцэс, Тоосгоны эцсийн 2 зогсоол, Чингэлтэй дүүргийн Хайлааст, Дэнжийн мянгын авто замд 6 зогсоол тус тус ашиглалтад орсон. 1.5. Улаанбаатар хот дахь явган хүний болон дугуйн замуудыг шинэчлэн засч, шинээр барих ажлын хүрээнд. нийслэлийн 16 байршилд буюу хотын төвд 162.79 км замын ажил хийгдэх бол Сэлбэ, Туул, Тэрэлж, Хөлийн гол дагуу 177.9 км дугуйн зам шинээр барихаар зураг төслийг батлан хэрэгжүүлж эхэлсэн. 1.7. Улаанбаатар хотын авто замыг бөсчлэлд хуваан зорчих асуудлаар Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны ажлын албанаас "Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл"-ийг боловсруулж, санал авахаар тус яамд ирүүлсэн ба саналыг судлан 2023.02.02-ны өдрийн 02/541 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн. 1.9. Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем, удирдлагын төвийн | | үүргийн дагуу хариуцах тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нэгдсэн терминал, автобусны зогсоолыг шинэчлэх, шаардлагатай газруудад шинээр байгуулах, 1.5. Такси үйлчилгээнд хэрэглэгчийн аппликейшнд суурилсан дуудлагын үйлчилгээ, төлбөр тооцоо, хяналт, зохицуулалтын нэгдсэн системийг бүрдүүлэх, такси үйлчилгээний автомашины парк шинэчлэлт хийх; 1.6. Хотын төвлөрөл ихтэй бүсэд автомашины ил, далд болон давхар зогсоол шинээр барих, авто зогсоолыг мэдээллийн болон төлбөрийн нэгдсэн системд холбох ажлыг 2022 онд багтаан хэрэгжүүлж дуусгах; 1.7. Улаанбаатар хотын авто замыг ашиглалтын бүсчлэлд хуваах замаар авто зам ашигласны төлбөрийг ялгавартай тогтоох эрх зүйн зохицуулалтыг хийх; 1.8. Явган болон унадаг дугуйгаар зорчих хөдөлгөөнийг дэмжих цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 1.9. Замын хөдөлгөөний хяналт, удирдлагын болон гэрлэн дохионы нэгдсэн систем, програм хангамжийн иж бүрэн шинэчлэл хийх. | байрны асуудалд 23 500.0 сая төгрөг төсөвлөж, RFID унших 161 төхөөрөмж суурилуулсан байна. | | |
| 93 | **2021_60. 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 60 дугаар** | XIII.7.2. Төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, төслийн | Засгийн газрын 2022.03.16-ны 16 дугаар тэмдэглэл болон 2022.05.31 ний 31 дүгээр тэмдэглэлээр тус төслийн/Дүүжин тээвэр/ бүтээн байгуулалтын ажлыг 2022 онд багтаан эхлүүлэх, санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх тухай санал танилцуулахыг Сангийн сайд, УБ хотын захирагч | 100% | хэрэгжсэн тул хяналтаас хасуулах. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **тэмдэглэл / 2021-11-17 /** | хэрэгжилтийг эрчимжүүлэн, ажлыг шуурхай зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт тус тус даалгав. | нарт даалгасан. Шинэ төрлийн нийтийн тээврийн төрөл болох дүүжин тээврийн төслийн нарийвчилсан ТЭЗҮ-г боловсруулах НХААГ/20211616 тендерийг 2021 онд 300 сая төгрөгийн санхүүжилтээр зарлаж ТЭЗҮ-г 2022 оны 09 сард хүлээн авсан. Дүүжин тээврийн төсөл нь Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөлд багтсан. ТЭЗҮ боловсруулахад төмөр замын зөвлөх инженер С.Майдар мэргэжлийн зөвлөгөө өгч, дэмжин ажилласнаар ТЭЗҮ-г 9 сард хүлээн авсан | | |
| 94 | **2021_63. 2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 63 дугаар тэмдэглэл / 2021-12-08 /** | ХҮ.5. . Агаарын бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Агаар бохирдуулах эх үүсвэр тус бүрээс агаарт ялгарах бохирдуулагч бодисын хаягдлын талаар судалж, агаарын бохирдолд эзлэх хувийг тодорхойлсон дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Агаар бохирдуулах эх үүсвэр тус бүрээс агаарт ялгарах бохирдуулагч бодисын хаягдлын талаар судалж, агаарын бохирдолд эзлэх хувийг тодорхойлж, Засгийн газарт танилцуулах ажлын хүрээнд Нийслэлийн Агаарын чанарыг сайжруулах бүсэд агаар бохирдуулагч зонхилох эх үүсвэрүүд, түлшний чанарт хяналт, шалгалт хийж холбогдох арга хэмжээг авах, агаар бохирдуулагч түгээмэл бодисуудын эх үүсвэр тус бүрд дүн шинжилгээ хийх, зуух, түлш, тээврийн хэрэгслийн ашиглалтын үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартуудыг дахин үнэлж, дүгнэлт гаргаж, санал, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 142 дугаар тушаалаар байгуулагдсан. Ажлын хэсэгт 2022.01.08-ны өдрөөс 2022.02.15-ны өдрийн хооронд ажилласан ба 15 төрлийн арга хэмжээний хэрэгжилтийн байдалд шалгалт хийж, дүнг Шадар сайдад танилцуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны/Байгаль орчин, аялал жуулчлалын яам/ дарга Б.Алтанзул болон мэргэжилтэн Д.Одонтунгалаг нар ажилласан. Нэгдсэн дүнгийн талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам Засгийн газарт танилцуулна. | 70% | Ажлын хэсэг ажиллаж, шалгалтын үр дүн гарсан ба нэгдсэн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын яам/Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо/ чиг үүргийн дагуу танилцуулах тул хяналтаас хасуулах. Тус яам хариуцсан чиглэлийн хүрээнд ажиллаж, тайлан гарсан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Хавсралтад ажлын хэсгийн дэлгэрэнгүй болон хураангүй тайлан хавсаргав. | | |
| 95 | **2022_11. 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл / 2022-02-16 /** | 2. Баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн импортыг үе шаттай хязгаарлах болон үүнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний хувилбарын талаарх саналаа 14 хоногт багтаан боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар нарт даалгав. | Засгийн газрын 2022 оны 09 сарын 28-ны өдрийн хуралдаанаар танилцуулж, 47 тэмдэглэлээр насжилт өндөртэй тээврийн хэрэгслийн татварыг нэмэгдүүлэх талаар холбогдох хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж танилцуулахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатарт даалгасан. | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| 96 | **2022_36. 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 36 дугаар тэмдэглэл / 2022-07-05 /** | XX.3. . “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар олгох арга хэмжээний талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан, Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэрийн өнгийг сонгох асуудлыг ажлын журмаар Ерөнхий сайдад танилцуулан чиглэл авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт даалгав. | Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар ажлын шугамаар холбогдох стандартад нэмэлт өөрчлөлт оруулсан саналаа 2022 оны 08 дугаар сард Ерөнхий сайдад танилцуулж, чиглэл аван улсын дугаарын дэвсгэр өнгийг зөвшилцсөнөөр “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг 1-р хэсэг Ерөнхий шаардлага” MNS4410-1:20021 стандартад “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд хар хөх өнгийн дэвсгэртэй дугаар олгох” нэмэлт өөрчлөлтийг Автотээврийн стандартын техникийн хорооны 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хэлэлцэн батлуулсан. | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулав. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 97 | **2022_47. 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл / 2022-09-28 /** | IX.1.7. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалаар баталсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 7.2.3-т “сүүлийн 5 жил техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй автотээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах”-аар заасныг 1 жил болгох өөрчлөлтийг 2022 оны 11 дүгээр сард багтаан хийж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт; | “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 7.2.3-т “сүүлийн 5 жил техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй автотээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах”-аар заасныг 1 жил болгох өөрчлөлтийн төслийг Гаалийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, Татварын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-уудад санал авахаар 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 07/268 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатарт санал авахаар 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 02/506 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 30% | |
| 139 | | 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Зам, тээврийн хөгжлийн яам Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2022 оны 05 сард батлагдсантай холбогдуулан яамны цахим хуудсанд өөрчлөлт оруулж, уг хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Төрийн үйлчилгээ гэсэн хэсэгт Нээлттэй мэдээлэл гэсэн шинэ ангилалийг бий болгосон. Үүний 2 дугаар үндсэн бүлэгт Хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал хэсгийн 5 дугаарт Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний мэдээлэл байна. | 100% | |
| 140 | | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн яамны www.mrtd.gov.mn цахим хуудсанд өөрчлөлт оруулж, Нээлттэй мэдээлэл хэсэг шинээр үүсгэсэн. Уг хэсгийн Хүний нөөцийн ил тод хэсэгт "Төрийн жинхэнэ албан хаагчийн | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ыг байршуулсан. | | |
| 141 | | 8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | Шилэн данс www.shilendans.gov.mn цахим хуудасны Төсөв гүйцэтгэл гэсэн хэсгийн 8т Байгууллагын батлагдсан төсөв, 9т Дараа жилийн төсвийн төсөл хэсгүүдэд мэдээллийг байршуулсан байна. https://old.shilendans.gov.mn/org/418?group=0&year=2022 | 100% | |
| 142 | | 8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.4т заасан Санхүү, төсөвтэй холбоотой мэдээллүүд Шилэн данс www.shilendans.gov.mn хуудсанд тухай бүр байршуулж байна. Уг цэсний Төсөв, гүйцэтгэл хэсэгт дараах дараалллын дагуу санхүүгийн мэдээллүүд байршсан байна. Үүнд:<br>1т. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал;<br>2т.Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт<br>3т. Санхүүгийн тайлан/гүйцэтгэл/<br>4т.Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшууралд зарцуулсан тайлан<br>5т. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт<br>6т.Санхүүгийн тайлан/жил бүр/<br>7т. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшууралд зарцуулсан тайлан<br>8т. Байгууллагын батлагдсан төсөв<br>9т.Дараа жилийн төсвийн төсөл<br>10т. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ<br>11т. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн | 100% | |
| 143 | | 8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | гүйлгээ. https://old.shilendans.gov.mn/org/418?group=0&year=2022 | | |
| 144 | | 8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | Тус яам автотээвэр, авто зам, төмөр замын холбогдох зөвшөөрлийг олгох үйл ажиллагаанд үйлчилгээний хөлс авдаггүй болно. | Хугацаа болоогүй | Хамаарахгүй тул хяналтаас хасуулах |
| 145 | | 8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.4т заасан Санхүү, төсөвтэй холбоотой мэдээллүүд Шилэн данс www.shilendans.gov.mn хуудсанд тухай бүр байршуулж байна. Уг цэсний Төсөв, гүйцэтгэл хэсэгт дараах дараалын дагуу санхүүгийн мэдээллүүд байршсан байна. Үүнд: 1т. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал; 2т.Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 3т. Санхүүгийн тайлан/гүйцэтгэл/ 4т.Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан 5т. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт 6т.Санхүүгийн тайлан/жил бүр/ 7т. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан 8т. Байгууллагын батлагдсан төсөв 9т.Дараа жилийн төсвийн төсөл 10т. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 11т. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ. | 100% | |
| 146 | | 8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | | 100% | |
| 147 | | 8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт | | 100% | |
| 148 | | 8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр | | 100% | |
| 149 | | 8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч | | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл | https://old.shilendans.gov.mn/org/418?group=0&year=2022 | | |
| 150 | | 8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, нэгдсэн систем www.tender.gov.mn цахим хуудсаар мэдээлж байна. Уг цахим хуудасны Тендер шалгаруулалт болон Тендерт шалгаруулалтын үр дүн хэсэгт тухай бүр 2022 онд зарлагдсан тендерийн сонгон шалгаруулалтын мэдээлэл байршсан байна. https://www.tender.gov.mn/mn/result/ | 100% | |
| 151 | | 8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт; | УАГ-аас жил бүр санхүүгийн тайланд хяналт шалгалт хийдэг ба худалдан авах ажиллагаг бас шалгадаг. Уг тайлан Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудасны "Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт" хэсгийн дараах бүлэгт байршсан байна. 3т. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 4т Худалдан авах ажиллагааны тайлан Шилэн дансны Төсөв, гүйцэтгэл хэсгийн 4т Санхүүгийн тайлан, 5т Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг тус тус байршуулсан. байна. https://old.shilendans.gov.mn/org/418?group=2&year=2022 | 100% | |
| 152 | | 8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, | Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем/ www.tender.gov.mn/-ийн Нийтлэг асуулт, хариулт хэсэгт худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаа байршуулсан ба тендерийн урилгын Холбоо барих мэдээлэлд нийтлэгдсэн утсаар тухай бүр | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | шаардлагатай мэдээллийг олон нийтэд түгээж ажилласан. | | |
| 153 | | 8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | Яамны цахим хуудасны Нээлттэй мэдээллийн Төсөл, хөтөлбөрүүд хэсэгт Гадаадын зээлийн төслүүд, Гадаадын тусламжийн төслүүд гэж ангилагдан төслийн мэдээллүүд байршиж байна. | 70% | |
| 154 | | 8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | Яамны цахим хуудасны Нээлттэй мэдээлэл хэсгийн 3.15т Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан хэсэгт дарахад Шинжлэх Ухаан Технологийн сангийн ДАТА руу шууд холбогдох боломжтой болсон. Зам, тээврийн салбарт 2012 онд хийгдсэн "Геотор ашиглан асфальт-бетон хучилттай замын хагарлыг бууруулах арга зам, технологи" судалгааны ажлын тайлан зэрэг судалгааны ажлын мэдээлэл байршсан. | 100% | |
| 155 | | 8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | Яамны цахим хуудасны Төсөл хөтөлбөрүүд хэсэгт Зам, тээврийн хөгжлийн сайдын багцын улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ сар бүр нийтлэгдэж байна. https://mrtd.gov.mn/t/192 | 100% | |
| 156 | | 8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамжийн мэдээллийг яамны цахим хуудсанд мэдээлсэн. https://mrtd.gov.mn/t/211 | 100% | |
| 157 | | 8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, | Яамны цахим хуудасны Төрийн үйлчилгээ буланд Тусгай зөвшөөрөл гэсэн хэсэгт Авто зам, төмөр зам, Автотээврийн салбарын тусгай зөвшөөрлийн талаарх Зөвшөөрөл хүсэх иргэн, аж ахуйн нэгжийн | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа. | бүрдүүлэх баримт бичгүүд, зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийг байршуулсан байна. https://mrtd.gov.mn/t/211 | | |
| 158 | | 8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | Яамны цахим хуудасны Нээлттэй мэдээлэл хэсгийн 5.1т Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн саналд дараах төслүүд байршуулсан байна. Үүнд:<br>1. 2023.01.24-ний өдөр Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл<br>2. 2023.01.06-ны өдөр Төмөр замын мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, сургалт зохион байгуулах, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг олгох, шалгалт авах журам-д санал;<br>3. 2022.12.09-ний өдөр Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авахаар тус тус байршуулсан байна. https://mrtd.gov.mn/t/104 | 100% | |
| 159 | | 8.6.2. эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт; | Зам, тээврийн хөгжлийн яам оюуны өмчийн эрхийн гэрчилгээ байхгүй тул мэдээлэл байршуулаагүй. | Хугацаа болоогүй | |
| 160 | | 8.6.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл; | Газрын тухай хуулийн 19.1.3-д "газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн байгууллагын эрх олгох, цуцлах, тэдгээрийн ажиллах журам, зааврыг батлан мөрдүүлэх" гэж заасан нь Газрын асуудал эрхэлсэн төрийн | Хугацаа болоогүй | Газрын тухай хуулийн 19.1.3 дэх заалтын дагуу Барилга, хот байгуулалтын яамны эрхлэх асуудал тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | захиргааны төв байгууллага бүрэн эрх тул тус яамд хамаарахгүй. | | |
| 161 | | 8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | Тус яамны цахим хуудасны Нээлттэй мэдээллийн 5д Бусад мэдээллийн ил тод байдал хэсэгт Газрын мэдээлэл оруулсан байна. https://mrtd.gov.mn/i/3351 | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| 162 | | 8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг; | төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдэд оруулсан хөрөнгө байхгүй. | Хугацаа болоогүй | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хамаарах тул хяналтаас хасуулах |
| 163 | | 8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл; | Зам, тээврийн салбарын төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болох МИАТ ТӨХК, МТЗ ТӨХК нар Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн болон холбогдох мэдээллийг тус тусын цахим хуудсанд байршуулсан байна. https://www.miat.com/pagecontent.php?pageId=209&lang=mn https://www.mtz.mn/content/64 | 100% | Төрийн өмчийн үйлдвэрийн газруудад хамаарах тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 164 | | 8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; | Өмч хувьчлал, ямар нэг хөрөнгө шилжүүлснээс олсон орлого байхгүй. | Хугацаа болоогүй | ТӨрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хамаарах тул хяналтаас хасуулах |
| 165 | | 8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл; | Зам, төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхдээ амьтны эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар тусгай нүхэн гарц зэрэг байгуулдаг тул амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл байхгүй. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн байгаль орчны нөлөөллийн байдлын үнэлгээний тайланг Хүрээлэн буй орчны зөвлөх “Өндөрхаан трейд” ХХК хийж гүйцэтгэн БОАЖЯамаар баталгаажуулсан тухай мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулсан. https://mrtd.gov.mn/i/3221 | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| 166 | | 8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт; | Яамны цахим хуудасны Нээлттэй мэдээлэл хэсгийн 5.7т Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт буюу 2022 онд улсын ашиглалтад хүлээлгэн өгсөн төсөл, арга хэмжээний жагсаалтыг байршуулсан байна. https://mrtd.gov.mn/t/289 | 100% | |
| 167 | | 8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл; | Төрийн бүтээмжийг ил тод нээлттэй байх зорилгоор салбарын мэдээллийн сан дах нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдлийг Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 232 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"-д зам, тээврийн салбарын 29 өгөгдөлийг баталсан. Энэ тогтоолын дагуу Нээлттэй өгөгдлийн сан болох | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | www.opendata.gov.mn цахим хуудсанд зам, тээврийн салбарын авто замын-8, авто тээвэр -15, төмөр замын-7, иргэний нисэхийн 4 нийт 34 өгөгдөл тухай бүр шинэчлэгдэн байршиж байна. Мөн яамны цахим хуудасны Нээлттэй мэдээдэл хэсэгт "Нээлттэй өгөгдлийн жагсаалт" нэрээр байршуулсан. https://mrtd.gov.mn/i/3331 | | |
| 168 | | 8.6.21. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт; | Төсвийн зардлаар гадаад улсад суралцаж байгаа төрийн албан хаагч тус яамд байхгүй. | Хугацаа болоогүй | Төрийн жинхэнэ албан хаагчид өөрсдөө Тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хүсэлтээ өгч, сургалтад явдаг ба тус яам 2012 оноос хойш нэг ч албан хаагчийг Төсвийн зардлаар гадаад улсад сургалтад хамруулж байгаагүй тул хяналтаас хасуулах |
| 169 | | 8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д заасанаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | Яамны цахим хуудсанд дараах мэдээллийг нээлттэй, ил тод байршуулж байна. Үүнд: 1. Автотээврийн харилцааны тухай олон улсын гэрээ, конвенциудыг байршуулсан. https://mrtd.gov.mn/upload/files/heleltseer.pdf 2. Ажлын хэсэг, хороодын үйл ажиллагааны талаарх мэдээллийг Мэдээ хэсэгт байршуулсан. https://mrtd.gov.mn/t/201 | 100% | хэрэгжилт тогтмолжсон тул хяналтаас хасуулах |
| 170 | **2021-12-24. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль** | 11.3. Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод | Улсын их хурлын 2021 оны 10 дугаар "Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай" тогтоолоор үүрэг болгосон 4 ажлыг Засгийн газар хэрэгжүүлсэн ба Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 2т "Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана" заасны дагуу Засгийн газрын чиг үүрэг байна. | Хугацаа болоогүй | Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 2т "Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана" заасны дагуу Засгийн газрын чиг үүрэг тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хүргүүлнэ. (11.2.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана.) | | | |
| 171 | | 15.3. Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсан бол Засгийн газар уг тогтоолын хэрэгжилтийг тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй. | Улсын их хурлын 2021 оны 10 дугаар тогтоолоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай баталсан. Уг тогтоолоор үүрэг болгосон дараах 4 ажлыг Засгийн газар хэрэгжүүлсэн. Үүнд: 1. 2020 онд батлагдсан Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг УИХ-аар 2021 оны 12 сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлуулсан. 2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасан журмуудыг баталсан. 2.1. Хуулийн 9.3.7.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам-Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоол; 2.2 Хуулийн 9.3.8.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлийг дүгнэх журам болон тайлангийн үлгэрчилсэн загвар-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ыг тус тус батласан. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар "Байгууллагын гүйцэтгэлийн тайлангийн загвар"-ыг баталсан. Зам, тээврийн хөгжлийн сайд, Засгийн газрын гишүүн:<br>3. 2022 оны 06 сард Далай ашиглах тухай хуулийг УИХ-аар батлуулсан.<br>4. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дэд бүтэц хоорондын хамаарал, төр-хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг тодорхойлон, төрийн захиргааны төв байгууллага байгуулах талаарх зураглал гарган, нэн шаардлагатай хууль тогтоомжийн төсөл болох Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д 2023 оны 01 сарын 10-ны өдөр өргөн барьсан. | | |
| **6б.УИХ-ын тогтоол** | | | | | |
| 172 | **2022 №08. Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай** | 1.36. Тээврийн нэгдсэн хуулийн анхдагч хуулийн төсөл; | Тээврийн ерөнхий хуулийн төслийг Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Сангийн яам, Хууль зүй дотоод хэргийн яамнаас Тээврийн ерөнхий хуулийг УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрлийг ЗГХЭГ-т газарт хүргүүлсэн. | 70% | |
| 173 | **2021 №12. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл** | 4. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг | “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтад Зам, тээврийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр 1 | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай** | жил бүрийн намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд хүргүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай. | хуулийн төсөл, 2 конвенц, 1 Улсын Их Хурлын тогтоолын төсөл тусгагдсан бөгөөд Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2022 оны 11 дүгээр сард, 2023 оны 02 сард хүргүүлэн, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан (www.unelgee.gov.mn)-д байршуулан ажиллаа. | | |
| 174 | **2022 №36. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай** | 5/д. хүнсний зориулалтын тусгай тээврийн хэрэгслээр /автомашин, вагон, онгоц/ тоноглогдсон тээврийн паркийг шинээр бий болгох, дотоодын болон экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тогтолцоог бүрдүүлэх; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:) | Дотоодын болон экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тогтолцоог бүрдүүлж ажиллаж байна. 2022 онд төмөр замаар хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 176.8 мян.тн, түргэн муудах бүтээгдэхүүн 4 мян.тн, хүнс хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 160 мян.тн ачааг тус тус тээвэрлэсэн байна. 2022 онд БНХАУ хилээ нээснээр 2022.11.15-наас ГХЯ болон Монголын махны холбоо нартай хамтран мах автотээврээр экспортолж эхэлсэн ба 322 тээврийн хэрэгслээр 7596.7тн мах экспортолсон. Хүнсний бүтээгдэхүүнийг холбогдох стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр горимын дагуу тээвэрлэдэг болно. Тухайлбал: 2022 онд агаарын ачаа тээврийн 2 онгоцтой болсон ба хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын сав баглаа, боодолд савласан байхыг ИКАО баталсан дүрмийн дагуу тээвэрлэдэг. Автотээвэр болон төмөр замын хувьд ачааны бүхээгт хөргөлтийн систем суурилуулсан байдаг. Тус салбар төмөр замаар тээвэрлэх махны экспортыг нэмэгдүүлэх зорилгоор УБТЗ ХНН-т 2023.01.04-ний өдрийн 08/49 тоот албан бичгээр "БНХАУ руу жил бүр 50000 тн махыг стандартын дагуу экспортлох боломжийг бүрдүүлж, БНХАУ-ын гүн рүү тээвэрлэлт хийн тээврийн зардал буурах нөхцөлийг судлан, Хятадын төмөр замтай дээрх ачааг шилжүүлэн ачих, хүлээлцэх хүйтний хэлхээ | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | бүхий байгууламжийн нөөц боломж"-ийн талаар судалж, танилцуулах чиглэлийг өгсөн. | | |
| **6в.Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | |
| 175 | **2018_46. Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай / 2018-05-23** | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр яамны Монгол Хэлний бодлогын салбар зөвлөл 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:<br>1.Нийт албан хаагчдын дунд Монгол бичгээр унших, бичиг мэдлэгийн түвшинг тогтоох сорилын арга хэмжээг зохион байгуулсны үндсэн дээр монгол бичгийн 27 удаагийн сургалтаар суурьгүй анхан шатны сургалтад 58, суурьтай анхан шатны сургалтад 93 албан хаагчийг хамруулсан.<br>- “Кирилл бичгийн зөв бичих, найруулга зүйн” 3 удаагийн сургалтаар 74, Баримт бичиг боловсруулахад анхаарах асуудал” сэдэвт 6 удаагийн сургалтаар 120 албан хаагчийг хамруулсан.<br>- Байгууллагын өрөө, тасалгаа, хурлын өрөөний нийт 64 хаягийг кирилл болон монгол бичгээр бичиж байршуулсан.<br>- Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу салбарын ажилтан, албан хаагчдад олгож байгаа яамны “Жуух бичиг”-ийг кирилл болон монгол бичгээр загварыг батлуулан хэрэглэж байна.<br>- Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын нэрийн хуудсыг монгол бичгээр хэвлүүлсэн.<br>2.Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлж сурталчлан таниулах, өвлүүлэх зорилгоор дараах ажлыг зохион байгуулсан. Үүнд:<br>- Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх “Шагайн харваа”-ны багийг 8 гишүүнтэй байгуулж Төмөр замын салбарын аварга шалгаруулах тэмцээн болон Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Үндэсний их баяр наадмын шагайн харвааны | 100% | Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-ын зорилт 1.1 Төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгал, утга зохиол, урлагын бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна, зорилт 1.3 Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ гэсэн зорилтуудын хүрээнд Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, идэвхитэй ажиллаж байгаа тул дотоод хяналтад авч, ЗГХШМС-ийн хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тэмцээнд оролцсон. - Монгол Улсын түүх, соёлын ховор нандин үнэт зүйлийн цуглуулга болох “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үзмэр”-ийг газар, хэлтэс тус бүрээс төлөөлөл оролцуулан 27 албан хаагчид үзүүлсэн. - Хар хорин хотыг судлах аяллыг зохион байгуулж Эрдэнэзуу хийд, Хөшөө цайдмын музей, Хар хорум музей, Хар хорум хотын туурь, Их гүрнүүдийн цогцолбор, Эрхтэн чулуу хөшөө, мэлхий толгойг үзэж түүх соёлыг судалсан. 3. Салбарын харьяа 9 байгууллагын монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр 2022 онд хийж гүйцэтгэсэн ажлын хэрэгжилтийг хавсралт файл хэлбэрээр оруулав. | | |
| 176 | **2020_10. Засгийн газарт чиглэл өгөх тухай /Шинэ коронавируси йн халдвараас урьдчилан сэргийлэх тухай/ / 2020-02-12** | 1. Дэлхийн олон улс болон манай хөрш БНХАУ-д шинэ коронавирусийн тархалт эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана жилийн Цагаан сарын баярыг тэмдэглэхгүй байж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээ авахыг Засгийн газарт чиглэл болгосугай: 1.1. Шинэ коронавирусийн тархалтын нөхцөл байдалтай уялдуулан хүн амыг урьдчилан сэргийлэх зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэглэлийг үе шаттайгаар сонгон хэрэгжүүлэх шийдвэр гаргах; 1.2. Олон улсын хөл | 1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020.02.14 №А/44 дүгээр Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай, 2020.03.02 №А/57 дугаар Бэлэн байдлын зэргийн үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тус тус тушаалын дагуу Ковидын үед тээвэрлэлтийг тасралтгүй зохион байгуулж, ажилласан. 1.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020.02.12-ны өдрийн зарлигаар Дэлхийн олон улс болон манай хөрш БНХАУ-д шинэ коронавирусийн тархалт эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана цагаан сарын баярыг тэмдэглэхгүй байх шийдвэр гарсан. Уг шийдвэрийн дагуу яамны цахим хуудас, Монголын үндэсний олон нийтийн радио телевизээр мэдээллийг ард олонд түгээсэн. 2. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх үүргээ зам, тээврийн салбарын албан хаагч, иргэд, ард олноороо үр дагаврыг ойлгож, хувийн хамгаалах хэрэгсэл амны хаалт, гар ариутгагчыг тогтмол зүүж хэвшсэн. онцгой нөхцөл байдлын үед байгууллагаас албан хаагчдыг хамгаалах хэрэгслээр ханган ажилласан. 3. | 100% | КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ хуулийн 18.1-д заасны дагуу үйлчлэх хугацаа 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дууссан тул хяналтаас хасуулах. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хориот болон халдварт бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчин гарсан үед тархаахгүй байх, таслан зогсоох зорилгоор хорио цээрийн дэглэм тогтоох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар яаралтай хэлэлцэн журамлаж, мөрдүүлэх; 1.3. Цагаан сарын баярт зориулсан олон нийтийг хамруулсан үзэсгэлэн худалдаа, мэдээллийн хэрэгслээр явуулах реклам, сурталчилгааг даруй зогсоох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх иргэдийн үүрэг, хариуцлага, уг халдварын хор хөнөөлийг ухуулан ойлгуулах ажлыг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах; 1.4. Дэлхий дахинд хүнээс хүнд, мал, амьтнаас хүнд халдварлах халдварт өвчин ихээр тархах болсонтой холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай болон бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын хаврын чуулган, шаардлагатай бол ээлжит бус чуулганаар яаралтай горимоор хэлэлцүүлэх. 2. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үүргээ ухамсарлан, өөрийн болон | 2021.06.21-ний өдрөөс 2021.10.05-ны өдөр хүртэл албан хаагчдаас яамны эмч Түргэвчилсэн тестээр/шүлс/ Ковидын эсрэг биет илрүүлэх шинжилгээг 7 хоногын Даваа болон Пүрэв гарагт тогтмол авч байсан. Монгол Улс 2022 оны 02 дугаар сард хорио цээрийн дэглэмээ сулруулж, олон улсад хилээ нээсэн. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нийтийн эрх ашгийг эрхэмлэхийг нийт ард иргэдэд уриалсугай. | | | |
| 177 | **2021_58. Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ / 2021-10-04** | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Зам, тээврийн салбарын байгууллагууд 2022 онд дараах ажил зохион байгуулсан байна. Үүнд:<br>1. Зам, тээврийн хөгжлийн яам 2021.10.04-ны өдөр "Зам, тээврийн салбарын 2021-2030 оны хооронд мод тарих тоон жагсаалт"-ыг баталсан. Үүний дагуу тус яам салбарын 11 байгууллагуудыг уриалан 2021 оны 10 сараас эхлэн Хөшгийн хөндийн хурдны зам дагуу Улиас, нарс, Шар хуайс зэрэг төрлийн моднуудыг тариад байна.<br>2. 2021 оны 11 сард салбарын Монголын төмөр зам, Монголын авто замчдын холбоо, АТҮТ ТӨҮГ, Зүүнбаян төмөр зам ХХК, Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ болон яамны нийт албан хаагчид нийт 1614 мод тарьсан.<br>3. 2022 оны 05 сард 1504, 10 сарын 08-нд салбарын Монголын авто замчдын холбоо, Монгол автозамчин эмэгтэйчүүдийн холбоо ТББ болон яамны албан хаагчид тус тус тарьсан модоо эргэн услах, шинээр 700 шар хуйасыг тарьсан байна.<br>4. МИАТ ТӨХК-Нийслэлийн Сонгино хайрхан дүүргийн 24-р хорооны нутаг дэвсгэр болох Баруун салаа, Бумбатын булагт 300 гаруй хар мод, нарс, шинэс зэрэг шилмүүст мод тарьсан.<br>5. ГТХЗНТ нийт 701 мод, бутыг тарьж ургуулаад байна.<br>6. ХХНОБ 1200 ширхэг хайлаас (бут, сөөг) модыг тарьж суулгаад байна.<br>7. Далайн захиргаа 110 ширхэг Шинэс хар мод, 110 гүйлс мод нийт 220 мод тарьсан.<br>8 УБТЗ ХНН 2022 онд 36000 ширхэг нийт 51800 ширхэг мод тарьсан.<br>9. МТЗ ТӨХК Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдсэн цагаас нийт 6380 ш мод тарьж, нийгмийн | 100% | Хэрэгжилт тогтмолжсон учир хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хариуцлагат үүргээ гүйцэтгэн ажиллаж байна. 10. ИНЕГ 3 төрлийн /Нарс, Хайлаас, Улиас/ нийт 3000 мод тарьсан. 11. АТҮТ ТӨҮГ нийтдээ 3429 мод тарьсан байна. Тэрбум мод хөдөлгөөнд нэгдсэн цагаас хойш харьяа байгууллагуудын хийсэн ажлын товч тайланг хавсаргав. | | |
| 178 | **2022_43. Засгийн газарт чиглэл өгөх тухай / 2022-04-05** | 1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох; | Засгийн газрын 2018 оны 258 дугаар "Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" дугаар тогтоолоор баталсан журмын 1.7-д " төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис... ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох" гэж заасны дагуу салбарын 10 байгууллага тус бүр Хөдөлмөрийн дотоод журмандаа албан томилолт, ажлын бус цагаар архи, согтууруулах ундааг хэрэглэхийг хатуу хориглосон заалт тусгасан ба 2018 оны 9 сараас хойш харьяа байгууллагад хяналт шалгалтаар ажиллах бүрт Сахилга хариуцлага мөн шалгаж хэвшсэн. Төрийн нарийн бичгийн даргын 2022.07.04-ний өдрийн А/88 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 5.2 Албан хаагчдын үйл ажиллагаанд хориглох зүйлийн а хэсэгт "Ажлын байранд төрийн албан хаагч ажлын болон ажлын бус цагаар мөн албан томилолтын явцад согтууруулах ундаа хэрэглэх, ажлын байранд авч орохыг хориглоно" гэж тусган хатуу хориглосон. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу Засгийн газрын 2022.11.30-ны өдрийн хуралдаанаас гарсан 57 дугаар тэмдэглэлийн хүрээнд 2022 онд | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | яам болон салбарын 10 байгууллага албан ёсны баяр/шинэ жил/ зохион байгуулаагүй болно. | | |
| 179 | **2022_43. Засгийн газарт чиглэл өгөх тухай / 2022-04-05** | 2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай. | Засгийн газрын 2018 оны 258 дугаар "Төрийн албаны сахилга, хариуцлага дэг журмыг чангатгах тухай" тогтоолын дагуу Тус салбарын албан хаагчид албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад архи, согтууруулах ундаа хэрэглэхийг бүр мөсөн хориглосон. Засгийн газрын 2022.11.30-ны өдрийн хуралдаанаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, нийтэд уриалга түгээх зорилгоор Төрийн байгууллагууд төсвийн хөрөнгөөр шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулахгүй байх нь зүйтэй хэмээн шийдвэрлэсэн. Үүний дагуу зам, тээврийн салбар шинэ жилийн арга хэмжээг зохион байгуулаагүй. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2020.07.01-ний 99 дүгээр захирамжаар батлагдсан "Эрэгтэй, Эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хүрээнд 2022.10.02-ны өдөр салбарын харьяа байгууллагын удирдлагууд болон яамны албан хаагчид нийт 109 хүнд "Эрүүл мэнд-Стрессгүй орчин" сургалтад хамруулсан. | 100% | |
| 180 | **2022_159. Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай / 2022-07-11** | 2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай. | 2022 оны 07 дугаар сард Эзэн Богд Чингис хааны эш хөргийг Зам, тээврийн хөгжлийн сайдын өрөөнд хүндэтгэлтэйгээр залсан. Салбарын 10 байгууллагад Эзэн Богд Чингис хааны эш хөргийг залах тухай чиглэл өгч, 2022 онд бүгд Эш хөргийг залсан байна. | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| 181 | | 4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл | "Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын зорилт 1.1. "Төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв еэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна" гэж заасныг үндэслэн тус яамны Монгол хэлний бодлогын зөвлөл 2022 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:<br>1. Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлж сурталчлан таниулах, өвлүүлэх зорилгоор Чингис хаан музейг 33 албан хаагч үзсэн.<br>2. Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх “Шагайн харваа”-ны багийг 8 гишүүнтэй байгуулж Төмөр замын салбарын аварга шалгаруулах тэмцээн болон Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Үндэсний их баяр наадмын шагайн харвааны тэмцээнд оролцсон.<br>3. Монгол Улсын түүх, соёлын ховор нандин үнэт зүйлийн цуглуулга болох “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үзмэр”-ийг газар, хэлтэс тус бүрээс төлөөлөл оролцуулан 27 албан хаагчид үзүүлсэн.<br>4. Хар хорин хотыг судлах аяллыг зохион байгуулж Эрдэнэзуу хийд, Хөшөө цайдмын музей, Хар хорум музей, Хар хорум хотын туурь, Их гүрнүүдийн цогцолбор, Эрхтэн чулуу хөшөө, мэлхий толгойг үзэж түүх соёлыг судалсан.<br>5. Салбарын харьяа 5 байгууллагад Монгол хэлний бодлогын зөвлөл 2022 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар уулзалт зохион байгуулсан. | | |
| **6г.Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж** | | | | | |
| 182 | **2010_10/09. Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх** | 2. Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн эрсдэлийн бодит байдлыг нийтэд таниулах, нийслэлийн орчмын бүс нутагт өндөр хурдны зам, эрчим хүчний шугам тавих замаар үйдвэр, үйлчилгээ, хүн амын суурьшлын | Улаанбаатар хотын төвлөрлийг задлах арга хэмжээний хүрээнд зам, тээврийн салбарт дараах бүтээн байгуулалтын ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд:<br>1. Нийслэл орчмын бүс нутагт 2019 онд Улаанбаатар, Чингис хаан олон улсын нисэх буудлыг холбосон хурдны 32 км хатуу хучилттай | 100% | Зам, тээврийн салбарын хүрээнд боломж, нөөцөө ашиглан бүх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул хяналтаас хасуулах. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **тухай / 2010-03-18** | шинэ төвүүдийг бий болгох, их, дээд сургуулийн хотхон байгуулах зэргээр төвлөрлийг задлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, | авто замыг ашиглалтад оруулсан.<br>2. 2021 оны 07 дугаар сард Хөшигийн хөндийн шинэ нисэх буудал үйл ажиллагаа явуулж эхэлсэн.<br>3. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн чиглэлийн 416.1 км/дэлгэмэл 462.5 км/ хэвтээ тэнхлэгийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дуусган, 2022.03.10-ны өдөр зүгшрүүлэх тээвэр явж эхэлсэн.<br>4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 233.6 км/дэлгэмэл урт 312.8 км/ нэгдүгээр зэрэглэлийн хүнд даацын төмөр замыг 2022.09.09-ны өдөр ашиглалтад хүлээн авсан.<br>5. Тавантолгой-Зүүнбаян болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замуудыг холбох 21.1км/дэлгэмэл 26км/ төмөр замын дээд, доод бүтцийг 2022 оны 09 сард барьж дуусган, техникийн комисс ажилласан.<br>6. Зүүнбаян-Ханги чиглэлийн 233.6км/ дэлгэмэл 263км/ төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дуусган, 2022.11.25-ны өдөр ашиглалтад оруулсан. Дээрх төмөр замын бүтээн байгуулалтын үр дүнд Өмнөговь аймгийн Цогтцэций болон Ханбогд сумдад ажиллах хүн амын тоо 2019 онтой харьцуулахад 5 хувиар өсч, 12374 болсон байна.<br>7. “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр” Төсөл 2-ын хүрээнд Ховд, Баян-Өлгий аймгуудад ОХУ-ын хилийн боомтоос БНХАУ-ын хилийн боомттой холбогдох Азийн авто замын АН-4 буюу баруун босоо тэнхлэгийн 745 км авто замыг 2022.10.30-нд бүрэн ашиглалтад оруулсан.<br><br>Төмөр замын бүтээн байгуулалтын үр дүнд Өмнөговь болон Дорноговь аймгийн нутаг дамнан Тавантолгой-Зүүнбаян чиглэлд Цэций өртөө, 6 зөрлөг, Зүүнбаян-Ханги чиглэлд Номгон, Ханги | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | өртөө, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд Тавантолгой болон Гашуунсухайт өртөө, 5 зөрлөг байгуулагдсанаар хүн амын суурьшлын шинэ төвүүд бий болсон. | | |
| **6д. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 183 | **2010_10/03. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай / 2010-03-18** | 4. Газар хөдлөл судлал, барилга байгууламжийн хийц, бүтээцийн сорил шинжилгээний лаборатори, барилгын зураг төсөл, эрдэм шинжилгээ, судалгааны төв байгуулах арга хэмжээг авах, (Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, нийслэлийн Засаг дарга) | Засгийн газрын 2012 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор “Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” тогтоолоор Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яам нь Зам, тээврийн яам болон Барилга, хот байгуулалтын яам болж өөрчлөгдсөн. Засгийн газрын 2015 оны 55 дугаар тогтоолоор Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний "Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төв" улсын төсөвт үйлдвэрийн газрыг "Зам, тээврийн хөгжлийн төв" аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар, Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний "Зураг, төсөл, эрдэм шинжилгээний институт" улсын төсөвт үйлдвэрийн газрыг "Барилгын хөгжлийн төв" аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газарт нэгтгэн зохион байгуулах гэж тус тус өөрчлөн байгуулсан. Үүний дагуу 1. Зам, тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын бүтцэд Авто замын итгэмжлэгдсэн төв лаборатори болон Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн хэлтэс үйл ажиллагаа явуулж байна.<br>2. Барилгын хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын бүтцэд Хот байгуулалт, зураг төслийн институтийн эрхлэх асуудалд Барилгын материалын сорилт, шинжилгээний лаборатори болон Барилга байгууламжийн зураг төсөл магадлалын хэлтэс тус тус үйл ажиллагаа явуулж байна. | 100% | Дээрх тэмдэглэлийн заалтад дурдсан үүрэг даалгавар нь Зам, тээврийн хөгжлийн яамны чиг үүрэгт хамаарахгүй тул хяналтаас хасуулах. Мөн Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн гамшгийн эрсдэл судлал болох газар хөдлөлтийн судалгаа хийх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулж байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 184 | **2010_10/03. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай / 2010-03-18** | 7.. Гамшгийн үед онцгой горимоор ажиллах шаардлагатай дулааны цахилгаан станц, цахилгаан, дулааны эрчим хүч дамжуулах, түгээх байгууламж, тээвэр, ачаа, зорчигчийн терминал, харилцаа холбоо, телевиз, радио зэрэг дэд бүтцийн объектууд, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, химийн болон бусад хорт бодис, нян өсгөвөр бүхий газруудын аюулгүй ажиллагааны журам, зааврыг боловсруулж хэрэгжүүлэх, (Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг дарга) | Зам, тээврийн салбарт онцгой горимоор/гамшгийн үед/ ажиллах шаардлагатай тээвэрлэлт гүйцэтгэхэд дараах журмуудыг мөрдөн ажиллаж байна. ҮҮнд: 1. Зам, тээврийн сайдын 2015 оны 334 дүгээр тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”; 2.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 235 дугаар тушаалаар баталсан " Мэдээллийн схем баталж, мэдээлэл дамжуулах тухай" журам; 3. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/154 дүгээр тушаалаар баталсан "Төмөр замын тээвэр дэх осол, гологдлыг судлан бүртгэх журам"-ыг мөрдөн ажиллаж байна. Дээрх журмыг мөрдөн ажилласны үр дүнд гамшгийн зэрэглэл тогтоон, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хугацаанд зам, тээврийн салбарын гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээллийг хавсаргав. | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| 185 | **2010_10/03. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай / 2010-03-18** | 10. Гамшгийн үед шаардагдах нөөц байр сууц, хүнс, дулаан хувцас, хээрийн эмнэлэг, эмнэлгийн тусламж үйлчилгээ, хүн хүч, техник хэрэгсэл, машин механизмын дайчилгааны төлөвлөгөө-хангалтын тооцоог улирал бүр нягтлан тодотгох, хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах агуулах сав, нисэх онгоцны нөөц буудлуудыг магадлан итгэмжлүүлэх, (Онцгой байдлын | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсээр 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр хянуулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөнд гамшгийн үеийн нөөц, техник хэрэгсэл, машин механизмын дайчилгааны бэлэн байдлын судалгаануудыг тусгасан байна. ИНД-139 дүрмийн шаардлагын дагуу өнөөдөр МУ-д гэрчилгээжсэн 20 нисэх буудал байгаа ба тэдгээрийн бэлэн байдлын мэдээллийг тогтмол шинэчлэн Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (aip.mn)-д мэдээлж байна. Буянт Ухаа нисэх онгоцны буудлыг Засгийн газрын 2019 оны 455 дугаар тогтоолын 2 дахь заалтаар | 70% | Монгол Улсад Нисэх онгоцны нөөц буудал магадлан итгэмжлэх чиг үүрэг бүхий байгууллага байхгүй ба итгэмжлүүлэх асуудал хэрэгжих боломжгүй тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий газар) | "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг олон улс, орон нутгийн нислэгийн нөөц нисэх буудал"-ын зориулалтаар ашиглуулахаар Иргэний нисэхийн ерөнхий газарт шилжүүлсэн. | | |
| 186 | **2010_10/03. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай / 2010-03-18** | 12. Аймаг, нийслэлийн газар хөдлөлтийн үйлчлэлтэй нутаг дэвсгэрт барих барилгын давхрын тохиромжтой тоог тогтоосон "Өндөр барилга, байгууламжийг төлөвлөх норм" боловсруулан, мөрдүүлэх, (Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам) | Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2010.12.30-ны өдрийн 429 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар "Өндөр барилгын төлөвлөлт" /БНбД 31-17-10/-ийг баталсан байна. | 100% | Хэрэгжсэн, Барилгын тухай хуулиар Барилга хот, байгуулалтын эрхлэх асуудал тул хяналтаас хасуулах. Засгийн газрын 2012.08.29-ний 14 дүгээр тогтоолоор “Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” тогтоолоор Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яам нь Зам, тээврийн яам болон Барилга, хот байгуулалтын яам болж өөрчлөгдсөн. |
| **6Е. Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 187 | **2022_417. Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай / 2022-11-23 /** | 3. Мэргэжлийн хяналтын чиг үүрэг салбарын яамдад шилжиж байгаатай холбогдуулан холбогдох яамдын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт зохих өөрчлөлт оруулах шийдвэрийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд, энэ тогтоолын 2.3-т заасан улсын байцаагч нарыг яамны зохих | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдаж, чиг үүрэг нь салбарын яамдад шилжих болсонтой холбогдуулан Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 469 дугаар тогтоолоор яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт нэмэлт, өөрчлөлт оруулсан. Үүний дагуу тус яамд Салбарын хяналтын газартай болсон ба 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 улсын байцаагч шилжин ирж ажиллаж байна. | 100% | хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бүтцийн нэгжид шилжүүлэн ажиллуулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай. | | | |
| 188 | **2022_419. Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай / 2022-11-23** | 5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай. | Зам, тээврийн салбар нь үйл ажиллагааны онцлогтой бөгөөд харьяа төсөвт байгууллагууд орон нутаг дах салбараар дамжуулан хариуцсан чиг үүргийн дагуу холбогдох хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал: Агаар: Иргэний нисэхийн ерөнхий газар нь 2181 албан хаагчтай ба үүнээс орон нутгийн 17 нисэх буудалд 391 албан хаагч ажиллаж байна. Төмөр зам: УБТЗ ХНН нь 15819 албан хаагчтай, үүний орон нутаг дах 28 салбар нэгж байгууллагад 8076 албан хаагч ажиллаж байна. Автотээвэр: Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь 775 албан хаагчтай ба орон нутгийн 23 салбарт 320 албан хаагч тус ажиллаж байна. Усан зам: Далайн захиргаа УТҮГ нь 26 албан хаагчтай ба үүний 1 албан хаагч Хөвсгөл аймгийн Ханх суманд ажилладаг. Зам, тээврийн 4 салбарын төрийн өмчит байгууллагуудын албан хаагчдын статистик тооноос харахад 18801 албан хаагчдын 8788 буюу 46% нь орон нутагт байнга ажиллаж байна. | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| 189 | **2022_448. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний** | 2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн | Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах арга хэмжээг авч ажилласан. ҮҮнд: 2.1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад Эдийн засаг, хөгжлийн сайдын төсөвт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Улсын хэмжээнд/”-ын ажилд 40,0 тэрбум төгрөг батлагдсан ба энэ хүрээнд зам, тээврийн салбарт | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **тухай / 2022-12-07 /** | хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагаар Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах. | 2023 онд боловсруулах шаардлагатай байгаа ТЭЗҮ, зураг төслийн ажлын жагсаалтыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01/5827 тоот албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад хүргүүлсэн.<br>2.2.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3 дахь заалтын дагуу ХАА-ны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх чиглэл баримтлан ажиллаж байна.<br>2.3. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний багцад 230.79 тэрбум төгрөг батлагдсанаас 215.97 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон ба 93%-ийн биелэлттэй байна.<br>2.4.Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/178 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2 удаа хуралдаж, үнийн өсөлтийн зөрүү олгох төслүүдийн тооцоо судалгааг "ЗТХТ" ТӨҮГ-аас дахин албажуулж авч, нэмэлт гэрээний төслийг боловсруулж батлуулан ажилласан.<br>2.5. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагаар Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем PIMIS-ийг бүрэн ашиглаж, 176 санхүүжилтийн хүсэлтийг 2022 онд тухай бүр түргэн шуурхай шийдвэрлэж ил тод, нээлттэй байдлыг хангаан ажилласан. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 190 | **2022_469. Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай / 2022-12-21 /** | 4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт зохих нэмэлт, өөрчлөлтийг тусган боловсруулж, батлуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай. | Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт өөрчлөлт оруулж, төслийг боловсруулан 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/435 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүдээс санал авахаар хүргүүлсэн. | 70% | |
| **6Ё.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 191 | **2021_14. 2021 оны3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл / 2021-03-03 /** | XII.2.2. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлын төлөвлөгөөг баталж, үндсэн чиглэлд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан дараах хууль тогтоомжийн төслийг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Үүнд:<br>1. Олон Улсын Иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 50 дугаар зүйлийн 50(а) хэсэгт өөрчлөлт оруулсан протоколыг соёрхон батлах тухай<br>2. Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 56 дугаар зүйлд өөрчлөлт оруулсан протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслүүдийг өргөн мэдүүлсэн. Хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан Иргэний нисэхийн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/261 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг хуулийн төсөл, үзэл баримтлал, холбогдох судалгааг шинэчилсэн. Хуулийн төслийг ЗТХЯ-ны | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | www.mrtd.gov.mn болон ИНЕГ-ын www.mcaa.gov.mn сайтад 2022.11.16-ны өдөр байршуулж, цахимаар санал авсан. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг хамтран батлахаар 2022.11.14-ний өдрийн 01/5235 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлснийг 2022.12.15-ны өдрийн 1/6329 тоот бичгээр батлан ирүүлсэн. Хуулийн төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авахаар 2022.01.18-ны өдрийн 01/252 тоот албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 192 | **2021_48. 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр 48 дугаар тэмдэглэл / 2021-08-25 /** | XYI.5. . Улсын Их Хурлын 2021 оны 75 дугаар тогтоолоор батлагдсан Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал болон Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын явцын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын тогтоолд заасан хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, 2021 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Монгол Улсын Их Хурлын 2021 оны 75 дугаар тогтоолоор тус салбарын дараах 3 хууль тогтоомжийн төсөл хэлэлцүүлэгдэхээр батлагдсанаас дараах 2 хуулийн төслийг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Үүнд:<br>1. Олон Улсын Иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 50 дугаар зүйлийн 50(а) хэсэгт өөрчлөлт оруулсан протоколыг соёрхон батлах тухай<br>2. Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 56 дугаар зүйлд өөрчлөлт оруулсан протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслүүдийг өргөн мэдүүлсэн.<br>3. Иргэний нисэхийн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/261 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг хуулийн төсөл, үзэл баримтлал, холбогдох судалгааг шинэчилсэн. Хуулийн төслийг ЗТХЯ-ны www.mrtd.gov.mn болон ИНЕГ-ын www.mcaa.gov.mn сайтад 2022.11.16-ны өдөр байршуулж, цахимаар санал авсан. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | төслийн үзэл баримтлалыг хамтран батлахаар 2022.11.14-ний өдрийн 01/5235 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлснийг 2022.12.15-ны өдрийн 1/6329 тоот бичгээр батлан ирүүлсэн. Хуулийн төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авахаар 2022.01.18-ны өдрийн 01/252 тоот албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 193 | **2022_11. 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл / 2022-02-16 /** | XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав. | Төрийн бүтээмжийг сайжруулах зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа улам боловсронгуй болгож, цаг хугацаа, зардал хэмнэсэн, үр ашигтай ажиллахад анхааран тус салбарын 17 үйлчилгээг E-Mongolia болон яамны цахим хуудсан дахь тусгай зөвшөөрөл, шагналын цэсээр дамжуулан аж ахуйн нэгж иргэдэд тухай бүр үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн.<br>Тус яамны цахим хуудсанд Онлайн үйлчилгээ буланд салбарын 22 үйлчилгээг нэвтрүүлсэн байна. Нээлттэй өгөгдлийн системд салбарын 32 өгөгдөл оруулж, Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан. | 100% | Хэрэгжсэн, Засгийн газрын 2022 оны 27 дугаар тэмдэглэлээр дараагийн шатны үүрэг өгөгдсөн тул хяналтаас хасуулах |
| 194 | **2022_22. 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр 22 дугаар тэмдэглэл / 2022-04-13 /** | XYIII.3.3. Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд харгалзан үзэх боломжтой ажил хэрэгч саналыг судлан бодлого, шийдвэр гаргахдаа авч үзэж, иргэдийн санал, хүсэлтийг хуульд заасны дагуу эцэслэн шийдвэрлэж байхыг Засгийн газрын гишүүдэд. | Төмөр замын суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч ганцхан байсан бол өнөөдөр суурь бүтэц эзэмшигч 4, тээвэрлэгч 4, суурь бүтэц барих, угсрах эрх бүхий 253, дагнасан болон салбар зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч 250 орчим болж нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын их хуралд өргөн мэдүүлсэн. | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| 195 | **2022_27. 2022 оны 5 дугаар сарын 4-ний** | XYIII.2.13. Төрийн хүнд суртлыг арилгах, авлигаас ангид байх, төрийн үйлчилгээг иргэдэд | Төрийн хүнд суртлыг арилгах, авлигаас ангид байх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **өдөр 27 дугаар тэмдэглэл / 2022-05-04 /** | шуурхай хүргэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэхэд онцгой анхаарч, шаардлагатай арга хэмжээг авч тухай бүр нь хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | хүсэлтийг шуурхай шийдвэрлэхэд онцгой анхаарч, дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд: 1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг салбарын 3 байгууллагад шалган, холбогдох зөвлөгөөг өгсөн. 2. Салбарын шагнал урамшуулал болон тусгай зөвшөөрлийн материалыг цахимаар авдаг болсон. 3. Салбарын 17 үйлчилгээг иргэд E-Mongolia хуудсаар дамжуулан авах боломжтой болсон. 4. 11-11 төвд ирсэн гомдлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. 5. Яамны цахим хуудасны Онлайн үйлчилгээ цэсээр салбарын 27 үйлчилгээг авах боломжтой. 6. Засгийн газрын 232 дугаар тогтоолын жагсаалтаар баталсан зам, тээврийн салбарын 34 өгөгдөл бүгд Нээлттэй өгөгдлийн системд орсон. | | |
| 196 | **2022_28. 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл / 2022-05-11 /** | XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн | Тус яамны 134 албан хаагчид албаны тоон гарын үсгийг 2022 оны 03 сард шинэчилж авсан ба албан бичгээ цахимаар шилжүүлж хэвшсэн. Мөн УБЕГ-ын төлөөлөл тус яаманд 2022 оны 05 сард хувь хүний тоон гарын үсгийг яамны 82 албан хаагчид авсан байна. УБЕГ-тай хамтран яамны цахим гарын үсэг аваагүй албан хаагч нарт 2022 оны 07 сард иргэний тоон гарын үсгийг олгож, цахим үнэмлэхтэй холбож өгөв. Яамны нийт албан хаагч нарт албаны тоон гарын үсгийн сертификатыг ҮДТ-өөс авч өгсөн. Тоон гарын үсгийн хэрэглэх хэрэглээний талаар ШУТИС-ын доктор, профессор Т.Халтар сургалт зохион байгуулсан. Тус яам 2022 оны 12 сард "Албан бичиг дундын систем DocX" холбогдсон ба төрийн бусад байгууллагатай цахим гарын үсэг буюу тоон гарын үсэг бүхий албан бичиг солилцох бүрэн боломжтой болсон. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | | | |
| 197 | **2022_28. 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл / 2022-05-11 /** | XX.11.2. 1. Үйл ажиллагааны дүнгээр доогуур үнэлгээ авсан Соёлын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Архангай, Говь-Алтай, Баянхонгор аймаг гарсан алдаа дутагдлаа засах талаар тодорхой ажил зохион байгуулж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэн гүйцэтгэлийг эргэн тайлагнахыг холбогдох Засгийн газрын гишүүн, Засаг дарга нарт үүрэг болгов; | Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоомж , тогтоол шийдвэр болон Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилтийг дүгнэсэнтэй холбогдуулан хэрэгжилт хангалтгүй дүгнэгдсэн арга хэмжээг яамны нэгжүүдэд хүргүүлсэн. Үүний дагуу Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан арга хэмжээнээс зорилтот түвшинг бууруулах, хугацааг хойшлуулах шаардлагатай төслийн саналаа боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд 2022.12.16-ны өдрийн 01/5835 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 70% | |
| 198 | **2022_34. 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл / 2022-06-22 /** | XII.9. . Монгол Улсад олон улсын хуурай боомт байгуулах талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт даалгав: 1.1. Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын хооронд байгуулсан “Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т заасан олон улсын хуурай боомт байгуулах шалгуурыг хангах байршлыг тодорхойлж, боомт байгуулах чиглэлээр эрчимтэй | 1.1. Гадаад харилцааны яамны Хөрөнгө оруулалтын судалгааны төвөөс НҮБ-ын АНДЭЗНК-ийн Зүүн, Зүүн-Хойд Азийн бүсийн офистой хамтран Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсад олон улсын чанартай хуурай боомтыг хөгжүүлэх судалгаа, техникийн үнэлгээ болон бодлогын зөвлөмж боловсруулах төслийг хэрэгжүүлж эцсийн тайлангийн төслийг боловсруулж холбогдох газруудаас санал авч эцсийн тайланг хүлээлгэн өгөөд байна. ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022.12.02-ны өдрийн А/157 дугаар тушаалаар Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд "Хувийн хэвшлийн оролцоогоор дамжуулан олон улсын худалдаа, логистикийг бэхжүүлэх, Замын-Үүд дэх Хуурай боомтын урьдчилсан ТЭЗҮ" боловсруулах зөвлөх | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ажиллах; 1.2. Хуурай боомтын асуудал хариуцсан нэгжийг зохих журмын дагуу байгуулж, Зам, тээврийн хөгжлийн яамны батлагдсан төсөвт багтаан ажиллуулах арга хэмжээ авах. | үйлчилгээний төслийг дэмжиж ажиллах Ажлын хэсэг байгуулагдсан. 1.2. Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа Далайн захиргаа УТҮГ-ын бүтэц, орон тоог шинэчлэн Хуурай боомтын нэгж буюу 5 орон тоог нэмж тусган Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/33 дугаар тушаалаар "Далайн захиргааны бүтэц, дүрэм, орон тооны хязгаар батлах тухай дүрэм, бүтэц"-ийг батлуулсан. | | |
| 199 | | XII.9.2. Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэд Хуурай боомтын асуудал хариуцсан нэгж байгуулахтай холбогдуулан Ерөнхий сайдын 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 104 дүгээр захирамжаар байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, олон улсын хуурай боомт байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж танилцуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгав. | Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэд Хуурай боомтын асуудал хариуцсан нэгж байгуулахтай холбогдуулан Ерөнхий сайдын 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 104 дүгээр захирамжаар байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэхэд орж ажиллах албан хаагчдын нэрийг 2022-09-29-ны өдрийн 01/4469 тоот албан бичгээр ЭЗХЯ-д хүргүүлсэн. Засгийн газрын тухай хуулийн 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргатай байхаар хуульчлагдсан тул хуурай боомтын асуудлыг тус сайд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэнэ. | 100% | Засгийн газрын тухай хуулийн 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргатай байхаар хуульчлагдсан тул хуурай боомтын асуудлыг тус сайдтай болсон тул хяналтаас хасуулах |
| 200 | **2022_36. 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 36 дугаар тэмдэглэл / 2022-07-05 /** | XX.9. . “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгасан логистикийн төвийн байршлын талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан уг асуудлыг хамтран боловсруулж Засгийн | Эдийн засаг, хөгжлийн яамны холбогдох албан тушаалтан нартай уулзалт хийж, Логистикийн төвийн 69 байршлыг эцэслэн тогтоосон. ЭЗХЯ эцсийн танилцуулгыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Монгол Улсын тээвэр логистикийн төвийн байршлыг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлд тусгаж батлуулна. | 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | газрын хуралдаанаар дахин танилцуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгав. | | | |
| 201 | **2022_39. 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл / 2022-08-03 /** | XYIII.3.11. Хөгжлийн төслүүдийн хэрэгжих байршил, төслийн нийт төсөвт өртөг, санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд, техник, эдийн засгийн үндэслэл, ажлын зураг, газар, байгаль орчны үнэлгээ, дэд бүтэц, төслийн хүрээнд барьж байгуулах барилга байгууламж, бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээ, зах зээлийн төлөв байдал болон холбогдох судалгаа, шинжилгээний мэдээлэл бүхий танилцуулгыг англи хэл дээр бэлтгэн 2022 оны 8 дугаар сард багтаан Гадаад харилцааны яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд; | ЭЗХЯ-нд Иргэний нисэхийн салбарын 3 төслийн танилцуулгыг англи хэлээр орчуулан хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 39 дүгээр хуралдааны тэмдэглэлийн 1.11 дэх хэсэгт даалгасны дагуу 2021 оны 106 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтын 1.1-т тусгагдсан Гашуунсухайт-Ганцмод хил холболтын төмөр замын төсөл, Тавантолгой-Цогтцэций өртөө холболтын төмөр замын төсөл, мөн 1.6-д тусгагдсан Гашуунсухайт шилжүүлэн ачих терминалыг байгуулах төсөл, 1.2-т тусгагдсан Эрээнцав-Баянтүмэн чиглэлийн төмөр зам, Сүхбаатар-Замын-Үүд чиглэлийн төмөр замын төв коридорыг хос замтай болгох төсөл, 1.3-т тусгагдсан Чойбалсан-Хөөт-Бичигт, Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Арцсууръ-Нарийнсухайт-Шивээхүрэн, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслүүдийн ерөнхий мэдээлэл, техник, эдийн засгийн үзүүлэлт, байршил, ач холбогдол, төсөвт өртөг зэрэг мэдээллийг агуулсан PPT танилцуулгыг англи хэл дээр боловсруулж, тус яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсээр хянуулж байна. | 70% | |
| 202 | **2022_41. 2022 оны 8 дугаар сарын 17-ны** | YIII.6. . “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн | 1.1. УБ-Дархан чиглэлийн 202.4 км авто замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2022.10.30-ны өдөр нээж, хэвийн нэвтрүүлж байна. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **өдөр 41 дүгээр тэмдэглэл / 2022-08-17 /** | явцыг 2022 оны хагас жилийн байдлаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох агентлагийн дарга нарт тус тус даалгав: 1.1. Удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байгаа зорилт, арга хэмжээг жилийн эцсийн зорилтот түвшинд хүргэх; 1.2. Санхүү, хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан эхлээгүй байгаа төсөл, арга хэмжээг улсын төсвөөс гадна гадаадын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар хэрэгжүүлэх боломжийг судлан, шийдвэрлэх; 1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэх; 1.4. Улсын Их Хуралд энэ онд өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн хууль | 1.2. ЗГҮАХ-т тусгагдсан Орон нутгийн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг БХБ-ын сайд (ТЕЗ)-ын төсвийн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улсын хэмжээнд)”-т тусган санхүүжилтийг шийдвэрлэх хүсэлт Сангийн яаманд хүргүүлсэн. (2022.10.04-ний 01/4549) Төслийг концессын зүйлийн "Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид шилжүүлэх ажлын даалгавар боловсруулж байна. Мөн “Жайка” ОУХАБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улсын Хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Дорнод аймгийн “Чойбалсан” нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгон хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийн нисэхийн бус орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран судалгаа хийж байна.<br>1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж 2022.08.12-ны өдрийн 01/3688 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>1.4. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2 хуулийн төслийг УИХ-д 2023.01.10-ны өдөр өргөн барьсан. / "Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол"-ыг соёрхон батлах тухай хуулийн | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар нэн даруй хэлэлцүүлж, өргөн мэдүүлэх. | төсөл, тус конвенцийн 56 дугаар зүйлийн б) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол/ | | |
| 203 | **2022_41. 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл / 2022-08-17 /** | YIII.7. . “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний биелэлтийн явцыг 2022 оны хагас жилийн байдлаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагийн дарга нарт тус тус үүрэг болгов: 1. Биелэлт нь хангалтгүй байгаа 32 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж жилийн эцсийн зорилтот түвшинд хүргэх шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 2. Төсөл, арга хэмжээний биелэлтийг зарцуулсан хөрөнгийн хэмжээ, шалгуур үзүүлэлтийг хангасан байдал, хүрсэн үр дүн зэргийг тодорхой тусгаж бүрэн тайлагнаж байх. | 2. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд 3 зорилтыг хэрэгжүүлэх 38 арга хэмжээний хэрэгжилтийг зарцуулсан хөрөнгийн хэмжээ, хүрсэн үр дүнгийн талаар тодорхой тусган, ЗГХЭГ-т 2022.12.30-ны өдөр тайлагнасан. 1. Биелэлт хангалтгүй 32 төсөл, арга хэмжээнээс тус яамд хамаарах 3 /Чойбалсан, Мөрөн, Ховд/ нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх хүрээнд Концессын тухай хуулийн 4.2-д заасны дагуу “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д орон нутгийн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг “Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлт ЭЗХЯ-нд 2022.01.26-ны 01/395 тоотоор хүргүүлсэн. | 100% | |
| 204 | **2022_45. 2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр 45 дугаар тэмдэглэл / 2022-09-14 /** | ХХ.4.2. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгын тодорхой хэсэгт байршуулахтай холбоотой тооцоо, судалгааг хийж, нүүлгэн | Мэдээллийн аюулгүй ажиллагааны танилцуулгыг бэлтгэж 2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр ЦХХХЯ-нд биечлэн танилцуулж, тус яамны дэд сайдтай уулзалт хийсэн. ТӨБЗГ-ын даргын 2022 оны “Дэд ажлын хэсэг байгуулах тухай” А/56 дугаар тушаалаар уг ажлыг зохион байгуулах, нисэх буудлын барилгын зориулалтыг өөрчлөх, технологийн шийдэл гаргах чиг үүрэг бүхий дэд | 70% | Цахим хөгжил, харилцаа холбооны яам нууц шийдвэрээ гарган нүүсэн тохиолдолд бүрэн хэрэгжих ба тус яамнаас шалтгаалах ажил бүрэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Иргэний нисэхийн ерөнхий газар (С.Мөнхнасан), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав; | ажлын хэсэг ажиллаж, хэмжилтийн зураг, санал дүгнэлтээ 2022.10 дугаар сард ЦХХХЯ-ны ТНБД Ч.Золбаяр, ТӨБЗГ-ын дарга Б.Цэнгэлд тус тус танилцуулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яам нүүлгэн шилжүүлэх эсэх шийдвэрээ гаргасан тохиолдолд холбогдох бэлтгэл ажил хангагдсан. | | хийгдсэн тул хяналтаас хасуулах |
| 205 | **2022_48. 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр 48 дугаар тэмдэглэл / 2022-10-05 /** | XII.1.2. Дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 2.1. Эрхлэх асуудлын хүрээнд стандарт, техникийн зохицуулалтын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; 2.2. “Үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 235 дугаар тогтоолын хэрэгжилтийг дүгнэж, салбарын шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг 2022 онд багтаан боловсруулж, батлуулахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд; | “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг 1-р хэсэг Ерөнхий шаардлага” MNS4410-1:20021 стандартад “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд хар хөх өнгийн дэвсгэртэй дугаар олгох” нэмэлт өөрчлөлтийг Автотээврийн стандартын техникийн хорооны 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хэлэлцэн батлав. | 100% | Шаардлагатай зохицуулалтыг батласан тул хяналтаас хасуулах |
| 206 | **2022_48. 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр 48 дугаар тэмдэглэл / 2022-10-05 /** | XII.3.2.4. Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авч, 2022 оны 10 дугаар сард багтаан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн | Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж мэдээллийг ЗГХЭГ-т 2022.11.15-ны 02/5255 тоот албан бичгээр хүргүүлсэн. Зөвшөөрлийн харилцааг зохицуулж буй захиргааны хэм хэмжээний актын жагсаалтыг гаргасан. Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн Авто замын тухай хууль, Автотээврийн тухай | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, төрийн болон нутгийн захиргааны байгууллагад. | хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж ЗГХЭГ-т 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 01/5137 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан. | | |
| 207 | **2022_54. 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл / 2022-11-09 /** | X.11.2. "Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем"-ийг байгууллагын үйл ажиллагаанд уялдуулан зохион байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллахыг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч нарт; | Тус яамны зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд Тээврийн Прокурорын газар хяналт тавидаг ба "Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем"-ийн талаар Тээврийн Прокурорын газраас эрх нээж, зааварчилгаа өгөөгүй байна. Уг системийг ашиглахад ямар нэгэн нэмэлт тоног төхөөрөмж суурилуулах шаардлагагүй болно. | Хугацаа болоогүй | Уг системийг ашиглахад зөвхөн эрх бүхий албан тушаалтанд нэвтрэх нэр өгөх бөгөөд нэмэлт тоног төхөөрөмж шаардлагагүй тул хяналтаас хасуулах |
| 208 | **2022_58. 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл / 2022-12-07 /** | XXI.1.2. Гадаад валютын нөөц бүрдүүлэх чиглэлээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүд санаачилгатай ажиллах, валютын гарч буй урсгалыг бууруулах зорилгоор шаардлагагүй худалдан авах ажиллагаа болон гадаад томилолтыг хориглох, төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баяр тэмдэглэхгүй байх, орон тоог бууруулах, урсгал зардлыг хэмнэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, тэдгээрийг томилох эрх бүхий этгээдэд; | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу Засгийн газрын 2022.11.30-ны өдрийн хуралдаанаас гарсан 57 дугаар тэмдэглэлийн хүрээнд 2022 онд яам болон салбарын 10 байгууллага албан ёсны баяр/шинэ жил/ зохион байгуулаагүй болно. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3 дахь заалтын дагуу худалдан авах ажиллагаа болон гадаад томилолт, урсгал зардлыг хэмнэх чиглэл баримтлан ажиллаж байна. | 100% | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг даган мөрдөж, төсвийн зарцуулалтад Сангийн яам хяналт тавин ажиллаж байгаа тул хяналтаас хасуулах. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 209 | | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | "Албан бичиг солилцооны дундын систем DocX"-д тус яам 2022 онд холбогдож бусад төрийн байгууллагуудтай шууд бичиг солилцох боломжтой болсон. | 100% | хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| 210 | **2022_62. 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 60 дугаар тэмдэглэл / 2022-12-21 /** | XYI.1. . “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийн явцын талаар Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хөгжлийн төслүүдийн судалгаа, тооцооллыг хийж, эдийн засгийн болон нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтаас хасах шаардлагатай төслийн саналаа тодорхой үндэслэл, судалгаатай боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд | “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хөгжлийн төслүүдийн судалгаа, тооцооллыг хийж, эдийн засгийн болон нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлэн, төслийн жагсаалтаас хасах шаардлагатай төслийн саналаа боловсруулж 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/5835 тоот албан бичгээр ЭЗХЯ-д хүргүүлсэн. | 100% | хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хүргүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгав. | | | |
| 211 | **2022_4. Чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай / 2022-07-05 /** | 7. Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт: 1.1. Зөвхөн чөлөөт бүс рүү хөнгөлөлттэй нөхцөлөөр тээвэр хийх нөхцөлийг бүрдүүлэх, логистикийг нэмэгдүүлэх; 1.2. Баруун бүсийн олон улсын АН-4 чиглэлийн автозамын үр нөлөөг дээшлүүлж транзит тээврийг хөгжүүлэх, Цагааннуур чөлөөт бүсэд тээвэр логистикийн төв байгуулах боломжийг судалж танилцуулах. | 1.1. Алтанбулагийн логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах төслийг БНСУ-ын KOTRA-тай хамтран хэрэгжүүсэн. БНСУ-ын Зөвлөх баг төслийн эцсийн шатны тайланг 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдөр хэлэлцүүллээ. 2022 оны 10 дугаар сард эцэслэн хүлээн авахаар төслийн ажлын удирдамжид тусгагдсан. Замын-Үүдийн чөлөөт бүсийг Эрээний чөлөөт бүстэй автомат удирдлага бүхий тээвэр буюу AGV-ээр холбох ТЭЗҮ-г хийлгэсэн. Чөлөөт бүс рүү нэвтрэх тээвэрлэлт хэвийн явагдаж байна. 1.2. Баруун бүсийн олон улсын АН-4 буюу Ховд, Баян-Өлгий аймгуудад ОХУ-ын хилийн боомтоос БНХАУ-ын хилийн боомттой холбогдох /Азийн авто замын АН-4/ баруун босоо тэнхлэгийн 745 км авто замыг бүрэн ашиглалтад орууллаа. 1.3 Засгийн газрын 2022 оны 11 сарын 23-ны өдрийн хуралдаанаар Цагааннуур чөлөөт бүсийн тухай Эдийн засгийн хөгжлийн сайд танилцуулж, 412 дугаар тогтоолоор Цагааннуур чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд оруулахаар шийдвэрлэсэн. | 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |
| **63.Засгийн газрын албан даалгавар** | | | | | |
| 212 | **2022_5. Цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай / 2022-07-05 /** | 4. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт: 1.1. Замын тэмдэг, тэмдэглэгээг олон улсын стандартын дагуу хийх, Замын хөдөлгөөний дүрмийг чангатгах | 1.1. Замын тэмдэг, тэмдэглэгээг батлагдсан стандартын дагуу гүйцэтгэж 2022 онд дараах авто замуудыг ашиглалтад оруулсан байна. Үүнд:<br>- Чингис хот - Дадал сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 50 км,<br>- Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Хөвсгөл, Цагаан-Уул сум/<br>- Улаанбаатар хотод хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ: Баянгол дүүрэг-Багц-1-3;<br>-Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй хорооны | 100% | хэрэгжсэн тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | чиглэлээр өөрчлөх арга хэмжээ авах; 1.2. Монгол Улсын 21 аймаг, сумдын авто замын сүлжээг холбосон газрын орон зайн мэдээлэл бүхий Жи Пи Эс /GPS/ системтэй болох, замын мэдээлэл, зам засвар, хөдөлгөөний түгжрэл, дэд бүтэц, замын дагуух үйлчилгээний төв, шатахуун түгээх станцын байршил зэргийг мэдээллийн нэгдсэн системд бүрэн оруулах арга хэмжээ авах. | доторх авто зам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг 13 дугаар хороо/`. -БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто зам; -Баруун босоо тэнхлэгийн авто төслийн Багц 1-4 Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км авто зам - Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн. 1.2. Геодези зураг зүйн газрын хөгжүүлсэн Үндэсний орон зайн мэдээллийн систем, "ЗТХТ" ТӨҮГ-ын хөгжүүлж байгаа Авто замын орон зайн мэдээллийн систем, Ай си ти групп ХХК-ийн хөгжүүлсэн "imap" болон бусад GPS навигацийн системүүдийг ашиглах, боломжууд одоогоор байна. Яамны зүгээс ТХХТ-ийн хүрээнд жолооч нарт зориулсан ToGo app хөгжүүлсэн “Media idea Consulting” LLC-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулж ОЗМС дээр суурилсан тээврийн хэрэгслийн мэдээлэл, замын эвдрэлийн мэдээлэл, замын засвар, хөдөлгөөний түгжрэл, дэд бүтэц, замын дагуух үйлчилгээний төв, шатахуун түгээх станцын байршил зэргийг жолоочид харуулах боломж бүрдсэн. | | |
| 213 | | 7. Албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай бол Ажлын хэсэг байгуулж ажиллах, биелэлтийг Төрийн бүтээмжийн болон Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах, авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороодын хуралдааны тус тус хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Үндэсний хороо (Орлогч | Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2022.09.14-ний хуралдаанаар Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. МУ сайд, Нийслэлийн түгжрэлийг бууруулах үндэсний хорооны даргаас ирүүлсэн УИХ тогтоолын төсөлд 2022.11 сард холбогдох саналыг хүргүүлсэн. Мөн Ерөнхий сайдын 2022 оны 10 сарын 157 дугаар | 70% | Хот хөдөөгийн сэргэлтийн дарга Батлан хамгаалахын сайд болон УЛаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга нарт шилжүүлэх, тус яамны чиг үүрэг шууд хамааралгүй тул хяналтаас хасуулах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дарга Л.Энх-Амгалан, Л.Халтар)-нд даалгасугай. | захирамжаар Хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд ажиллах Батлах хамгаалахын Дэд Сайдаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулсан. | | |
| 214 | **2022_6. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай / 2022-07-05 /** | 1. 1.1. ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харьяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2.""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах; | Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-ын талаарх сургалтад Удирдлагын академитай хамтран 2022.09.23-24-ний өдрүүдэд салбарын 96 албан хаагч хамрагдсан. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Төмөр замын салбарт хэрэгжиж буй бүтээн байгуулалтын талаар видео шторк бэлтгэн олон нийтэд түгээсэн. https://mrtd.gov.mn/i/3026 Баруун бүсийн босоо тэнхлэгийн Азийн авто замын сүлжээ АН-4 зэрэглэлийн олон улсын чанартай 745 км авто замын талаар англи хэл дээрх танилцуулга видеог 2022 оны 10 сард олон нийтэд хүргэсэн болгосон. Тус яам "Зам, тээврийн хөгжлийн яам" гэсэн албан ёсны цахим хуудасаар дамжуулан өдөр бүр олон нийтэд тээврийн салбарт хийгдсэн ажлын талаар контент, мэдээ бэлтгэн тухай бүр олон нийтэд тайлагнан ажиллаж байна. | 100% | |

---o0o---